

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY



Грек болох бас  
болохгүй байх “шалгуур”

“Тэжээгчээ хянадаг  
тэжээлгүүлэгч байдаг юм уу”

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл


2013. 10 сар. №19 (053)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)



Нэрт эдийн засагч  
Ханс-Вернер Зинне

**ЗЭЭЛЭЭ БАГАСГА, ӨӨРСДИЙН  
ХҮЧЭЭР УЛСАА ХӨГЖҮҮЛ**






Since 2001

# AIRLINK

EXPERTS IN AIRWAYS

Та ЭЙРЛИНК ОНЛАЙН ОНГОЦНЫ БИЛЕТИЙН КАСС  
гар утасны аппликейшныг ашиглан  
**ОНГОЦНЫ ТИЙЗЭЭ ЗАХИАЛААРАЙ**



Та өөрийн гар утасны аппликейшн татах Play store, Market (Android) Apple store (I Phone) хэсэгт Airlink гэж оруулан хайлтыг эхлүүлэхэд Airlink  гарч ирэх ба уг программыг гар утсан дээрээ татаж суулгана.



Available



Available

Available

Суулгасан аппликейшнруу нэвтрэн орж захиалга өгөх салбар, ажилтнаа сонгон захиалгаа өгөөрэй.

Вэб: [www.airlink.mn](http://www.airlink.mn) Facebook: Airlink1818

УТАС: 70101838, 99902857



# VERTUL

OFFICE FURNITURE - ART GALLERY

Италийн DOIMO группын  
албан тасалгааны тавилгыг  
албан ёсны эрхтэйгээр  
нийлүүлж байна.



*Өөрийгөө хүндэлдэг  
танд зориулав.*



## DOIMO

- Албан тасалгааны тавилга
- Уран зургийн галлерей

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их Сургуулийн гудамж 31/1, PC mall

**Утас: 7011-3535, 9903-7487**

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав /9409-2904/

Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,  
Их сургуулийн гудамж. AV center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

## IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

### УТАС: 70115476

## ОНЛАЙН СЭТГҮҮЛЭЭ

<http://mongolianeconomy.imedia.mn/>

### ХАЯГААР ЗАХИАЛНА УУ

Less Noise Means  
Better Music

## Noise Cancelling Headphones

Кино болон дууны илүү тэнцвэртэй, илүү нарийвчилсан дуугаралтыг танд хүргэнэ. BOSE-ын Noise Cancelling технологи нь танд дуу болон киног гадаад орчиноос хамааралгүйгээр сонсох боломжийг олгож байна.

Сүхбаатар дүүрэг, Их Сургуулийн гудамж 31/1, PC mall  
Саммит Компьютер Технологи ХХК, Улаанбаатар-14193, Монгол улс



7011-3535



Visit us:  
[www.pc-mall.mn](http://www.pc-mall.mn)



Join us on Facebook  
<http://www.facebook.com/PCmallOfficial>

**BOSE**<sup>®</sup>  
Better sound through research<sup>®</sup>

## ЭДИЙН ЗАСАГ

- 10** Грек болох бас болохгүй байх “шалгуур”
- 12** “Бүү зээл, харин хадгал”
- 14** GIPSIC+Монгол?
- 16** Зах зээл өөрөө шийдэг
- 18** Тэдний сонирхол
- 20** Салхи хагалагчдаас итгэл эхэлнэ



## БАНК, САНХҮҮ

- 23** Хөрөнгө “шанагадах” боломж
- 25** Доголон тогтолцоо
- 28** Д.Цэвээнжав: Жолоочийн даатгал санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалсан хохирогчгүй даатгал

## УУЛ УУРХАЙ

- 32** Давтах эрхгүй, алдах ёсгүй
- 35** Даацтай хөгжил, давхар дэмжлэг



## БИЗНЕС

- 37** “Тэжээгчээ хянадаг тэжээлгүүлэгч байдаг юм уу”
- 41** “Бүгдээрээ хямрал яриад эхлэхээр хямралаас гарч эхэлдэг”
- 46** Түр зуурын давуу тал

## ОНЦЛОХ

## ДУУЛИАН ШУУГИАНЫ ДАРААХ ЭДИЙН ЗАСАГ

## Б.ҮҮРИЙНТУЯА

Зуны зугаатай өдрүүд дуусах, ажил төрөл эрчимжих үеэр толгойтой бүхэн эдийн засагч болж, амтай бүхэн ам.долларын тухай шуугилаа. Аз болж ханшийн оргилд нэг их удаагүй тус дэвсгэртийн чангарал намжих төлөвтэй байгаа нь сайн хэрэг. Гэсэн ч ахархан хугацаанд монголчуудыг чангалаад авсан ам.долларын алдуурсан ханш бизнес эрхлэгчдийн хувьд гүн “шарх” үлдээлээ.

Манайх шиг түүхий эдийн валюттай орон ханшийн хэлбэлзэл, түүнээс гарах эдийн засгийн хүндрэлүүдэд хэр дархлаатай болохыг харуулсан дээрх үйл явдал Монголын төр, засгийг эдийн засаг хийгээд нийгмээр нь түгшээж дөнгөв. Эдийн засагчид болоод санхүүгийн мэргэжилтнүүд валютын ханшид Төвбанк оролцох гэж оролдох нь буруу. Аль болох ханшийг зах зээлд нь даатгаад орхих хэрэгтэй гэж үзэх нь их байсан. Харин Монголбанкны ерөнхийлөгч саяхан үйлдвэрлэгчдэд хандаж, “Бид валютын ханшид интервенц хийх гэж оролдоогүй. Эдийн засаг хямарч магадгүй үед тогтвортой ажлын байраа авч үлдэх, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн бодлого явуулсан нь үр дүнгээ өглөө. Хөрөнгө оруулалт эрс хумигдчихсан, ханшийн савлагаатай үед Төвбанк зөв бодлого явуулаагүй бол эдийн засаг үүнээс ч хүчтэй унах байсан. Монголын эдийн засгийн хамгийн хүнд хэцүү үе ард хоцрох шиг боллоо” хэмээн мэдэгдсэн.

Өнгөрсөн сар Монгол Улсын хувьд хурал, цуглаанаар амьсгалсан завгүй өдрүүдээр дүүрэн байлаа. Уул уурхайн салбарт дэлхийн зах зээл хатуурхаж байгаа нь ашигт малтмал суурьтай Монголын эдийн засгийг барьц алдахад хүргэсэн гэж болох. Монголын уул уурхайн үйлдвэрлэлийн гол нийлүүлэгч болох урд хөрш “Манай эдийн засаг сулхан байна. Монголчууд минь учраа өөрсдөө ол” гэсэн шиг авирлаад удаж байна. Мөн өнгөрсөн сард Монголын төдийгүй дэлхийн уул уурхайнхан цугладаг гэж болох “Discover Mongolia” чуулганы 11 дэх хуралдаан сайнтай, муутай гэхээсээ илүү зочид, гийчид багатай болж өнгөрөв. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчид манайхыг шохорхохоо байчих шиг боллоо гэсэн дохиог тод гэгч нь өгөв үү гэлтэй. “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэдэгчлэн гаднын хөрөнгөтнүүд улс доторхоо тууштайхан цэгцлэ хэмээн бидэнд хэлэх шиг. Үүний зэрэгцээ мөнөөх урт нэрээрээ алдартай хуулийг хэлэлцэх асуудал өрнөж байх үед Төрийн ордны ойролцоо буун дуу хүртэл гарсан нь тулга тойрсон маргаанаа монголчууд нэг тийш болгохгүй бол горьгүй болсныг гэрчиллээ.

Улс дотроо ийн бужигнаж байхад алс тивийн Герман

улсаас дэлхийн топ эдийн засагчдийн нэг, Германд төдийгүй дэлхийд нэртэй “Ifo” хүрээлэнгийн ерөнхийлөгч, профессор Ханс-Вернер Зинн манай улсад бараг долоо хоног саатсан юм. Тэрбээр МУИС-ийн Эдийн засгийн сургууль болон Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан “UB Impulse II: Чанартай өсөлт” сэдэвт олон нийтийн лекц, хэлэлцүүлэгт оролцон өр тавьж, үрэлгэн загнаж буй Монголын Засгийн газарт хандан үнэтэй зөвлөгөө өгсөн. Асуудал гарвал бонд нэрээр гадаад өрөө зузаатгаж буй манай улсын Засгийн газар валютын зээлээ хүний хөгжил, үндэсний брэнд гэх мэтээр үр ашиггүй зарцуулах нь төв Азийн цээжинд орших Монгол биш Грекийн араас орж болзошгүй тухай профессор Зинн дээрх лекцийн үеэр сануулсан. Мөн тэрбээр үнэгүй зүйл гэж байдаггүйн адил “Бэлэн бүхэн хоол болохгүй” хэмээн илтгэлийнхээ үеэр онцолсон бөгөөд улс орноо гаднын мөнгөөр бус өөрсдийн хүчээр хөгжүүл хэмээн зөвлөсөн билээ. Түүний илтгэлийн хүрээнд яригдсан олон сэдвийг манай сэтгүүлийн “Грек болох бас болохгүй байх шалгуур” гарчигтай нийтлэлээс уншихын сацуу дэлхийд нэртэй зочны сонирхолтой ярилцлагыг сонирхоорой.

Мөн өнгөрсөн сарын нэгэн тэмдэглэлт үйл явдал бол Монгол Улсын Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуягийн арлын Японд хийсэн айлчлал юм.

Түүний айлчлалын гол тодотгол нь “Самурай бонд” босгох тухай асуудал байв.

Есдүгээр сарын бас нэгэн онцлох үйл явдал нь манай улсад зохион байгуулагдсан Азийн банкуудын холбооны 30 дугаар чуулган байлаа. Монголын банкуудын холбооны зохион байгуулсан эл чуулганаар Азийн, цаашилбал дэлхийн банкны салбар хэрхэн хувьсан өөрчлөгдөж буй, үүнтэй хөгжиж буй орнууд, тухайлбал Монгол Улс хэрхэн хөл нийлүүлэх талаар олон улсын банкируудын хэлэлцсэн асуудлаарх чуулганы дэлгэрэнгүй сурвалжлагыг хүргэж байна.

Манай улсын банк, санхүүгийн салбар өнөөдөр ямар түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа, тус салбарын амин сүнс нь даатгалын сайн тогтолцоо бөгөөд урт хугацааны буюу амьдралын даатгалыг хөгжүүлэх нь санхүүгийн салбарын хэтэд эерэг үзүүлэлт авчирдаг тухай манай сэтгүүлч нийтлэл бичлээ. Түүнчлэн жолоочийн хариуцлагын даатгалын талаар Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжавтай хийсэн ярилцлага танд энэ талын мэдлэг мэдээллийг өгөх болно. Мөн эдийн засаг, бизнесийн бусад сонирхолтой нийтлэл, ярилцлага, илтгэл, зөвлөгөөг “Mongolian Economy” сэтгүүлийн шинэхэн дугаараас аваарай. ■

МОНГОЛД



**Монголд бизнес** эрхлэгчид бараа бүтээгдэхүүний үнийг дунджаар хоёр улирал тутамд өөрчилдөг. Харин Европт дөрвөн улиралд нэг удаа өөрчилдөг аж. Энэ нь Монголын өндөр инфляцитай холбоотой бөгөөд монголчууд өнгөрсөн үеийн инфляциас илүүтэйгээр ирээдүйд хүлээгдэж буй инфляцид илүү ач холбогдол өгдөг

аж. Эндээс харахад инфляцийн зорилтот хэмжээ нь инфляцийн бодит хэмжээнд чухал нөлөө үзүүлдэг. Мөн инфляцийг бууруулахаар зарлах нь бидний төсөөлж байснаас ч илүү эерэг нөлөө үзүүлдэг байна. Хөгжилтэй орнуудтай харьцуулахад Монголын хэрэглээ хэрэглэгчдийн зуршлаар биш, тэдний тухайн үеийн орлогоор тодорхойлогддог талаар Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан “Монголын эдийн засгийн эмзэг байдал” судалгаанд дурджээ.

“**Чингис**” бондын хоёрдогч зах зээлийн хүү долоо орчим хувьд хүрч өсчээ. Бусад улсын ам.доллараар гаргасан бондын хүү ч өсч байгаа аж. Үүний гол шалтгаан нь АНУ-ын эдийн засгийн сэргэлттэй холбоотой гэнэ. Өөрөөр хэлбэл, тус улсын эдийн засаг сэргэхтэй зэрэгцээд ам.долларын өртөг нэмэгдэж байгаа аж. Тиймээс “Чингис” бондын хүү урт хугацаандаа өсөх магадлалтай.

**2013** оны эхний найман сарын байдлаар нийт импортын 45 хувийг үйлдвэрлэлийн орц болон

нефтийн бүтээгдэхүүн, 12 хувийг өргөн хэрэглээ, 3 хувийг хүнсний бараа, үлдсэн 40 хувийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна. Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс зургаан нэгж хувиар буурсан нь нефтийн бүтээгдэхүүний хувийн жин 0.2 нэгж хувиар, үйлдвэрлэлийн орцын хувийн жин 5.6 нэгж хувиар буурсантай холбоотой байна. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь өөрчлөлт багатай, тогтвортой хэвээр байна.

**Алтны** дэлхийн зах зээл дээрх үнэ өнгөрсөн сарын байдлаар нэг унци тутамд 1,395.3 ам.долларт хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 17.5 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх сараас 5.3 хувиар өссөн үзүүлэлт аж. Мөн “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ наймдугаар сарын байдлаар 7,077.5, 1,868.5 ам.долларт тус тус хүрчээ.




**Ашигт** малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурч нийт экспортын 87 хувийг бүрдүүлсэн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 85 хувийг, нийт экспортын 74 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь эдгээр бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 6.3 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 8.6 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

Экспортын барааны өөрчлөлт /сая ам.доллар/

	Тоо хэмжээний өөрчлөлт	Хувь	Үнийн өөрчлөлт	Хувь	Нийт өөрчлөлт	Хувь
Ашигт малтмал	3	242	245			
Чулуун нүүрс	25746	297	54	554	329	
Зэсийн баяжмал	20	394	15	294	5	-3
Төмрийн хүдэр ба баяжмал	1	2	84	98	86	-51
Боловсруулаагүй нефть	87	96	4	4	91	-54
Цайрын хүдэр ба баяжмал	8	110	1	-10	7	-4
Мөнгөжөөгүй алт	143	106	8	-6	134	-80
Жонш, лейцит, нефелит	5	52	4	48	9	5
Молибдений хүдэр ба баяжмал	1	21	4	79	6	3
Ноос ноолуур	22	25	46			
Ямааны ноолуу	20.0	46	23.4	54	43.4	-26
Ямааны самнасан ноолуур	1.7	56	1.3	44	2.9	-2
Бусад	17	56	13	44	31	-18

Эх сурвалж: Монголбанк

Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ /ам.доллар/



Эх сурвалж: Уул уурхайн яам


## ДЭЛХИЙ ДАХИНД

### АНУ



Энэ сарын 17 гэхэд өрийн дээд хэмжээндээ хүрэх төлөвтэй байгаа АНУ-ын Засгийн газар төлбөр, тооцооныхоо тэн хагасыг төлж барагдуулахаас өөр аргагүй болно хэмээн тус улсын Сангийн сайд Жэк Лью сануулав. Тэрбээр зээлийн дээд хэмжээг нэмэгдүүлэхгүй бол тус улс төлбөрийн хариуцлага болох 30 тэрбум ам.долларын өрийн үлдэгдэлтэй болно гэжээ.

### БНХАУ



БНХАУ-ын Засгийн газар хөрөнгө оруулалтын жагсаалтаа шинэчлэн гаргаж, зах зээл дэх хэт их оролцоогоо бууруулах зорилгоор захиргааны журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан талаар өнгөрсөн сарын 25-нд мэдэгдлээ. Тус улсын Ерөнхий сайд Ли Кэчианг тэргүүтэй Төрийн зөвлөлийн хурлаар хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцсэн хэмээн хурлын дараах мэдэгдэлд дурдсан байна.

### Япон

Япон болон АНУ өөрсдийн органик бүтээгдэхүүнээ харилцан импортлох ажлыг хөнгөвчлөх үүднээс хэлэлцээр хийжээ. Японы Хөдөө аж ахуйн байгууллага өнгөрсөн сарын 26-нд хоёр улсын аль нэгэнд нь борлуулах зөвшөөрөл бүхий органик бараа, бүтээгдэхүүнийг нөгөө оронд мөн адил органик бүтээгдэхүүн хэмээн борлуулна гэсэн мэдэгдэл гаргав. Хэлэлцээр ёсоор дахин зөвшөөрөл авах шаардлагагүй аж.

### Герман

Германы бизнесийн сентимент өнгөрсөн наймдугаар сард сүүлийн 16 сард байгаагүй хамгийн өндөр түвшинд хүрчээ. Үүнд аж үйлдвэрийн салбарт гарсан өсөлт

голлон нөлөөлсөн аж. Европын хувьд хамгийн томд тооцогдох тус улсын эдийн засаг энэ оны хоёрдугаар улиралд хүчтэй өссөний дараа ийнхүү улам хүчээ авах болсон байна. Германы Ifo эдийн засгийн судалгааны хүрээлэнгээс гаргасан мэдэгдэлд тус улсын эдийн засаг таамаглаж байснаас илүү өссөн бөгөөд өнгөрсөн оны дөрөвдүгээр сараас хойш дөрөв дэх удаагаа дараалан өссөн сайн үзүүлэлт болсон гэжээ.

### Франц

Франц улсын ажилгүйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд байнга нэмэгдсээр ирсэн бол өнгөрсөн наймдугаар сард 50 мянгаар буурч, 3.23 сая болжээ. 2000 оноос хойш ийм огцом бууралт ажиглагдаагүй аж. Энэ нь

сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд ажилгүйдэл анх удаа буурсан үзүүлэлт хэмээн тус улсын Засгийн газраас мэдэгдсэн байна.

### ОХУ

Дэлхийн банк ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн таамгаа 1.8 хувь болгон бууруулсан нь 2009 оноос хойшхи хамгийн доогуур үзүүлэлтэд тооцогдов. Тус банкны тайлангаас гадна ОУВС болон тус улсын Эдийн засгийн хөгжлийн яамнаас эдийн засгийн өсөлтийн таамгаа мөн бууруулжээ. ОХУ үйлдвэрлэлийн нийт хүчин чадлынхаа 80 хувийг одоогоор ашиглаж байгаа бөгөөд санхүүгийн хямралын өмнөх 2007 оны түвшинтэй адилхан байгаа гэжээ. Гэхдээ тэр үед эдийн засгийн жилийн өсөлт найман хувьтай байв. ■

## А.АМАРСАЙХАНЫ БУЛАН



ЦАГ ҮЕ

# ГРЕК БОЛОХ БАС БОЛОХГҮЙ БАЙХ “ШАЛГУУР”

Б.ТУЯА

Манай Засгийн газар мөнгөтэй болмогцоо Бурханы хишиг аятай тараачихдаг нь нууц биш. Монгол Азийн Грек болох эхний “шалгуур”-т тэнцэх нь энэ. Хөрөнгө оруулалтаар хөгжүүлэх учиртай салбаруудыг өрийн мөнгөөр туйлуулах удаах шалгуурыг мөн л амжилттай давж буй. Гуравдугаарх нь аль нэг салбарыг тэргүүлэх хэмээн өндөрт өргөж, бусад салбарын өрсөлдөх чадварыг булшлах. Ийн өмнөд Европын жишгээр эдийн засгаа хүндрүүлж байгаа монголчуудад бусдын алдаанаас суралцах боломжийг өнгөрсөн сард Улаанбаатар хотноо болсон “UB Impulse II: Чанартай өсөлт” сэдэвт олон нийтийн лекц, хэлэлцүүлэг олгосон билээ. МУИС-ийн Эдийн засгийн сургууль болон Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс, түүхий хөтөлбөр хамтран зохион байгуулсан тус цуврал лекцийн энэ удаагийн хүндэт зочин Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний “Ifo” хүрээлэнгийн ерөнхийлөгч профессор, хүндэт доктор Ханс-Вернер Зинн уригдсан байлаа. Профессор Зинн Германд төдийгүй дэлхийд нэртэй эдийн засагч бөгөөд түүнийг Их Британийн “The Independent” сонин дэлхийг өөрчилсөн чухал хүмүүсийн тоонд оруулсан байдаг. Түүнчлэн өнгөрсөн онд “Bloomberg Markets” сэтгүүлийн хамгийн нөлөө бүхий 50 хүний нэгээр нэрлэжээ. Тэрбээр манай улсад



“UB Impulse II: Чанартай өсөлт” лекцийн үеэр

зочлон “UB Impulse II: Чанартай өсөлт” сэдэвт лекцэд оролцохдоо “Европын хямрал: Дэлхийн эдийн засагт хэрхэн нөлөөлж байна вэ” сэдвээр сонирхолтой илтгэл тавьсан юм. Тэрбээр илтгэлийнхээ хүрээнд евробусийн, тэр дундаа Грек өрийн хямралд орсон түүхэн замналыг жишээ бүрээр тайлбарлахдаа “Төв Азийн аль орныг санагдуулж байна” хэмээн илтгэлийг нь шимтэн сонсох зочдоос асууж байсны хариулт нь мэдээж Монгол байв.

Зарцуулах зүйлээ зөв олвол зээл авах ашигтай. Гэтэл үйлдвэрлэлийн дэд бүтэц, үндэсний брэнд, бага хүүтэй орон сууцны зээл гэх мэтээр бонд нэртэй өрийн мөнгөө зохисгүй тарааж байгаа Монголын Засгийн

газрын бодлогыг профессор Зинн буруушааж байлаа. Тэрбээр “Аливаа улсын хөгжил дэд бүтэцтэй салшгүй холбоотой. Гэхдээ үүнийг өрөөр биш, хөрөнгө оруулалтаар хөгжүүлдэг. Танай улсын инфляцийн түвшин 14 хувьтай байгаа тухай Дэлхийн банк нийтэлсэн байсан. Гэтэл моргейжийн зээлийн хүү нь үүнээс бараг хоёр дахин доогуур байна. Энэ бол байж боломгүй харьцаа” гэсэн юм. Түүний хэлснээр энэ нь инфляци хөөрөгдөхөөс өөр “гавьяагүй” аж.

Тус лекцийн бас нэгэн хүндэт илтгэгч Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Роберт Шозлхаммер “Өсөлт байгаа бол уналт ч бас бий. Иймд валютын зээлээ гамтай ашиглах хэрэгтэй.”

Дотоодын чухал салбаруудыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулагчдыг татах нь ашигтай. Ингэснээр гадаад өрийн дарамтыг иргэддээ үүрүүлэхээс зайлсхийнэ. Учир нь хөрөнгө оруулагчид зээлээ авч, түүгээрээ хөрөнгө оруулна. Монголын Засгийн газар тэдний өмнөөс хийгээд суух ажил биш” гэсэн юм. Суурин төлөөлөгч Роберт Шоэллхаммерын халаглаж буйгаар гурван сая хүрэхгүй хүн амтай манай улсын валютын өр хэдхэн жилийн дотор 2.1 тэрбум ам.доллараар өссөн нь “эмгэнэл” аж.

## Өрийг өгөөж болгох талаар

Төв Азийн “Грек” болохгүй байх боломж бидэнд бий. Профессор Зинн болон Роберт Шоэллхаммерын зөвлөснөөр монголчууд өрнөөсөө болж өтөнд баригдахуйн тулд дотоод эдийн засгаа хөгжүүлэх шаардлагатай аж. Тэдний санал нэгдэж буйгаар дотоод эдийн засаг нь тогтворгүй байхад экспортын зориулалттай үйлдвэрлэлийг түр мартах хэрэгтэй гэнэ. Өөрөөр хэлбэл, байшингийн сууриа цутгаагүй атлаа тоосгоо өрөх гэж яарах хэрэггүй ажээ. Профессор Зинн “Улс, үндэстэн хөгжин цэцэглэх үндэс нь дотоод эдийн засгийн суурь сайн байхаас эхэлдэг. Үүний ноён нуруу нь жижиг, дунд үйлдвэрлэлээс эхтэй төдийгүй боловсролын сайн системээс шалтгаалдаг. Харин боловсрол гэдэг нь зөвхөн их, дээд сургуулийн болосвролыг хэлэхгүй. Тусгай мэргэжлийн сургалт асар их үүрэг гүйцэтгэдэг. Барилга, зам барих хүмүүс нь байж дэд бүтэц хөгжинэ. Мэргэжлийн цахилгаанчид байж эрчим хүчний салбарт дэвшил гарна. Экспортоо хөгжүүлэх нь чухал хэдий ч энэ бол эдийн засгийн хоёрдогч хүчин зүйл. Танай орны хувьд дотоод эдийн засгаа хөгжүүлээгүй байж экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг олон салбарт нэвтрүүлэх шаардлага алга. Өрсөлдөж ч чадахгүй” хэмээн хатуухан хэлсэн. Мөн тэрбээр “Хоёр дахь гарын Япон машин хэдэн арваар нь оруулж ирэхийн оронд нэг япон инженер авчраад, түүний мэдлэгийг монголчууддаа өвлүүл. Ийм замаар дотоод эдийн засгаа хөгжүүлэх болохоос валютын зээлээр улс

доторх зардлаа санхүүжүүлэх нь ухаалаг алхам биш” гэсэн юм.

“UB Impulse II: Чанартай өсөлт” сэдэвт олон нийтийн лекц, хэлэлцүүлэгт манай улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын компаниудын төлөөлөл ч цөөнгүй байсан.

Уул уурхайгаас өөр эдийн засгийн хөшүүрэггүй мэт авирлаж байгаа Монголын Засгийн газрыг шүүмжлэх хөрөнгө оруулагчид олон. Тэдний нэг нь “Mongolian Star Melchers” компанийн гүйцэтгэх захирал Лауренц Мелшерс байв. Тэрбээр “Монголыг уул уурхайн орон гэдэг. Би үүнтэй санал нийлдэггүй. Монголд байгалийн нөөц, лиценз ашиглалтын тухай яриа л байна. Харин уул уурхай алга. Хуруу дарам цөөн компани л энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа. Хятадын нүүрсний импорт буурлаа, эдийн засаг хямарлаа гэдэг ч үнэн хэрэгтээ Хятад руу экспортлоод байгаа нь тун бага шүү дээ. Хэрэв Хятадын эрэлт өсвөл, нийлүүлэлт ч төдий хэмжээнд өснө. Гэтэл Монгол тэрхүү эрэлтийн хумсын чинээг ч хангадаггүй. Монголчууд ашигт малтмалаас гадна хөдөө аж ахуй гэх мэт бусад өрсөлдөхүйц нөөцөөрөө бахархах хэрэгтэй. Гэхдээ бахархаад суух хангалтгүй. Үүнийгээ хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулахаа сайтар бодох нь чухал. Харин энэ Монголын Засгийн газрын үүрэг болохоос АНУ, Европ эсвэл Хятадын эдийн засаг хэрхэхээс шууд хамаарахгүй” хэмээн өөрийн саналаа хуваалцсан юм. Түүний “Монголын Засгийн газар ямар бодлогоор юу хийх гээд байгаагаа шийдэх цаг болсон. Уул уурхайгаа хөгжүүлмээр байгаа бол хөгжүүл. Олборло, урд хөршдөө нийлүүл. Улсаа хөлжүүл. Ярихаа болиод хий” гэсэн үг лекцийн танхимд суусан олны алга ташилтаар хөглөгдөж байлаа.

## Герман зөвлөгөө

Монгол өрийн ангалд уналаа гэхэд биднийг торгоох “Азийн Холбоо” гэж байхгүй. Хэвлэх ажиллагаа явуулах “Азийн Төвбанк” ч гэж үгүй. Тэгэхээр аваад идчихсэн мөнгөө хаа нэгтэйгээс олох л хэрэг гарна.

Харин ингэхийн тулд үндэсний гэх бүхнээ өрөндөө өгөхөөс өөр гарцгүй болж мэднэ гэдгийг лекцийн үеэр оролцогчид анхааруулж байв.

Уул уурхайн орнуудад элбэг тархах Голланд өвчнөөс ангид байх нөхцөл Баялгийн сан байгуулах аж. Баялгийн хараалд гүн автахаас сэргийлж чадсан Чили, Норвеги болон Арабын орнууд ийм сан байгуулснаар “Алтан дээр суусан ядуус” болох эрсдэлээс аврагдсан юм. Тус санд тэргүүлэгч салбараас олсон орлогын хэсэг хувийг төвлөрүүлснээр бусад салбарынхаа өрсөлдөх чадварыг хадгалах нөхцөл бүрддэг байна. Үүнээс гадна цалин хөлсний хэт ялгааг үгүй болгох, байгалийн нөөцийг тодорхой хэмжээнд хадгалж үлдэх үндэс болохоос гадна ашигт малтмалын үнийн хэлбэлзлийн эсрэг хамгаалт болж өгдөг аж. Манай улс Баялгийн сантай болох асуудал олон жилийн турш яригдаж буй ч биелсэн нь өдгөө үгүй. Харин дээрх туршлагаас монголчууд суралцваас өнөөгийн үүсээд буй нөхцөл байдлын эсрэг харьцангуй тогтвортой зогсох боломжтой болно гэдгийг профессор Зинн, Роберт Шоэллхаммер нар зөвлөв. Түүнчлэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх замаар чадварлаг хүний нөөц бүрдүүлэх нь Монгол Улсын хувьд анхаарах чухал асуудлуудын нэг байх талаар тэд ярьсан юм. Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Роберт Шоэллхаммер “Монгол Улсын эдийн засаг бөхөн гөрөөсний хурдаар урагшилж байсан. Өнөөдөр яст мэлхий мэт болжээ. Гэвч зарим тохиолдолд гөрөөс байснаас яст мэлхий байх нь давуу талтай. Учир нь яст мэлхий илүү удаан амьдардаг шүү дээ” гэв.

Хүний эрхэнд жаргахаар өөрийн эрхэнд зов гэдэг. Монгол ардын эл сургаалийг бидэнд өнөөдөр харийнхан айлтгаж байна. “Зээлээ багасга. Өөрсдийн хүчээр улсаа хөгжүүл. Бэлэн бүхэн хоол болдоггүй юм шүү” гэсэн Герман зөвлөгөөгөөр хагас өдрийн турш үргэлжилсэн “UB Impulse II: Чанартай өсөлт” сэдэвт олон нийтийн лекц, хэлэлцүүлэг өндөрлөсөн билээ. ■

ЗОЧИН

# “БҮҮ ЗЭЭЛ, ХАРИН ХАДГАЛ”

Х. ХУЛАН

*Германы Олон улсын хөгжлийн агентлаг (GIZ)-ийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” (IMRI) хөтөлбөрөөс зохион байгуулсан “UB Impulse-2013” арга хэмжээний үеэр Мюнхений их сургуулийн профессор Германы “Ifo” эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн ерөнхийлөгч Ханс-Вернер Зиннтэй ярилцлаа.*

**-Та Монголд анх удаа ирсэн үү, сэтгэгдэл ямар байна?**

-Тийм ээ. Би Монголд анх удаа ирж байна. Монголчуудын эрч хүч, уужуу занг хараад сэтгэл ихэд хөдөлж байна. Гайхалтай орон юм.

**-Та Европын эдийн засгийн өнөөгийн хямралын талаар юу гэж бодож байна вэ?**

-Европын хямрал хоёр талтай. Нэг нь санхүүгийн хямрал, нөгөө нь бодитоор нүүрлэсэн хямрал. Шаардлагатай тохиолдолд Засгийн газар бонд гаргаж, Европын Төвбанк амлалт өгснөөр санхүүгийн хямрал намжих тийшээ хандсан. Харин бодитоор нүүрлээд буй хямралын асуудлыг шийдвэрлэхэд амаргүй. Өмнөд Европын орнууд өрсөлдөх чадвараа алдсан бөгөөд ажилгүйдэл, ялангуяа залуусын дунд маш их газар авсан.

**-Хөгжиж буй орнуудын эдийн засагт тулгараад буй сорилт хэр удаан үргэлжилнэ гэж Та бодож байна вэ?**

-БНХАУ, ОХУ болон Бразил зэрэг орнуудын эдийн засгийн өсөлт удаашралтай байгаагаас дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн мөчлөг буурах болсон. Дээрх орнуудын эдийн засгийн өсөлтийн удаашрал удаан үргэлжлэхгүй гэж бодож байна. Монголын хувьд гол зах зээл болох БНХАУ-ын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний худалдан авалт буурсан нь сайны шинж биш гэдэг нь ойлгомжтой. Тус улсын хэрэгцээ дахин сэргэнэ гэж бодож байна.



**-11 хувийн өсөлттэй байгаа Монголын эдийн засгийн өсөлтийн талаар таны бодол.**

-Энэ бол тун сайн өсөлт. Гэхдээ БНХАУ-ын өсөлтийг дагадаг. Эдийн засгийн нөхцөлөөр аваад үзвэл Монгол Улсын нийт экспортын 90 хувь нь урд хөршөөсөө хамааралтай. Энэхүү үйл явц хүндхэн байгаа боловч илүү сайн зохион байгуулах боломжтой. Нэг талаас хувийн хэвшлийнхний өсөлт ширүүн байгаа, нөгөө талаас Засгийн газрын зохицуулалт, төрийн дэд бүтэц учир дутагдалтай байгаа нь хоорондын харьцааг тодорхой хэмжээгээр алдагдуулсан гэж бодож байна.

Монгол Улсын импорт хэтэрхий их байна. Бусад орноос бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээний дотогш чиглэсэн урсгалаас хэтэрхий хамааралтай гэж болно. Гадаад худалдааны алдагдал ДНБ-ий 30 хувьтай тэнцэж, хэвийн байдлаа алдсан. Энэ алдагдлыг зайлшгүй зогсоох ёстой юм. ▶

▶ Зарж борлуулах бэлээхэн байгалийн нөөцтэй байж Засгийн газрын бонд гаргах ямар ч шаардлагагүй юм. Хөрөнгө болон бараа, бүтээгдэхүүний импортыг дэмжсэн Чингис бондыг гаргах нь аюултай. Учир нь ам.доллараар зээл авч буй хэрэг бөгөөд үүний дүнд дотоодын мөнгөн тэмдэгт инфляцид өртөж, үнэгүйдэхэд хүрдэг. Өрөө төлөхөд маш их хэмжээний хүндрэлтэй тулгарах болно.

**-Энэ нөхцөл байдлаас гарах ямар нэг шийдлийг Та олж харж байна уу. Засгийн газар юу хийж чадах вэ?**

-Зардлаа хэмнэх шаардлагатай. Олж буй орлогоосоо хэтэрсэн зардалтай байж болохгүй. Засгийн газрын зүгээс Монголбанкны бодлогод хөндлөнгөөс оролцох ёсгүй. Төвбанк бодлогын хүүгийн ханшаа өсгөж, харин Засгийн газар Чингис бондоос хүүгийн татаас үзүүлдэг. Энэ хоёр хоорондоо харшиж байна.

Эдийн засгийн өсөлтийн үйл явц удаашрах нь зүйн хэрэг. Учир нь эдийн засаг хиймлээр өсч, хэт халсан байгаа. Энэ бол хөөс юм.

**-Тэгвэл энэ хөөсийг хэрхэн арилгах вэ?**

-Хэт их зардал гаргахгүй байх, ард иргэдэд бэлэн мөнгө тараахаа болих. Үүний оронд Тэтгэврийн сан байгуулах нь ирээдүйдээ зориулсан ямар нэг барьцтай зүйл хийж буй хэрэг.

**-Эдийн засгийн өнөөгийн байдалтай холбоотойгоор таны зүгээс манай сэтгүүлийн уншигчдад санал болгох зүйл юу байна вэ?**

-Хүмүүс мөнгөө хадгалах ёстой. Зардал хэтэрхий өндөр байгаа нь ойлгомжтой. Европт хөөс нэг л өдөр хагарсныг бид харсан шиг энд тийм зүйл тохиолдохыг үгүйсгэхгүй. Бүү зээл, харин хадгал. Хадгална гэхээр банкинд мөнгөө хийгээд хав дараад байх албагүй. Харин ч компаниудын хувьцааг худалдаж авч болох юм.

**-Аливаа оронд эдийн засагчид ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?**

-Эдийн засагчид харилцан адилгүй төлөв байдал дахь макро эдийн засгийн харилцан үйлчлэл болон нөлөөллийг авч үздэг. Хувийн хэвшлийг бүрдүүлдэг эдийн засгийн

дүрэм, журам тогтоож, бүтцийг бий болгох үүргийг тэд гүйцэтгэдэг. Энэ нь замын бөглөрөл үүсэхээс сэргийлэхийн тулд замын цагдаа ажилладагтай яг адил. Хувийн хэвшлүүд бол автомашины жолооч нар. Харин эдийн засагчдыг замын цагдаатай зүйрлэж болно.

**-Таны эрдмийн ажлын сэдэв "Тодорхойгүй нөхцөлд гаргах эдийн засгийн шийдвэр" гэсэн байсан. Өнөөдөр бид үүнээс юу суралцаж, хэрэглэж болох вэ?**

-Миний эрдмийн ажлын гол сэдвүүдийн нэг нь бага хөрөнгөтэй, хязгаарлагдмал хариуцлагатай үед хэтэрсэн эрсдэл үүрэх тухай. Монголын зарим банкууд дампуурч Засгийн газраас нь үзүүлсэн тусламжийн талаар тухайн үед би сонсож байсан. Энэ бол зайлсхийх ёстой асуудал мөнөөс мөн бөгөөд банкууд өдгөө эзэмшиж буй олон төрлийн хөрөнгөө эргэлтэд оруулан ашиглахаас өөр аргагүй байдалд оруулж буй. Хэрэв ингэхгүй юм бол банкууд татвар төлөгчдийг барьцаалан мөрийцөж буй хэрэг.

**-Таны чухам ямар ажил Германы Засгийн газрыг улс төрийн реформ хийхэд хүргэж, нөлөөлсөн бэ?**

-Нийгмийн тусламжийг идэвх-жүүлэх зорилгоор хийсэн ажил маань "Agenda 2010" сэдэвт Шредерийн реформд нөлөө үзүүлсэн. Энэ нь амьжиргааны түвшинг бууруулалгүйгээр ажлын байр шинээр бий болгохын тулд мэргэжил, ур чадвар тааруухан хүмүүсийг тохирсон цалинтай ажилтай болгох зорилготой байв. Үүний тулд ажилгүйдлийн тэтгэмжийг бууруулж, ажилтай холбоотой татаас төлөх хэрэгтэй болсон. Энэ бодлого ажлын байрыг ихээр бий болгож, ялангуяа ур чадвар тааруухан хүмүүсийг ажлаар хангаж чадсан. Ажилтай болсноор тэд дунд зэргийн орлоготой болохын зэрэгцээ Засгийн газраас татаас өгч байв. Энэ нь ур чадвар муутай ажилтнууд болон нийгмийн бусад давхаргад илүү сайн зүйл болсон юм. Ажилгүй байсных нь төлөө хүмүүст мөнгө өгч, нийгмийн халамж үзүүлэх нь ямар ч утгагүй зүйл.

**-Герман улс Европын холбооны улсуудыг эдийн засгийн сорилттой**

**тулгарч байх үед дэмжлэг үзүүлсээр ирсэн. Өнөөгийн байдлаас гарахын тулд урт хугацаа шаардлагатай юу?**

-Урт хугацааны үйл явц шаардагдана. Учир нь хэтэрхий өндөр болсон үнэ нэг л өдөр буурдаг. Улс, орнуудын хооронд худалддаг бараа, бүтээгдэхүүний үнийг дахин тохируулах шаардлага бидний өмнө тулгаараад буй. Энэ бол маш хүнд, хэцүү үйл явц юм. Энэ нь хойд Европын орнуудад инфляци үүсгэж, өмнөд Европын орнуудад дефляци үүсгэж ч болно. Гэхдээ хойд европыхон өөрсдийн хадгаламжийг алдахаас айж байгаа учраас инфляцийг хүсэхгүй нь тодорхой. Харин өмнөд европыхны хувьд дефляцийг мөн хүсэхгүй бөгөөд учир нь өөрсдийн өрийг эргүүлэн төлөх боломжгүй болох эрсдэлтэй.

**-"Ifo" эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн талаар танилцуулахгүй юу?**

"Ifo" хүрээлэн нь Германы төрийн санхүүжилттэй таван хүрээлэнгийн нэг. Эдийн засгийн чухал ач холбогдолтой судалгаа явуулдаг. Бид сар болгон 7000 компаниас тэдгээрийн бизнесийн нөхцөл байдал болон туршлагын талаар мэдээлэл авдаг. Бид дэлхий дахинд олон судлаачтай хамтран ажилладаг бөгөөд дэлхийн өнцөг булан бүрээс 1000 гаруй эдийн засгийн профессорыг хамруулсан судалгааны сүлжээтэй.

**-Таны бодлоор Монгол Улсад улс төрийн ямар реформ хэрэгтэй вэ?**

-Миний бодлоор боловсролын хосолсон тогтолцоо хэрэгтэй юм шиг санагддаг. Монголд 100 гаруй их, дээд сургууль байгаа нь 2.9 сая хүний хувьд дэндүү ахадсан тоо. Хоёроос гурван их сургууль байхад хангалттай. Ийм олон сургуулийн оронд техник, мэргэжлийн сургуулиуд хэрэгтэй. Ажил, мэргэжил болгон өөрийн гэсэн "know-how" болон нарийвчилсан мэдлэгийг шаарддаг. Компаниудтай хамтран боловсролын хосолсон тогтолцоог бүрдүүлэх боломжтой юм.

Хууль тогтоомж, эмх замбараатай тогтолцоог мөн бий болгох шаардлагатай гэж үзэж байна. ▶

► Энэ бол зайлшгүй чухал асуудал. Аливаа хотыг төлөвлөлт, тухайн бүсэд зориулсан хатуу чанд дүрэм, журамгүйгээр барьж байгуулах боломжгүй. Жишээ болгох үүднээс хууль бусаар баригдсан ганц, хоёр байшинг Засгийн газар нураах ёстой. Үүний дараа хүмүүс дүрэм, журмыг дагаж мөрдөх болно.

Улаанбаатар хот төдийгүй Монгол Улсын хэмжээнд дэд бүтцийг яаралтай сайжруулах хэрэгтэй. Төрийн зүгээс хувийн хэрэглээтэй холбоотой дэд бүтцийн хөрөнгө оруулалт хэтэрхий бага байна.

Улаанбаатар хотын хүн болгон л гар утастай, бараг айл өрх бүр

хавтгай дэлгэцтэй зурагтай байх. Электрон бараа, төхөөрөмж хэрэглэхэд үнэхээр сайхан байдаг. Японоос автомашин худалдан авахаа багасгаж, улмаар гудамж, автомашины зогсоол болон байшин, барилгуудын дундах цэцэрлэгт хүрээлэн, амралт, зугаалгын талбай зэрэг олон нийтийн газрууд олноор байгуулахыг миний зүгээс санал болгомоор байна. Мөн эмнэлэг шинээр байгуулах хэрэгтэй. Миний бодлоор амьд дэд бүтэц энд дутагдаж байна.

**-Цаг заваа гаргаж, манай сэтгүүлд ярилцлага өгсөнд баярлалаа! ■**

үнэний нэг хэсэг төдий. Европ тив нэгдсэн мөнгөн тэмдэгтээр ижилсэх шийдвэр гарсан тэр цагаас өрийн хямрал үүссэн гэлтэй.

## Европын шинэ бүс GIPSIC

Шинэ зуун, шинэ мөнгөн тэмдэгт. Европын эдийн засгийг шинэ түвшинд хүргэх евро хэмээгч дэлхийн зах зээлд нэвтрэв. Тив нийтээрээ хэтэвчиндэхээ ижилсүүлснээр ханшийн хэлбэлзлээс үл хамаарсан чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх боломж бүрдсэн гэдэг. Энэ боломжтой зэрэгцэн Португаль, Грек, Киприйн Засгийн газар бонд гаргаж эхэлсэн. Ийнхүү өрийн бичгээр олсон хэдээрээ төрийн албан хаагчдын цалинг нэмэхийн сацуу нийгмийн халамж нэрээр иргэдээ “хөлжүүлэв”. Харин иргэд нь тохилог сууц, Герман чанар, Япон технологид дурлан өрийн дансаа улайлгаж байлаа. Испани, Ирланд, Италийн хувьд төрийн өр хямрал даллаагүй ч хувийн хэвшил нь хэмжээлшгүй ихээр зээлсэн байдаг. Ийн улсынхаа төсөвт татвар хэлбэрээр багагүй мөнгө нийлүүлж, магтаалын дээдийг хүртэж байсан ч зээлийн урсгал боогдоход татвар тасалдах нөхцөл болсон юм.

Грек, Итали, Португаль, Испани, Ирланд болон Кипр GIPSIC хэмээх ►

## ӨРИЙН БҮС

# GIPSIC+МОНГОЛ?

### Б.БАЯН

Дэлхийн II дайнаас хойш хямрал гээчийг үзээгүй топ эдийн засгуудын “лагшин” 2008 онд нэг л базаахгүй болоод ирэв.

Нэгэн үед үл хөдлөх, моргейжид хошуурч байсан америкчууд байр, сууцыг чухалчлахаа больсноор АНУ-ын банкны салбар уналтад орж бусад холбоотой салбарыг хөлдөө чирж эхэлсэн. Удалгүй тус улсын эдийн засгийн түнш хийгээд тэмцэлдэгч буурал Европ уналтын эрчинд хөтлөгдөх нь тэр. “Өндөр хөгжилтэй”, “Барууны” хэмээн үлгэр дууриалал болдог орнуудын эдийн засаг өрсөн даалуу нурах адил унаж байлаа.

Хэдий Америкийн эдийн засгийн таагүй байдал Европын хөрөнгө оруулагчдад хүнд туссан ч 2008 оны хямралыг АНУ-ын үнийн хөөсөнд умбасан үл хөдлөхөөс эхтэй гэвэл



шинэ ойлголтыг дэлхийд түгээв. Үрэлгэн зангаасаа болж ерөнд унасан дээрх зургаан оронд цухас үзэгдсэн өсөлт, хөгжил солонго мэт замхрав. Эцэст нь GIPSIC-т инфляци, ажилгүйдэл, үнийн хөөрөгдөл газар авч, улмаар зээлээр “хөглөгдсөн” эдийн засаг болж хувирсан. Түүнчлэн 1995-2008 онд дээрх орнуудын бараа, бүтээгдэхүүний үнэ 40-67 хувиар өссөн нь тэдний өрсөлдөх чадварыг дэлхийн зах зээлээс арчсан гэдгийг олон улсын томоохон судалгааны байгууллагууд онцолдог.

Сүүлийн таван жилийн хугацаанд дээрх үзүүлэлт 30 хувиар нэмэгдсэн байна.

Тухайлбал, Грек өрийн хямралыг хамгийн ихээр амсаж буй. Грекийн эдийн засаг шил мэт хагарч эхлэхэд гадаадын хөрөнгө оруулагчид ч өрсөлдөх чадваргүй болсон тус улсаас дайжих болов. Түүнчлэн тансаг хэрэглээнийх нь санхүүжилт зогссон нь авсан дахь сүүлийн хадаас болсон гэдэг. Хамгийн энгийн жишээ дурдвал, Грек чидун жимсний экспортод тэргүүлэгч байв. Гэтэл ийм төрлийн үйлдвэрлэл дотооддоо явуулах шаардлагагүй гэж үзэв үү гэлтэй Герман зэрэг орноос импортлохыг илүүд үзэж. Энэ мэтээр дотоодын үйлдвэрлэлийнхээ өрсөлдөх чадварыг үгүй хийсэн тухай баримтууд олонд ил. Гаднын мөнгөөр туйлж байсан тус улс өдгөө хөдөлмөрийн насны залуусынхаа гуравны хоёрыг нийгмийн халамжаар тэтгэн гэрт нь суулгаж байна.

Иргэдийнхээ хадгаламжийн мөнгийг эргэн олгох боломжгүй гэдгээ хэдийнэ зарласан Кипр гаднынханд иргэншил амлан хөрөнгө татах горьдлого тээж буй. Тэгвэл Испани 942.8 тэрбумын өглөгөө хэрхэн барагдуулахаа мэдэхгүй суугаа. Испанийн Төвбанкны мэдээлснээр тус улсын Засгийн газрын нийт өр эдийн засгийн бүтээмжийнх нь 92.2 хувьтай тэнцэж байгаа аж. Ирланд улсын хувьд хямралаас гарсан гэсэн таатай мэдээ тархаж буй ч баярлах болоогүйг дэлхийн эдийн засагчид сануулсаар байгаа. Учир нь тус улсад ажилгүйдэл 13 хувьтай байгаа, моргейжийн зээлийн эргэн төлөлт болон дотоодын эдийн засагт зэрэг хүлээлт бага байгаа билээ.

## Хэвлэх ажиллагаа

Цухас хугацаанд ядуугийн зовлонг мартсан GIPSIC-ууд одоогоор 1.1 их наяд еврогийн тусламж аваад буй. Үүний 650 тэрбумыг хэвлэсэн бол 120 тэрбумыг GIPSIC-ийн Засгийн газрууд бонд гарган босгожээ. Тэгэхээр дээрх санхүүжилтийн ердөө 35 хувийг GIPSIC бүрдүүлсэн бол 65 хувийг Европын Төвбанк дангаар хариуцжээ. Өөрөөр хэлбэл, умардынхан өмнөдөө аврахын тулд еврог их хэмжээгээр хэвлэж байв. Тухайлбал, өмнөд бүсийг өрийн хямралаас аврах 1.1 их наяд еврогийн зээлээс Грек 214 тэрбумыг хүртсэн нь тус улсын ДНБ-ий 160 хувьтай дүйх аж.

Гэвч аврах ажиллагаа тусыг эс олов. Хэтэрхий ихийг зээлүүлсэн бүсийн Төвбанк өөрийн капиталаа хадгалахын тулд зээлийн хүү, барьцаа хөрөнгийн шаардлагаа хөнгөвчлөн өмнөдийн Засгийн газруудын бондыг худалдаж авахад хүрсэн байдаг. “Төвбанк Засгийн газруудыг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн Маастрихтын гэрээний заалтыг зөрчсөн гэх улстөрчдийн эсэргүүцэлтэй тулгарсан ч Европын Төвбанкинд өөр сонголт байсангүй. Өртэй орнуудын өрийн бичгийг худалдан авах замаар итгэл нь алдарсан хөрөнгө оруулагчдыг дээрх улсуудад “эрсдэлгүйгээр” дахин хөрөнгө оруулахыг Европын Төвбанк “ягтаж” байсан. Товчхондоо, өөрийн нэрээр дэнчин тавин “шимтгэлгүй даатгал олгогч”-ийн үүрэг гүйцэтгэж эхлэв.

## Европоос Ази руу, тэгээд Монгол

Шил шилээ дагасан үр дүнгүй оролдлогууд. Эцэст нь Банкуудын нэгдсэн холбоо байгуулна, байгуулахгүй гэх маргаан. Төгсгөл нь үл үзэгдэх GIPSIC-ийн өр. Европт нэг иймэрхүү.

Энэ үед өсөж, буурсан үзүүлэлттэй Азийн эдийн засгууд дор бүрнээ тогтвортой өсөлтийг эрэлхийлж буй. Тухайлбал, Япон улсын Засгийн газар иенийн ханшаа сулруулж, улмаар өрсөлдөх чадвараа

дээшлүүлэн эдийн засгаа аварна гэх. Тэдний энэ оролдлогыг Олон улсын валютын сан “Хилийн чанадыг зорих учиртай тээш дүүрэн чингэлэгүүд усан боомт дээр “хог” болж байсныг бодвол нөхцөл байдал дээрдсэн. Эерэг үр дүн гарч мэднэ” хэмээн сайшааж байгаа. Харин Энэтхэгийн эдийн засаг ухрах араанд нэлээд хурдан шилжиж, нэг ам.доллартай тэнцэх рупигийн ханш шалдаа буусан нь саяхан. Тэгвэл урд хөршийн эдийн засгийн жилийн дундаж өсөлт ялимгүй саарсан ч 7.5 хувьтай яваа. Итгэлт захиалагч АНУ, Европын эрэлт буурсан нь Хятад дотоодын эрэлтээр гадаад худалдааны “шархаа” нөхөх арга хэмжээ авахад хүргэж буй. Ийм үед, тухайлбал, урд хөршийнхөө хормойноос зүүгдэн, экспортлож болох бүхнийхээ 92.6 хувийг нийлүүлдэг Монголын эдийн засаг хэрхэх нь тодорхой болно гэдгийг манай эдийн засагчид учирлаж байгаа.

Ашигт малтмалын нөөцөөрөө Монгол дэлхийн уул уурхайн салбарт томоохон тоглогч байж чадна. Гэтэл өрсөлдөх чадвар өндөртэй, олонд танигдсан цорын ганц салбарт нь улсын нийт ажиллах хүчний ердөө дөрвөн хувь нь ажилладаг гэсэн судалгааг Азийн хөгжлийн банкнаас гаргажээ. Ийм байтал ажиллах хүч, дэвшилт технологи дутмаг Монголын уул уурхай эдийн засгийнх нь гол хүч болчихсон.

Зах зээлийн жамаар хэлбэлзэх ашигт малтмалын ханш, тэр дундаа зэсийн үнэ 32, нүүрс 56 хувиар тус тус буурахад манай эдийн засаг хүндэрч, түгшүүр зарлах нь холгүй байдалд орсныг хэн хүнгүй мэдэх. Хөгжлийн банкнаас авсан 600 сая ам.долларыг “хүний хөгжилдөө” үрчихсэн Монголын Засгийн газар зээлийн эрэлд дахин мордож, зорилгоо ч биелүүлсэн. Мөнгө гэхээр “Чингис” бондоо ярих манай Засгийн газар хоёрхон жилийн хугацаанд гадаад өрөө 2.1 тэрбум ам.доллараар нэмэхийн сацуу “Самурай”-тай ч болоод амжив.

Ийн өр тавьж олсон хэдэн “ногоон”-оо өмнөд европчуудын адил үрэн таран хийж байгаа Монголын Засгийн газар GIPSIC хэмээх шинэ нэршилд “М” үсэг нэмж, өрийн бүсийг тэлэх нь үү гэх бодол төрүүлэх. ■

## ВАЛЮТЫН САВЛАГАА

# ЗАХ ЗЭЭЛ ӨӨРӨӨ ШИЙДЭГ

## Б.ЭНХЦЭЦЭГ

Ханшийг хашаа, доторх байшинг нь Монголын эдийн засаг гэж бодъё. Гаднын хэнбугай ч айлд орохдоо хашааны хаалга тогшдог. Урилгагүй зочин ч нохой хориулна. Энэ бол гэрийн эздэд ирэх гаднын дохио. Төгрөг мөнгөн тэмдэгтийн бусад валютын ханштай харьцах хэлбэлзэл Монгол хэмээх их айлын эдийн засагт ирж буй гаднын дуудлага сайн, муу аль нь ч байсан бэлд гэсэн сануулга.

Эцсийн бүтээгдэхүүн импортлогч, түүхий эдийн хувьд экспортлогч манай улсад валютын ханшийн савлагаа ихээхэн эмзэг тусдаг. Үүнийг энэ жилийн гуравдугаар улиралд ам.долларын ханш 1800 төгрөгт хүрэхээ шахсан нь тод гэрчиллээ. Өнгөрсөн сарын сүүлчээр болж өнгөрсөн Компанийн захирлуудын уулзалтаар ханшийн чангарлыг тойрч гарсан компани байхгүйг харж болохоор байв. Бүгд л их хохирол амссанаа ам булаалдан хэлж байлаа. Ам.долларын ханш оны эхнээс 15 хувиар чангарсан. Ханшийн өөрчлөлтөөс хамгаалах хэрэгсэл, бүтээгдэхүүн байдаггүй манай зах зээлд энэ өөрчлөлт нь дотоодын бизнесүүд ашгаас алдагдал руу шууд шилжихэд хүргэжээ.

Монгол Улсын төсөв ч өнөөдөр дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурч, эрэлт багассанаас үүдэн том цоорхойтой байгаа нь хэн бүхэнд ил болсон. Он гарч эхний хагас жилийн байдлаар нүүрсний экспорт 50 орчим, гадаадын хөрөнгө

оруулалт 40 гаруй хувиар буурсан зэрэг нь ам.долларын ханш огцом өссөн томоохон шалтгаануудын нэг болоод байгааг мэргэжилтнүүд хэлж буй. Бид зарахаасаа илүү авдаг орон. Үүний нөлөөгөөр өнгөрсөн жилүүдэд худалдааны тэнцэл алдагдалтай гардаг байсан ч зөрүүг нь гаднын хөрөнгө оруулалт битүүлсээр ирсэн. Хөрөнгө оруулалт буурснаар энэ жил тус нөхөөсний аврах ажиллагаа амжилтгүй болох нь ойлгомжтой болсныг “Мандал даатгал” компани есдүгээр сарын эдийн засгийн тооцоололдоо харуулжээ. Өнгөрсөн зургадугаар сарын байдлаар худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын алдагдалтай, төлбөрийн тэнцэл 911 сая ам.долларын хасах дүнтэй гараад байна.

Дэлхийн банкны эдийн засагч Тайхён Ли “Валютын ханшийн сулрал нь Монгол Улсын зах зээлийн суурь үзүүлэлтүүдэд шууд тусч байна. Валютын ханшийн энэ удаагийн өөрчлөлт нь Монголын зах зээл хэт мэдрэмтгийг харууллаа. Ялангуяа сөрөг мэдээлэлд зах зээл тун эмзэг” хэмээн өнгөрсөн сарын сүүлээр болсон “Монгол Улсын тэнцлийн өнөөгийн төлөв: Хямрал уу, боломж уу” сэдэвт уулзалт, семинарын үеэр илтгэлдээ хэлж байсан. МУИС-ийн Эдийн засгийн онолын тэнхимийн эрхлэгч Б. Алтанцэцэг тус семинарын үеэр төгрөгийн нэрлэсэн ханш буурах хандлагатай ч бодит ханш өсөхөөр байгааг тайлбарласан.

Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал Компанийн захир-

луудын чуулган дээр “ам.долларын ханш буурч, тогтворжих хандлагатай байна. Бидний хийсэн ажлын жинхэнэ үр дүн ирэх жил гарна” гэв. Хэрвээ үнэ тогтворжуулах бодлого хэрэгжүүлээгүй бол өнөөдөр шатахууны үнэ 50 хувиар өсч, ханшийн савалгаа 30 хувь байх байсныг тэрбээр мөн хэлсэн. Гэсэн ч цаашид Монголбанк валютын нөөцөө дундлан байж, шахалтаар шахуу интервенц хийх замаар ханшийн орчинд хана босгодогийг шүүмжлэх зах зээлийн оролцогч, шинжээч, эдийн засагчид цөөнгүй бий.

## Толгой хаашаа сүүл тийшээ

Манай экспортын дийлэнхийг уул уурхай эзэлдэг болоод багагүй хугацааг үдэж байна. Экспортын орлогын 90 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа нь түүхэнд байгаагүй рекорд гэх. Түүхий эдээ экспортолж гаргадаг Канад, Австрали, Чили, Орос, Өмнөд Африк зэрэг улс бий. Экспортынх нь орлого түүхий эдийн эрэлт, үнэд чанга чагтлуулчихсан орнууд гэж ойлгож болно. Тиймээс түүхий эдийн валюттай улс хэмээн цоллогддог. Чили, Канад, Австралиаар харьцуулахад манай улсын экспорт хамгийн их түүхий эдийн хамааралтай нь. Гэвч дээрх орнууд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Манай улсын хувьд хил давуулж буй нь газар ухаж гаргаж авсан ашигт малтмал. Дэлхийн зах



багш Б.Эрдэнэбат “Монголбанкийг Засгийн газар, аж ахуйн нэгж, сонирхлын бүлгүүд шахаанд оруулж интервенц хийлгэж, хагас тэрбумыг зарцуулчихаад байна. Гэсэн ч ханш унадагаараа унасан. Тиймээс валютын зах зээлтэй тэмцээд ялсан нь үгүй харин ч ялагдсан. Ялагдахдаа маш их зардалтай ялагдлаа” хэмээн тэрбээр одоогийн нөхцөл байдлыг дүгнэсэн юм.

Ерөнхийдөө энгийнээр тайлбарлахад ханшийг аажмаар эсвэл огцом унагах уу гэсэн сонголт бий. Бусад улсад алгуур унагасан нь эдийн засагт дарамт бага гэж үздэг байна.

Ханш унадагаараа унасан. Тиймээс валютын зах зээлтэй тэмцээд ялсан нь үгүй харин ч ялагдсан. Ялагдахдаа маш их зардалтай ялагдлаа

► зээл дээр хамгийн их хэлбэлзлэлттэй байдаг бүтээгдэхүүн болох түүхий эд.

Дээр жишээ авсан улсуудын хувьд ханшийн уян хатан бодлоготой. Гаднаас ирэх “шоки” дотоод эдийн засаг шууд хүлээж авахаас хамгаалах механизмыг ханшийн уян хатан систем гэдэг. Өөрөөр хэлбэл, тэд ханш хаашаа ч чиглэж байсан интервенц хийдэггүй. Зах зээлд нь даатгадаг. Харин манай улсын хувьд Хятад улс шиг ам.доллартай мөнгөн тэмдэгтээ бат уяадаггүй ч бодлогоор ханшаа хашдаг. Төвбанк гадаад валютын зах дээр шууд оролцдоггүй, валютын ханш эрэлт, нийлүүлэлтээр тогтдог зарчмыг зах зээлийн олон оролцогч хүсэмжилж буйгаа хэлж байгаа СЭЗДС-ийн Экономиксийн тэнхимийн багш Д.Түвшинжаргал “Чөлөөтэй хөвөгч горим нь хөгжингүй орнуудын хувьд бусад горимтой харьцуулахад инфляцийн дарамтгүй, эдийн засгийн өсөлтийг илүү нэмэгдүүлдэг” гэдгийг Монгол Улсын тэнцлийн өнөөгийн төлөв хурлын

үеэр илтгэлдээ дурдсан. Тэрбээр мөн хэдийгээр хөгжиж буй орнуудад тогтмол ханшийн буюу одоогийн манай замнаж буй бодлого оновчтой ч эдийн засаг нь хурдацтай өсч байгаа орнуудын хувьд тогтмол ханшийг дагахад зах зээлийн дарамттай нэлээд нүүр тулах бөгөөд инфляцийн бууралт, эсвэл эдийн засгийн өсөлт бий болохгүйг хэлсэн.

Европын эдийн засгийн тодорхой бус байдал, мөн түүхий эд авдаг гол улс Хятадын эдийн засаг саарах дохиогоор түүхий эдээ өгдөг орнуудын валют унаж байна. Манайх ч гэсэн ялгаагүй унаад ирсэн. Гэхдээ интервенц хийх замаар торгоож байгаад унагасан. Мэргэжлийн хүний хэлснээр “Бусад улсын ханш хэлбэлзэх замаар унаж байхад манайх гөлийтэл тогтож байснаа гэнэт огцом унадаг гэмтэй гэнэ. Иймээс л компаниуд хүнд цохилт, гүн хордлогыг мэдрээд байгааг мэргэжилтнүүд хэлж буй. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн

Ханш унахаар тухайн эдийн засагт бэлдэх хугацаа болж, ойрын ирээдүйд хэрхэн сэргийлэх арга чарга аль аль талаас гарч ирнэ. Аж ахуйн нэгжүүд ханшийн эсрэг даатгал худалдаж авна. Эсвэл форвард, опшон, своп, фьючерс, хэлцлүүд хийх зэрэг арга бий. Эдгээр үүсмэл хэрэгсэл Монголд орж ирэх нөхцөлийг одоо болтол хангаж өгөхгүй байгаад гайхах хүн цөөнгүй. Алдаж, онож байгаа хоёр талын эрсдэлийг нийлүүлсэн даатгалын бүтээгдэхүүн ашиг хонжооны үүдийг нэгд нь нээж, нөгөөд нь хамгаалалтын бамбай болдог. Гэтэл Монголд интервенц нэрийдлээр түмний нүдийг хааж, чхийг таглаж байгаад, огцом ханшийн уналтаар “сюрприз” барьдаг нь санхүүгийн зах зээлийн хөгжих боломжийг хязгаарлаж байгаа. Улмаар энэ нь компаниудын хувьд ашаасаа огцом огтлуулж, алдагдалын ангал руу араасаа түлхүүлэх нөхцөл болж буйг мэргэжилтнүүд шүүмжилж байна. Товчхондоо огцом цочроог ►

► өөрсдөө бий болгоод байна гэж үзэж буй. Санхүүгийн зэх зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг “Валютын ханш бол макро хүчин зүйлээс шалтгаалж буй асуудал. Хэн нэгний захиалга биш гэдэг нь ойлгомжтой. Энэ макро суурь хүчин зүйлүүд нь өмнө гаргасан бидний алдаанаас үүдэлтэй. Урт хугацаанд эдийн засгийн суурь хүчин зүйлүүдээ бэхжүүлж чадсангүй. Экспортыг дэмжинэ гэснээ хийж чадаагүй байгаа. Эдийн засгийн аливаа буруу үйл ажиллагаа үр дагавар гэдэг эргээд хямрал болж гарч ирдэг” хэмээн хэлсэн юм. Дэлхийн банкны ахлах эдийн засагч “Эрэлт нийлүүлтийнхээ зарчмаар зах зээл валютынхаа ханшийг тодорхойлоод явах нь зөв. Зохистой валютын зохицуулалт нь Монголын экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, зах зээлийн үнийн механизмаар импортын эрэлт ч багасна” хэмээж байна.

Ханшийн хамгаалалт, дохио болгон ашиглаж, зах зээлийн жамаар нь явуульа гэсэн санал олон эдийн засагч, шинжээч, мэргэжилтнүүдээс гарч байгаа. Гэвч инфляцийг онилох бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тогтмол ханшийг огцом чөлөөлж хэлбэлзэл үүсгэлгүй аажим шилжилт хийх нь тодорхой улсын туршлагаас үр дүнтэй болох нь харагдаж байгааг СЭЗДС-ийн Экономиксийн тэнхимийн багш, магистр Д.Түвшинжаргал сануулсныг энд дурдах нь зүйтэй болов уу.

УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл валютын зах зээлийн дэглэмээ илүү тодорхой болгож тогтоох шаардлага өнөөдөр тулж буйг онцолж хэлсэн. Мөн тэрбээр зөвхөн банк хоорондын зах зээл биш өрсөлдөөнт орчинд оруулах, банк бус санхүүгийн байгууллагууд, томоохон экспортлогч, импортлогчдыг оруулах хэрэгтэй. Ингэснээр валютын зах зээлд үүсч байгаа ханшийн эрсдэлээс хамгаалах үүсмэл хэрэгслүүд орж ирнэ. Үүний тулд хууль, эрх зүй, зохион байгуулалтын ажил хэрэгжүүлэх нь зайлшгүйг хэлж байсан юм.

Өнөөдрийн түвшинд уул уурхайн орлогыг хүлээж суух бус олон улсад бонд, үнэт цаас гаргаж, төрийн өмчийг

хувьчилж валютын алдагдлаасаа гарч болохыг санхүүгийн зах зээлийн холбооны шинжээчид санал болгож буй. Харин урт хугацаанд валютын орох, гарах урсгалын зөрүүг арилгах зам бол гадаадын хөрөнгө оруулалт, экспортын орлогоо нэмэгдүүлэх явдал хэмээж буй.

Монголбанкы зүгээс ирэх жил инфляцийгонилохоосимпортыггорлох, экспортыг дэмжих бодлого барьж ажиллахаа хэлж буй. Н.Золжаргал ерөнхийлөгч “Дотоодын үйлдвэрлэл хөгжихгүй бол валютын ханшийн савалгаа мөнхөд үргэлжилнэ” гэв. Өөрөөр хэлбэл экспортын сагсанд түүхий эдээс гадна үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн орж, байр сууриа зузаатгахгүй аваас ханш савалсаар байх аж. Үүнтэй санал нэгдэх эдийн засагч ч олон бий. Б.Эрдэнэбат багш “Одоогийн ханшийг би харьцангуй засварлагдчихсан, өрсөлдөх чадвартай болсон гэж харж байгаа. Импортын бүтээгдэхүүн Монголынхтой харьцуулахад нэлээд үнэтэй болж. Үүнийг нөгөөтэйгүүр бидэнд олдож байгаа боломж гэж

харж болно. Импортын бүтээгдэхүүн үнэтэй болчихсон ч дотоодын ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ үнийг өсгөлгүй үлдээвэл импорт шахагдаж, зах зээлд эзлэх хувь хэмжээгээ өсгөж чадна. Ингэвэл өрсөлдөх чадвар өсч, өргөжих боломж нэмэгдэнэ” хэмээн үндэсний үйлдвэрлэгчдэд зөвлөсөн.

Ханшийн савалгаа ерөнхийдөө тогтворжиж байгаа нь сайн хэрэг ч дахин савлах уу гэсэн айдас түмний бодолд хургаж. Гадаад талаас Хятадын эдийн засгийн өсөлт, Европ, Америкийн эдийн засаг хэр хурдан сэргэх мөн Америкийн төвбанкны мөнгөний бодлого, хүүгийн түвшин ямар байхаас шалтгаална. Гэсэн ч манай улсын хувьд дотоод хүчин зүйлээс ихээхэн шалтгаалж байгааг эдийн засагчид хэлж байгаа. Ирэх жил урсгал тэнцлийнхээ алдагдлыг хэр бага түвшинд байлгаж чадах, төсвийн тэлэх бодлого үргэлжлэх эсэх түүнчлэн 2014 онд төсөв ямар царайтай батлагдахаас ханш хаачих аа шийднэ. Гэхдээ зах зээлийн жамаа дагавал шүү дээ. ■

## ХӨРШ

# ТЭДНИЙ СОНИРХОЛ

## Б.ЖАРГАЛ

Монголын импортын зах зээлийн Мэцэг, эх гэлтэй хөршүүд маань биднийг өрх тусгаарлаж, биеэ даах цаг болсон гэж үзэж буй бололтой. Тэдний “хайр” өдрөөр алсарч хилийн битгий хэл тивийн цаана байх оронтой эдийн засгийн ураг барилцахаар шийдэж. Гэр бүлдээ шинээр элсүүлэхээр санаархаж буй орон нь өрийн дүнгээрээ цойлж буй Грек ажээ.

## Хувьчлах замаар өмчлөх нь

Өрийн хямралаас гарахын тулд улсаа “хувьчлан” эдийн засгаа аврах гэж буй Грект оросууд талтай байна. Тухайлбал, тус улсын төмөр замын “Trainose” компанийн хувьцааг урд хөршийн “Russian Railways RZD” компани 100 хувь эзэмших нь гэх яриа тархаад буй. Үүний зэрэгцээ байгалийн хийн олборлолтоороо дэлхийд тэргүүлэгч “Gazprom” Грекийн байгалийн хий ▶



► олборлогч, төрийн өмчит “Dera” компанитай хэлэлцээрийн ширээнд суун “хуучнаа” дурсах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Грекийн талаас дээрх асуудалд нааштай хариу өгсөн төдийгүй “Gazprom”-ийн санаачилгыг дэмжин ажиллах талаар мэдэгдсэн байна.

Оросын Парламентийн дээд танхимын гишүүн Валентина Матвиенко “Манай Засгийн газар Грекийн эдийн засгийг ихээхэн сонирхож байгаа. Энэ утгаараа миний бие болон тодорхой хэдэн салбарын хөрөнгө оруулагчид эх орноо төлөөлөн тус улсыг зорихоор зэхэж байна” гэжээ. Мөн тэрбээр “Бид тэднээс эд хөрөнгийг нь булаах гэсэнгүй. Харин хүнд нөхцөлд орсон анд, нөхөддөө тусламжийн гараа сунгах чин эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэх зорилготой” хэмээн онцолсон байна.

Грекийн Засгийн газрын үзэж буйгаар төмөр замын үндэсний компани хувьчлах нь тус улсын эдийн засагт 19 тэрбум евро төвлөрүүлэх бөгөөд энэ хэмжээгээрээ өрийн дарамтаас ангижрах аж. Төмөр замын эл хэлэлцээр биелэлээ олвоос ОХУ тус улсад жилд гурван тэрбум хүртэлх еврогийн хөрөнгө оруулалт хийх бөгөөд ингэснээр Грек Евро-Азийг холбосон төмөр замын сүлжээний нэг хэсэг болж, зорчигдоос гадна бараа бүтээгдэхүүн тээвэрлэх ажээ. “Trainose” төрийн өмчит компани нь нэг жилд 15 сая зорчигч, 4.5 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай

бөгөөд ингэсэн тохиолдолд 148.2 сая еврогийн цэвэр ашигтай ажиллах боломжтой гэнэ. Тус компнийг өнгөрсөн долдугаар сард 30 сая еврогоор үнэлжээ.

Сүүлийн зургаан жилийн турш эдийн засгийн хүнд байдлаасаа салаагүй Грек улсын хувьд төрийн өмчит комданиудаа хувьчилж, төсвийн алдагдалаа нөхөхөөс өөр зам үлдээгүй аж. Грек төрийн өмчит “Dera” байгалийн хий олборлогч компани худалдах шийд гаргасан ч амжилт ололгүй өдийг хүрчээ. “Gazprom”-ийн зүгээс тус компанийг худалдан авах саналаа саяхан ирүүлсэн бөгөөд хэлэлцэх шатанд явж байна.

Манай хойд хөрш болон Грек улс нь аялал жуулчлалын салбараар дамжуулан эдийн засгийн “нөхөрлөл”-ийн урт түүхтэй. Өнгөрсөн онд л гэхэд 1.2 сая орос амралтаа Грект өнгөрүүлсэн гэх статистик гарчээ. Түүнчлэн орос жуулчид аяллынхаа туршид дунджаар 1000 евро бэлэг дурсгалын эд зүйлс авахад зарцуулдаг гэсэн тоог нэгтгэвэл Грекийн эдийн засагт шууд орох боломжит мөнгөн дүн асар их болохыг Оросын Парламентийн дээд танхимын гишүүн Валентина Матвиенко онцолсон байна. Иймд хоёр улс визний нөхцөлүүдээ хөнгөвчлөх талаар ярилцан, улмаар Грекийн зорих орос жуулчдын тоог нэмэгдүүлэх асуудлаар хэлэлцэхээр тохирчээ.

## Хятад аргаар хөгжих нь

Хямарч яваа Грект туслах хөрөнгө оруулагч цөөн. Харин Хятад аргаар хөгжиж, эдийн засгаа хөлжүүлэх боломж бий гэдгийг урд хөршийн эдийн засагчид төдийгүй хөрөнгө оруулагчид хэлж байна. Хятад аргаар хөгжинө гэж яг юуг хэлдэг вэ гэвэл “Бүх газар бизнесийн боломж бий” гэх зарчмаар ажиллах аж. Өөрөөр хэлбэл, хоосон авдраас хоол олж иднэ гэсэн үг. Тусламжийн гараа сунгасан бүхэнд үүдээ нээхэд бэлэн байгаа Грек улс хөрөнгө оруулалт, хувьчлалын замаар 2015 он гэхэд 50 тэрбум евро босгоно хэмээн тооцоолсон. Гэвч энэ таамаг талаар болж ердөө 11 тэрбум евро босгох боломжтой болсон. Хөгжингүй орнуудаас хөрөнгө ирэхгүй болсон тул хөгжиж буй орнууд руу хандахаас өөр зам тэдэнд үгүй болжээ. Ийм ч учраас Грекийн Ерөнхий сайд Антохис Самарас өнгөрсөн саруудад Хятад тэргүүтэй Азийн орнуудад айлчлал хийн худалдааны “меню”-гээ танилцуулах болов. Тус цэсэнд усан боомт, нисэх онгоцны буудлаас эхлээд төрийн өмчит байгууллагууд багтах агаад 250 мянган еврогийн хөрөнгө оруулалтаар иргэншил “худалдан авах” сонголт ч бий аж.

Хятадын төрийн өмчит “Cosco” тээвэр жуучийн компани нь Грекийн Пирей боомтын нэгэн гарцыг сэргээн засварлах, үйл ажиллагааг нь дэмжих үүднээс 500 сая еврогийн хөрөнгө оруулалт хийжээ. Энэ нь Грект хямралын жилүүдэд орсон хамгийн том шууд хөрөнгө оруулалт болсон бөгөөд Хятад улсын хувьд Европ руу нэвтрэх “ногоон тасалбар” болсон гэх. “Cosco” компанийн ерөнхий менежер Жанг Анмин “Бид бизнесийн боломж олж харсан. Амжилттай ч явна. Бид Грект хэрэгтэй байгаатай адил Грек ч бидэнд хэрэгтэй” гэв. Пирей боомтын ажилчдын холбооны нарийн бичгийн дарга Гиоргос Гогос “Хятадын бодлого үргэлж амиа хичээсэн байдаг. Манай улсын эдийн засгийн эмзэг байдлыг ашиглаж байна. Хэн ч үнэгүй зүйл өгдөггүй, тэр дундаа хятадууд” хэмээн дургүйцлээ илэрхийлсэн байна.

Хэдийгээр нутгийн иргэдтэй ►

► халз “тулалдах” шаардлага Хятадын компаниудад гарч буй ч хоёр улс харилцаагаа өргөтгөх нь тал бүрийн ашигтай аж. Тухайлбал, урд хөршийн зах зээлээр дамжуулан Грек өрсөлдөх чадваргүй болсон экспортын салбараа өөд нь татах боломжтой юм. Жишээлбэл, “Frutor” хэмээх ундаа үйлдвэрлэгч компани өнгөрсөн жил бүтээгдэхүүнээ Хятадын зах зээлд нэвтрүүлснээр экспортоо гурав дахин өсгөсөн байна. Тус компанийн экспорт хариуцсан менежер Эви Морфониди “Грекийн үйлдвэрлэгч компаниудад шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж байгаа. Хятад, зах зээлийн хамрах хүрээгээсээ хамааран, бидний эхний сонголт болж байна. Манай улсын бүтээгдэхүүнийг ч тэд

сайшаан хүлээн авах болсон” хэмээн онцолсон. Мөн тэрбээр Хятадын зах зээлийн Грекийн эдийн засгийг аварна гэдэгт итгэл төгс байгаа аж.

Аялал жуучлалаар алдартай Грек улсын боловсролын салбарыг хятадууд “эзлэх” бололтой. Афин хотын хамгийн том гэгдэх “Сионтри” хэлний сургууль 2005 онд Хятад хэлний анги нээжээ. Энэ үед ердөө тавхан оюутан сурч байсан бол өдгөө тус сургуулийн хоёр дахь том хэлний анги болсон байх жишээтэй. Тус ангийн оюутнууд ч “Хятад хэл сурах нь ирээдүйтэй. Учир нь хоёр жилийн дараа гэхэд бидэнд энд ажил олдохгүй байх эрсдэлтэй. Энэ үед Хятадад очиж ажиллах хэрэгтэй болно” хэмээн ярьцгаадаг ажээ.

## Гэрэл өөд

Грекийн Засгийн газар тив дотроо нэр хүндээ алдсан. Харин наран мандах зүгийн орнууд хүнд үед нь ийн “тусалж” байгаад тэд талархаж байна. “Дорнын зүгт ирээдүй арай гэрэлтэй харагдаж байгаа тул грекчүүд тийшээ тэмүүлэх болсон” хэмээн хөршүүдийн эдийн засагчид тайлбарлаж буй. “Эрлэгт явчихаасаа өмнө ийн ухаалаг хийгээд эрсдэлтэй шийд гаргаж байгааг нь үнэлэх хэрэгтэй” хэмээн тэд онцолж байна. Хятадын хувьд Грек Европын холбоонд үг хэлэх эрх эдлэх боломж бол хойд хөршийн төлөвлөгөөнд Евро-Азийн худалдааны бүсийг дэд бүтэц, эрчим хүчтэй нь “эзлэх” оролдлого хэмээн буужээ. ■

## ЯРИЛЦЛАГА

# САЛХИ ХАГАЛАГЧДААС ИТГЭЛ ЭХЭЛНЭ

Б.МЭРГЭН

**М**анай сэтгүүлийн баг өнгөрсөн долдугаар сард Лондонд ажиллах үеэрээ Лондонгийн хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн газрын орлогч дарга Жон Эдвардстай ярилцаж амжсан юм. Тэрбээр ОХУ болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн орнуудад тус биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлыг хариуцдаг. Жон Эдвардс ОХУ, Казакстан, Украйн болон Монгол Улс руу ажлын журмаар тогтмол аялдаг байна. Тэрбээр Колумбийн их сургуульд суралцаж, Орос судлалын бакалаврын зэрэг, мөн бизнес, хууль хосолсон чиглэлээр магистрийн зэрэг хамгаалсан бөгөөд 2003 оны наймдугаар сараас хойш ЛХБ-д ажиллаж байгаа аж. ►



Фотог Э.Зоригт

Лондонгийн хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн газрын орлогч дарга Жон Эдвардс

► **-Та Монголд олон удаа ирж байсан. Монголын санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгийн зах зээлийн талаар Таны бодол?**

-Монголын зах зээлийг их эрчтэй гэж боддог. Залуу зах зээл ч, ялангуяа Монголоос төрөн гарч буй шинэ уул уурхайн компаниудад боломж их байна. Гаднынхны сонирхол их байгаа нь дотоодын хүчтэй хүсэл эрмэлзлэлтэй нийцэж, хөгжлийн шинэ түүхүүдийг бичих үндэс болж байна. Энэ нь зөвхөн уул уурхайгаар хязгаарлагдахгүй бөгөөд аялал жуулчлал зэрэг туслах үйлчилгээ мөн багтана. Тиймээс Монгол Улс олон түвшинд анхаарал татаж буй. Хөрөнгийн зах зээлийн хувьд энэ бүгд онцгой боломж. Зах зээлээ бий болгохын тулд нэн тэргүүнд хийж бүтээсэн зүйлтэй, тодорхой туршлагатай байх шаардлагатай. Хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан ямар нэг зүйлтэй байх хэрэгтэй юм.

**-Түншлэлийн хүрээнд Монголын хөрөнгийн зах зээлтэй хуваалцах хамгийн чухал туршлагыг Та юу гэж бодож байна вэ?**

-Бидний хуваалцаж чадах хамгийн чухал хүч бол өдийг хүртэл бүрдүүлж чадсан хүрээлэл, сүлжээ гэж боддог. Бид хөрөнгө оруулагчдын өргөн сүлжээ, мэргэжлийн зөвлөхүүдээ Монголын зах зээлд татан оролцуулах бүрэн чадамжтай. Мөн Монголын компаниудыг энд авчирч хөрөнгө оруулагч, мэргэжилтнүүдтэйгээ уулзуулж байсан удаатай. Энэ бол манай хоёр биржийн хамтын ажиллагаа. Монголын зах зээлд илүү олон хөрөнгө оруулагч татах нь түншлэлийн нэг хэсэг. Бид давхар бүртгэлийн боломжийг ихээхэн сонирхож байгаа. Монголын хөрөнгийн биржээр дамжуулан Монголын компаниуд Лондонд Дэлхийн үнэт цаасны хадгалалтын бичиг (GDR-global depository receipt)-тэй болох боломжтой. Мөн Монголын хөрөнгийн бирж өөрийн бүртгэлийн жагсаалтаа хадгалж авч үлдэхэд тусална.

**-Лондонгийн хөрөнгийн биржийг дэлхийн шилдгүүдийн нэг гэлцдэг. Цөөн үгээр амжилтын хүчин зүйлсээ тодорхойлохгүй юу?**

-ЛХБ үйлчилгээгээ сайжруулах шинэ арга замыг байнга эрэлхийлж, улмаар арилжаанд оролцогчдод хамгийн сайн үйлчилгээ хүргэхэд бэлэн байдагтай холбоотой. Тэд бол компаниуд, хөрөнгө оруулагчид, зуучлагчид юм. Олон оролцогч тал байдаг учир биржийн ажил

маш хэцүү. Энэ бол бидний МХБ-тэй хамтран ажиллаж, ойлгохыг хичээж буй нэг зүйл. Өргөн хүрээний оролцогч талуудтай байх нь хүндрэлтэй. Хоорондоо харилцан адилгүй бүлгүүдийн санаанд тааруулна гэдэг амар биш. Зарим тохиолдолд компаниудын дунд хэвийн үйлчилдэг зүйлс хөрөнгө оруулагчдад таарахгүй байх нь элбэг тохиох тул алтан дунджийг барих нь оновчтой. Энэ бол ЛХБ-ийн үнэхээр сайн хийж чадсан зүйл.

**-Лондонгийн хөрөнгийн зах зээл дэлхий дахинд хаашаа замнаж байгаа вэ?**

-Өргөн хүрээг хамрах асуулт байна. Тэр дундаа ЛХБ-ийн байр сууриас харвал манай бирж дэлхийн эдийн засгийн хөгжилд амин чухал үүргийг гүйцэтгэсэн хэвээр байна гэдэгт бид итгэдэг. Тиймээс ч Монгол Улсын Засгийн газраас олон улсын түнш татах зорилгоор МХБ-ийг орчин үеийн бирж болгон өөрчлөхийг дэмжсэн шийдвэр гаргасан нь үнэхээр алсыг харсан алхам болсон. Үүний тулд улсынхаа нөөц, баялгийг хөшүүрэгдэж, өсөлтөө хурдасгах нь чухал юм. Аль ч оронд шинэ бизнесийн өсөлтөд дэмжлэг болох хөрөнгө оруулалтыг татахад зах зээл болон хөрөнгийн бирж чухал үүрэг гүйцэтгэж, тэдгээрийг хурдасгуур болгон ашигладгийг харж болно. Энэ нь аливаа улс орны эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой. Олон зүйл өөрчлөгдөж болох ч хөрөнгийн бирж үлдэнэ.

**-Монгол Улсын шинэ Үнэт цаасны тухай хуулийг Та хэрхэн үнэлж байна вэ?**

-Миний зүгээс үнэлэлт, дүгнэлт гаргахыг урьтал болгохгүй. Гэхдээ Үнэт цаасны тухай хуулиар олон улсын тоглогчид болон хөрөнгө оруулагчдын зарим үндсэн хүсэлт, шаардлагыг гарцаагүй шийдвэрлэж чадсан гэж бодож байна. Эхэлсэн өдрөөсөө л төгс боловсронгуй болдог зүйл гэж хаа ч үгүй. Эхлүүлээд, хэрэгжүүлээд ирэхээр хувьсал, өөрчлөлт бий болдог. Анхны алхмын хувьд гарцаагүй урагшилсан, сайн алхам болсон гэж бодож байна.

**-Тэгэхээр үндсэн шаардлагад нийцсэн хууль болсон гэж Та бодож байна уу?**

-Тийм. Энэ хуульд хийсэн маш чухал өөрчлөлт бол монголчууд болон олон улсын хөрөнгө оруулагчдын санал бодлыг бүх шатанд авч үзсэн явдал. Хуулийг гаргахдаа сайтар хэлэлцэж, зөвлөлдсөн гэж бодож байгаа. Хуульд олон санал, хүсэлт тусгасан гэж бодож байна.

**-Төрийн өмчит компаниудыг хувьчлах үүднээс МХБ-ийг байгуулсан. Монгол Улс өдгөө арай өөрөөр өсч, хөгжихийг чармайж буй. Харин энэ зах зээлд монголчуудыг хэрхэн оролцуулах вэ. Энэ тохиолдолд түншлэл юу хийж чадах вэ?**

-Түншлэлийн нэг хэсэг бол боловсрол, тэр дундаа хувьцааны зах зээл дээрх олон нийтэд зориулсан боловсрол. Энэ бол хоёр биржийн хамтран ажиллаж буй талбар юм. Энэ мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэх талаар бид уулзалт, хэлэлцээр хийж байгаа. Үүнд брокеруудын гүйцэтгэх үүрэг маш чухал. Учир нь тэд зуучлагчид. Ихэнх тохиолдолд олон хөрөнгө оруулагчтай харилцдаг нь тэд. Бид брокеруудын боловсролд зориулан олон зүйл хийдэг бөгөөд Монголын брокеруудад зориулан боловсрол, маркетинг, олон нийтэд таниулан сурталчлах зэргийг багтаасан арга хэмжээг Лондонд зохион байгуулсан. Үүний зэрэгцээ бидний зүгээс брокеруудад тусгайлан анхаарч өөрсдийн байнгын үйлчлүүлэгчидтэй, үр дүнтэй ажиллахад нь шаардлагатай бүхэн байгаа эсэхт анхаардаг.

**-Монголын санхүүгийн зах зээлийг харвал хөрөнгийн зах зээл болон банкны салбарын тэнцвэрт байдал сайн биш. Таны бодлоор хөрөнгийн зах зээлийг хэрхэн хүчтэй хөшүүргэдэж болох вэ?**

-Тохиромжтой компаниудтай байх асуудал дахин сөхөгдөнө. Ийм компаниудтай болохын тулд үйл ажиллагаа явуулах тохиромжтой газар болон олон нийтийн зах зээл гэдэг итгэл үнэмшлийг төрүүлэх хэрэгтэй. Томоохон болон олон улсын тоглогчдыг урдаа барьж эхэлбэл бусад компани араас нь дагах нөхцөл бүрдэнэ. Энэ бол аажмаар үйл хэрэг болох явц. Амжилттай явж ирсэн компаниудын түүхийг сөхөн харж, тэднийг татан оролцуулахад чиглэж ажиллах нь зүйтэй. Тэд орж ирснээр, бусад нь ч дагана. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн шатыг түргэсгэх арга байж болно.

**-Ашигт малтмалын тухай хуулийн төслийн талаар олон хэлэлцүүлэг өрнөсөн. Монголын стратегийн ордууд Монголын хөрөнгийн биржээр заавал дамжих ёстой гэсэн заалтыг аваад хаячихсан. Тус заалт байсан эсвэл байгаагүйн нөлөө юу байх вэ?**

-Давхар бүртгэл хийж болох хосолмол зах зээлтэй байх нь, тэр ►►



Фотог э.Зоригт

дундаа уул уурхайн салбарт ихээхэн түлхэц болдогийг миний ажиллаж байсан ОХУ-ын зах зээлийн амжилт гэрчилнэ. Бид дотоодын хөрөнгө оруулагчдыг “Дэлхийн хадгалалтын бичиг” (GDR)-тэй болгосноор үнийн өөрчлөлтийг брокеруудаар хөнгөвчлүүлэх боломжтой болох юм. Ингэснээр хөрвөх чадвар бий болно. Ялангуяа зарим томоохон компанийн хувьд энэ нь маш хэрэгтэй. Харин жижиг компаниудад зориулан хөрөнгө оруулагчдыг татах түншлэлийн ажлаа улам эрчимжүүлэх нь бидний хувьд чухал. Ингэснээр тухайн компани орон нутгийн зах зээл дээр хэрэгцээт хөрөнгө, мөнгөө өсгөх боломжтой болно. Энэ үйл явцыг хөнгөвчлөхийн тулд дотоодын хөрөнгө бий болгох шаардлагатай. Харин дотоодын хөрөнгийн биржийн асуудлаар дан ганц гаднын хөрөнгө оруулагчдад найдаж болохгүй. Дотоодын хөрөнгө оруулагчдад тулгуурлан тухайн зах зээл улам хүчирхэгжиж байх учиртай. Үр нөлөө нь ямар байх талаас баруун руу чиглэсэн томоохон урсгал бий болно гэж би бодохгүй байна. Компаниуд хөрөнгөө өсгөхөөр хаашаа явж байгаагаа маш нухацтай бодож, болгоомжтой хандах ёстой. Дотоодын хөрөнгийн бирж бий болгохдоо зайлшгүй эрэлт, хэрэгцээнд тулгуурлах ёстой болохоос биш хиймлээр хийж болохгүй. Компаниуд дараагийн шатанд гарахын тулд хөрөнгөө өсгөх шаардлагад тулдаг. Тэд хөрөнгөө хаана

өсгөж болохыг чадварлаг зах зээл зааж, чиглүүлж өгдөг. Бидний ажил бол Монголд болон МХБ-д дээрх хөрөнгийг хангалттай босгож болох тогтолцоог бүрдүүлэх юм.

**-Монголын хөрөнгийн зах зээлд томоохон хөрөнгө оруулагчид л хэрэгтэй байгаа. Тэднийг татахын тулд бид юу хийх вэ?**

-Энэ тал дээр олон асуудал байгаа. Зарим нь макро түвшний асуудал бол зарим нь тохиромжтой зах зээлийн гарц нээгдэхийг хүлээж буй. Үүний зэрэгцээ хөрөнгө болон тээврийн үйлчилгээ зэрэг салбар Монголд хурдацтай хөгжиж байна. Уул уурхайн салбар хүчээ авч, тасралтгүй өсч эхлэх үед Монголын компаниуд өөрсдөө зах зээлээ туршин гарч ирэх хэрэгтэй. Томоохон хөрөнгө оруулагчидтай болохын тулд томоохон компаниуд зах зээлд орж ирэхийг хүлээх шаардлагатай байна. Эцсийн эцэст, хөрөнгө оруулагчид арилжих үнэт цаасуудыг л хүсдэг. Дутагдаад байгаа нь энэ. Компаниуд шинээр гарч ирж, улмаар зах зээлд нэвтрэх үед л бид томоохон хөрөнгө оруулагчид орж ирэхийг харна.

**-Төрийн өмчит зарим компанийг одоо хувьчилж эхлэх нь зүйтэй гэж Та бодож байна уу ?**

-Хувьчлал бол тухайн нөхцөл байдал бүрээр нь авч үздэг зүйл. Тодорхой салбар, компанид ойлгомжтой асуудал. Энэ нь мөн хувьчлалыг хэрхэн хийж,

хэрхэн компанийн шилжилтийг хийх гэж байгаа тухай юм. Хэрэв хувьчлалыг олон нийтийн зах зээл дээр хийвэл компанийн шинэ хэлбэр юу байхав. Хувьчлал хийх тохиромжтой хувилбарыг гаргахын тулд холбогдох мэргэжилтэн, зөвлөхүүдийг оролцуулах шаардлагатай болдог тул хүндхэн ажил байдаг. Энэ нь тодорхой нөхцөл байдалд үйлчилдэг. Азаар Монголын хувьд бусад зах зээл, тэр дундаа хөрш орнуудынхаа зах зээлээс жишээ авч хувьчлалыг хэрхэн хийснийг үлгэрлэх боломж байна. Хувьчлалыг тохиолдол тус бүрээр нь тусгайлан авч үзэх шаардлагатай. Ерөнхийдөө энэ нь бизнесийн үйл ажиллагааг түлхэх, шинэ оролцогч талууд, үр ашгийг авчрах талаасаа үр дүнтэй үйл явц.

**-Монголын компаниуд хөрөнгийн бирж дээр IPO гаргах төдийлэн сонирхолгүй болоод байгаа. Тэгвэл тэдний анхаарлыг хэрхэн татах вэ?**

-Тэдгээр хөрөнгө оруулалтын компанийг татах нь шургуу ажиллахтай л холбоотой. Тодорхой бөгөөд ойлгомжтой дүрэм, журамтай байх хэрэгтэй гэсэн үг. Үүний тулд бидэнд “салхи хагалагчид” хэрэгтэй байна. Гэвч тэднийг оруулж ирэхийн тулд итгэл хэрэгтэй. Бусдаас түрүүлж итгэл хүлээлгэх компани байж л таарна.Тэдний араас л явах хэрэгтэй. МХБ боломжийг сайн эрэлхийлэх ёстой. Учир нь Монголын компаниудыг татах, тэдгээрийн хөрөнгийг өсгөх энэ ажлыг ▶▶

▶ эхлүүлж чадах брокерууд тэнд ажиллаж байгаа бөгөөд тэдэнд жагсаалт үүсгэх ихээхэн боломж байдаг. Үүнийг эхлүүлж чадвал бизнесийн шинэ эгнээтэй болно. Та нарын хувьд гадаад валютад толгойгоо бүрэн мэдүүлчихсэн улс биш. Бизнесийн тусдаа хэсгүүдтэй шүү дээ. Энэ нь тайлан тэнцэлд ч сайнаар нөлөөлдөг. Эхлээд хийх ёстой хамгийн чухал зүйл бол итгэл төрүүлэх.

**-Засгийн газрын зүгээс хөрөнгийн зах зээлд үзүүлэх ямар дэмжлэг байж болох вэ?**

-Үүнтэй холбоотойгоор хөрөнгийн зах зээлийг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг асуулт гарч ирнэ. Тэтгэврийн сангийн шинэчлэл, дотоодын хөрөнгийг бий болгох зэрэг арга хэмжээ бий. Дотоодын урсгалыг дэмжихэд дээрхүүд чухал ач холбогдолтой. Хэдийгээр бүх хариулт надад байхгүй ч дээрх сонголтууд анхаарч авч үзэх ёстой ажлууд. Дүрэм журмаа нэн тэргүүнд харах хэрэгтэй. Бидний зүгээс гаднын хөрөнгө оруулагчдыг “мөшгиж” чадах бол Монголын тал дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжсэн ажил хийх нь чухал. УИХ-аар хэлэлцүүлбэл зохих дараагийн асуудал энэ ч байж болох юм.

**-Хөгжиж буй орнууд хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхэд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг. Харин Монголын хувьд хэр хугацааг зарцуулах бол?**

-Бусад зах зээлийг харахад тухайлбал, ОХУ-ын эдийн засаг ерээд онд богино хугацаанд амжилттай хөгжсөн түүхтэй. Тухайн үед “Renaissance Capital” тэргүүтэй брокеруудын үйл ажиллагаа дөнгөж эхэлж байв. Тэд байгууллага болон дотоодын эрэлт, хэрэгцээнд хариулах, шийдвэрлэх чадвартаа тулгуурлан хурдацтай хөгжиж чадсан юм. Тус улсын хувьд томоохон компаниуд зах зээлд орж ирсэн нь ихээхэн дэмжсэн байдаг. Монголын хувьд төстэй боломж бий. Тэгэхээр энэ нь ердөө зах зээлийн хувьд цаг хугацааны асуудал бөгөөд эдгээр томоохон хөрөнгийн боломж ороод ирвэл цаашид гаднын хөрөнгө оруулагч байгууллагууд дагах нь тодорхой. Мөн дотоодын хөрөнгө оруулагчид зах зээлд оролцож эхлэх бөгөөд брокерууд үүнийг ойлгон мэдэрч, тухайн эрэлтийг хариулах чадвар сууна. Энэхүү үйл явц эхлэх үед одоогийн дотоодын брокеруудыг улам бэхжүүлнэ. Олон улсын брокерууд ч судалгаа явуулах болно. ■

**АЗИЙН БАНКНЫ ХОЛБООНЫ 30 ДУГААР ЧУУЛГАН**

# ХӨРӨНГӨ “ШАНАГАДАХ” БОЛОМЖ

**Б.ЦЭЦЭЭ**

Намрын налгар есдүгээр сарын дунд үед “Blue Sky”-н Очир эрдэнийн танхимыг Азийн банкирууд хоёр өдөр эзэгнэж, санал бодлоо нэгтгэсэн нь дэлхийн эдийн засгийг хөдөлгөх гол хүчээр Азийг тодорхойлж, банкны салбарын дүрийг тодотгох гэсэн эрмэлзлэлээс үүдэлтэй. Азийн банкны холбооны 30 дугаар чуулган энэ жил “Ази тив: Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр” хэмээх даацтай, далайцтай хөгжлийн хандлагаар хурлаа “малгайлсан” билээ.

Евробүсийн сунжирсан зогсолт, АНУ болон Японы тэнгэрт тулсан өр, төсвийн алдагдал болон эдийн засгийн сул тэлэлт нь дэлхийн эдийн засгийг эерэг зөгнөхөд эртдэж буйг харуулсаар. Хөгжингүй орнуудын эрэлт багасч, дэлхийг “дайвалзуулсан” эдийн засгийн их давалгаа Ази Номхон далайн орнуудыг ч тойролгүй дайрч, өсөлт саарч, экспорт огцом суларсан. Гэсэн ч хүн амын нягт төвлөрөлтэй Азийн хөгжиж буй орнуудын дотоодын эрэлт, гаднын хөрөнгө оруулалтын ширүүн урсгал, засгийн газруудын дэд бүтэцдээ цутгаж буй үлэмж хөрөнгө оруулалт нь хямралыг эсэргүүцэх үүлэн чөлөө болж буй юм. Ази, Номхон далайн бүс нутаг нь дэлхийн хүн амын 40 хувь, дэлхийн нийт бүтээгдэхүүнийн 50 хувийг бүрдүүлдэг нь манай гаригийн хөгжилд тус бүс нутаг ямар байр суурь эзэлдэгийг мөн хэрхэн нөлөө үзүүлж чадахыг харуулж буй. Эдийн засгийн тодорхой салбаруудыг дэмжих замаар банкны салбар Ази тивийн эдийн засгийн өсөлтийг хэрхэн өргөж болох вэ гэдгийг Азийн банкирууд голчлон ярилцсан юм.

Европ өрийн хямралд автаж, хөрөнгө оруулалтын салбараас гараа хумьсан даруй орон зайг Азийн санхүүгийн зах зээл, тэр дундаа Азийн банкны салбар нөхөж, уул уурхайн салбарт шаардагдаж буй хөрөнгө оруулалтыг хийх болсон. Үүний нэг жишээ нь Австралийн уул уурхайн салбар дахь Азийн санхүүчдийн өсөн нэмэгдэж буй оролцоо.

Гэхдээ улс төрийн тогтворгүй байдал, дэд бүтцийн сул хөгжил, орлогын жигд бус хуваарилалт зэрэг асуудал Азид оршоор байгааг оролцогчид хэлж байлаа. Азийн хөгжлийн банкны төлөөлөгч Жае Ха Пак “Ази, тэр дундаа хөгжиж байгаа орнуудад тулгамдаж байгаа гол асуудал бол дундаж орлоготой орон өндөр орлоготой орны тоонд шилжиж чадахгүй байгаа юм. Энэ хавхнаас гарч чадвал 2050 он гэхэд Азийн хөгжиж буй орнууд өнөөгийн АНУ, Европ шиг хөгжингүй орон болох боломж бий. Үүний тулд эхлээд ядуурлыг бууруулах, улс төрийн хүсэл эрмэлзлэл, орлогын тэгш хуваарилалтыг дэмжих замаар дундаж давхаргыг бий болгох хэрэгтэй” гэв.

Их хүчийг нэгтгэн захирч, залахаар цугласан Азийн банкны холбооны ерөнхийлөгч Лорензо В.Тан тус чуулганы эхэнд болон төгсгөлд нь Монгол Улсыг 30 дугаар чуулганы суудлыг засах орноор сонгосон нь манай гишүүдийн хүсэл сонирхол гэдгийг онцлон хэлсэн билээ. Монголын Банкны холбооны ерөнхийлөгч М.Болд “Тус чуулганыг манай улсад зохион байгуулж байгаа нь Монголын банкууд холбоогоороо дамжуулан Азийн банкны салбартай хамтын хүчээр нэгдэж, улам нээлттэй болж байна гэсэн үг” хэмээв. ▶



Захирлуудын хэвлэлийн бага хурал

Фотог Э.Зоригт

► Чуулганд оролцогчдын хандлага, уур амьсгал ч үүнийг гэрчилж байлаа.

Олон улсын валютын сан хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтийг энэ жил 1.2 хувь, хөгжиж буй орнуудын эдийн засгийг таван хувь байна хэмээн таамагласан. Энэ тоо ч талаар болохгүйг тус сангийн төлөөлөгч Юко Киношита чуулганы эхэнд дуулгасан. Гэвч тэрбээр хөгжиж буй эдийн засгуудын хувьд өсөлт саарах хандлагатайг анхааруулсан бөгөөд нэг талаас санхүүгийн тогтвортой орчныг хангах, нөгөө талаас бодлогын дэмжлэг үзүүлэх гэсэн хоёр арга хэмжээний тэнцвэрийг олох тал дээр ихээхэн анхаарах хэрэгтэйг Азийн банкируудад зөвлөж байсан. Азийн эдийн засгийн хувьд гадаад талаас дэлхийн эдийн засгийн удаашрал, хөрөнгийн гадагшлах урсгал, дотоодоос санхүүгийн тогтворгүй байдал, бүтцийн сул байдал зэрэг ерөнхий эрсдэлүүд сорьж байгааг ОУВС-гийн төлөөлөгч хэлсэн.

Азийн банкирууд эхний өдөр Банкок, Малайз, Вьетнам, Монголын тэргүүлэх банкны үйл ажиллагаатай танилцаж, цаашдын чиг хандлагатай холбоотой асуулт, хариулт өрнүүлсэн. Азийн банкны салбарын хувьд Сингапур, Вьетнам, Филиппин тэргүүтэй зарим улсын хувьд жижиглэнгийн буюу иргэдийн зах зээлд түшиглэсэн банкны

үйлчилгээ давамгайлсан хандлагатай байдаг бол зүүн өмнөд Азийн орнуудын банкны салбар аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээгээр илүүрдэг байна. Харин Монгол Улсын хувьд хүн ам цөөн учир банкны салбарын үзүүлж болох бүх үйлчилгээг санал болгох нь амь зогоох үндэс нь болдог байна. Хасбанкны ерөнхий захирал Д.Бат-Очир “Манай банкны салбарыг өндөр хөгжсөн орнынхонтой харьцуулахад барааг нь харахгүй хэмжээнд хараахан алдчихаагүй яваа. Монгол Улс жижиг зах зээлтэй орон учир иргэдийн, эсвэл жижиг, дунд бизнес гэх мэтээр дагнавал банкны бизнес оршин тогтнохгүй. Тэгэхээр бүх боломжит хэсгүүд рүү орохоос өөр замгүй” хэмээсэн юм.

Гэсэн ч Ази тивийн дундаж түвшнийхний эзлэх хувь сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж буй нь жижиглэнгийн зээл өсөх нэг шалтгаан болж байгаа аж. Харин нөгөө талаас банкуудын зүгээс тивийн хэмжээнд дэд бүтэц, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах нь ихэсч байгааг илтгэгчид хэлж байсан юм.

Тус чуулганы үеэр цэвэр эрчим хүчний салбарыг ихээхэн онцолж, санхүүжилтийн хувьд илүү дэмжиж өгөх бодлогыг барих нь тивийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх талаар оролцогчид ярилаа. Хасбанк энэ үеэр эко төслүүдийг

дэмжих тал дээр илүү анхаарч ажилладгаа танилцуулж, “Цэвэр агаар” төсөлд оролцсоноо онцлов.

## Нэг үйлчилгээг шахаж буй нөгөө үйлчилгээ

Банкны салбарын хөгжлийг технологийн дэвшлээс салгах боломжгүй. Тиймээс энэ удаагийн чуулган дээр “McKinsey&Company” компанийн мэргэжилтэн банкны салбарын шинэ эрин болох цахим, гар утас, автоматжсан үйлчилгээний талаар мөн дэлгэлээ. Өнгөрсөн жилийн байдлаар банкны салбарын үйлчилгээ багасч гар утсаар гүйлгээ хийх нь огцом ихэсчээ. Европ тивийнхний хувьд салбарын хэрэглээ 2015 он гэхэд тавхан хувь байх бол утас, интернэт үйлчилгээ 68 хувьд хүрч байна. Цахим ертөнцийн огцом өөрчлөлт, дэвшилтэт технологийн хөгжлийг банк, санхүүгийн салбар сайтар ашиглаж чадахгүй бол төлбөр төлөх болон бусад үйлчилгээг өөр салбарт алдаж магадгүй аж.

Технологийн өндөр хөгжил нь нэг талаар шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох боломж ч нөгөө талаар нууцлал алдагдах эрсдэлийг дагуулахыг салбарынхан хэлсэн юм. “Dell” компанийн Ази, Номхон далай болон Японыг хариуцсан мэргэжилтэн Ноорул Хак “Банкны салбар технологи ►►

▶ болон цахим ертөнцтэй хөл нийлүүлэн алхаснаар амжилттай оршин тогтнох боломж гарч ирнэ. Тэр дундаа залууст зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж байгаа бол “Facebook”, “Twitter”-ийг зайлшгүй ашиглах хэрэгтэй. Мөн цахим банкыг ашиглах нь залууст илүү таалагддаг. Ер нь технологийн дэвшлийг дагаад дата мэдээлэл бүх салбарт бий болж байна. Тиймээс энэ төрлийн мэдээллийг хадгалах, хамгаалах, түгээх гээд олон асуудал бий” гэсэн юм. Монголын банкны салбарын хувьд цахим ертөнц болон технологийн дэвшлийг харьцангуй сайн ашигладаг гэдгийг талууд хэлж байсан. Монголын банкны салбарын хувьд өнөөгийн эдийн засаг, хэрэглэгчдийн түвшинд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ, нэвтрүүлж цаг үетэйгээ хөл нийлүүлэн явж байгааг манай банкны салбарынхан хэлж байсан юм.

Ази тивийн хүч түрэн хөгжиж буй эдийн засгуудыг Хятад, Энэтхэг, Индонез, Тайланд, Малайз хэмээн эрэмбэлсэн бол тэдний араас Индонез, Филлипин, Вьетнам, Лаос, Камбож, Монгол тэргүүтэй улс нэхэж явааг “GIA” группын Ази, Номхон далай хариуцсан дэд ерөнхийлөгч Николас Пишет илтгэлдээ дурьдсан. Тэрбээр Мьянмар улсыг илтгэлийнхээ гол орноор сонгон танилцуулж, Ази тивийн дараагийн бар болох боломж бүрдэж байгааг дуулгасан билээ.

Мьянмар улсыг тэрбээр 2030 он гэхэд үйлдвэрлэл, газар тариалан, дэд бүтэц тэргүүтэй долоон салбарын нөлөөгөөр 200 тэрбум ам.долларын эдийн засгийн бүтээмж хүртэх боломжтой гэв. Мөн Мьянмар улс хэдийгээр Монголын адил байгалийн нөөц ихтэй ч манай улсаас хүн амын хувьд хэд дахин давуу учир 2030 он гэхэд эдийн засгийн ач холбогдол бүхий хэрэглэгч нь 19 саяд хүрч 100 тэрбум ам.долларын эргэлтийн боломжийг дотоодын болон гаднын бизнес эрхлэгчдэд олгохоор байгаа аж. Тус улсын санхүүгийн үйлчилгээ 2030 гэхэд 50 дахин өснө гэж тооцоолсон нь хуралд оролцогчдын сонирхлыг өдөөж байв. Энэ нь нөгөө талаар Монгол Улсад өрсөлдөгч олон болж буйг сануулж байна гэж үзэх хүмүүс ч байлаа.

Ази тивд асуудал олон бий. Урт жагсаалт бүхий эрсдэл. Тэр дундаа

шийдвэр гаргах түвшинд амин судас мэдээллийн дутагдалтай байдал, баталгаагүй мэдээлэл зэрэг нь хамгийн том эрсдэл болж буйг банкны салбарынхан Ази тивийн хувьд онцолсон. Тэдний зүгээс шийдэл нь тун энгийн агаад зөв тогтолцоогоор судалгаа шинжилгээ хийлгэх, чадвартай хүмүүстэй хамтарч ажиллаж, тэдний тусламжтайгаар мэдээллийн боловсруулалт хийлгэх гэсэн юм.

Азийн банкны холбоо ч тодорхой асуудлууд дээр голчлон зааварчилгаа өгч ажилладаг гэдгээ энэ үе эрдурьдсан. Тэдний хувьд микро санхүүгийн орчинд гарч ирж буй боломжууд, гамшгаас урьдчилан сэргийлэх ба түүнийг даван туулах, мэдээллээр хангах ажлын хэсгүүдийг идэвхжүүлж удирдамж гаргах, Азийн банкуудад гадаад дансны хувьд татвар хэрхэн үйлчилж буйг хянах зэрэг ажлыг бодлогын түвшинд авч үзэж ажиллаж байгаа аж. Мөн Азийн банкны холбооны ерөнхийлөгч Тан Монголын банкуудын санхүүгийн

дутмаг эх үүсвэрийн асуудалд тусалж болно гэдгээ илэрхийлсэн билээ. Хэдийгээр ХХБ, Хас тэргүүтэй гадаад зах зээлээс санхүүжилт татсан банкууд байгаа ч бүх банк гаднаас хөрөнгө “шанагадах” бүрэн чадамж хараахан суугаагүй байгаа.

Манай улсад Азийн 16 орны банкны салбарын дээд хэмжээний 60 гаруй төлөөлөгч анх удаа цуглалаа. Цаашид үр ашигтайгаар банкны үйлчилгээг түгээх арга замыг сурах, нэгэнт хэрэглээнд нэвтэрчихсэн технологийг туршлагатай банкуудаас шууд авч хэрэглэх, Азийн банкуудын өдий хүртэл бий болгосон сүлжээг ашиглан хөрөнгө татах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг олон боломжийг тус чуулган манай улсад өгч байгааг онцолсон. Чуулганы чухал яриа өндөрлөсөн ч азиуд тэнгэрийн хөлгөөр улс дамнан гэрийн зүг жолоо залахаар яарсангүй. Харин Монголын хөдөө тал, нүүдэлчин соёл заншилтай танилцахаар Хэнтий аймгийн дархан цаазат газрыг зорьсон. ■

## ДААТГАЛ

# ДОГОЛОН ТОГТОЛЦОО



## ЭЗЭРИЙГ

Санхүүгийн салбар олон гар, хөлтэй. Гар, хөл бүр нь эрүүл байж сая уг салбар хөл дээрээ тогтож, бусадтайгаа өрсөлдөж чадна гэдэг. Гэтэл санхүүгийн салбарыг бүрдүүлдэг даатгал, үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулалтын сангийн аль аль нь Монголд хөгжөөгүй. Ганцхан тоо хэлэхэд, санхүүгийн салбарын 95 орчим хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна. Гэтэл ▶

▶ банк нь сонгодог утгаараа богино хугацааны хадгаламжид тулгуурласан зээл олгож ашиг олдог санхүүгийн нэг л арга хэрэгсэл. Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэн “Эдийн засаг өсөхийн хэрээр мөнгөний хэрэгцээ шаардлага их байгаа энэ үед санхүүгийн салбарын хөгжлийг сайжруулах хэрэгтэй. Ганцхан банкны салбарын мөрөн дээр байгаа ачааллыг хуваах үүднээс даатгалын салбарыг хөгжүүлэх шаардлага байна. Тэр дундаа урт хугацааны даатгал буюу амьдралын даатгалыг хөгжүүлснээр монголчууд хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэртэй болох боломжтой” гэв.

Гэтэл монголчуудад урт хугацаатай мөнгө хэрэгтэй болоход арилжааны банкинд хандахаас өөр аргагүй. Гэвч банкнаас зөвхөн өндөр хүүтэй, богино хугацаатай зээл л авч болно. Банкуудын хувьд үндсэн хадгалажийн төлбөрөө хүүгийн хамт төлөхийн хажуугаар үйл ажиллагаагаа өргөжүүлнэ, урт хугацааны зээл ихээр олгоно гэдэг амаргүй, бараг боломжгүй. Ингээд бодохоор Монголын санхүүгийн салбарыг “доголон” гэж хэлэхээс аргагүй. Гэтэл зарим хүн банкны салбар хөрөнгийн зах зээлд гарч хөрөнгө оруулалтын сан үүсгэх хэрэгтэй гэх нь бий. Энэ нь нэг талаар манайдаа л санхүүгийн шилдэг гэгдэх банкны салбараар санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх гэсэн санаа боловч эрсдэлтэй алхам аж. Монголын Банкны холбооны ерөнхийлөгч М.Болд “Банк хөрөнгийн бирж дээр гарч болохгүй. Энэ нь хадгаламж эзэмшигчдийн мөнгийг эрсдэлд оруулж буй хэрэг” гэсэн юм. Учир нь хадгаламж эзэмшигч хэзээ ч 10-20 магадгүй түүнээс дээш жил мөнгөө банкинд тогтвортой хадгалдаггүй. Хэзээ хадгаламжаа татах нь тодорхойгүй. Тиймээс арилжааны банкууд ихээр бодоход гурван жилийн хугацаатай зээл олгодог аж. Ийм үед урт хугацааны санхүүжилт гацаанд ордог. Үүний тод жишээ бол өнөөгийн моргейжийн зээл юм. Сүүлийн үеийн мэдээллээр Хас банк орон сууцны зээлийн урьдчилгааг 60, Төрийн банк 30-50, Худалдаа хөгжлийн банк 20-40, Капитал банк 30-50 хувь болгон

### Даатгалын хэлбэр

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2011.12.31	2012.12.31	Өөрчлөлт /+, -/
	Даатгалын нийт хураамжийн орлого		
Хөрөнгийн даатгал	12427.3	18716.6	6289.3
Автотээврийн хэрэгслийн даатгал	11880.3	15342.9	3462.6
Агаарын хөлгийн даатгал	5282.2	8570	3287.8
Хариуцлагын даатгал	6055.8	7514.3	1458.5
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	5537.6	62.1	663.4
Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	3026.2	16298.1	13271.9
Санхүүгийн даатгал	1630.9	1975	344.1
Барилга угсралтын даатгал	353.6	1756.1	1402.5
Ачааны даатгал	1070.5	1392.9	322.4
Хугацаат амьдралын даатгал	173.7	326.7	153.0
Эрүүл мэндийн даатгал	228.6	308.2	79.6
Мал, амьтдын даатгал		22.4	441.1
Газар тариалангийн даатгал	0.01		0.0
Хуримтлалын даатгал	85.2	125.3	40.1
Тэтгэврийн даатгал	22.7	35.3	12.6

Эх сурвалж: СЗХ

өсгөсөн байна. Ийнхүү зээлийн урьдчилгааг өсгөсөн гол шалтгаан нь банк эрсдэлээ тооцоод урьдчилгааг 30 хувиас дээш тогтоох эрхийнхээ дагуу гаргасан шийдвэр гэх. Дундаж давхаргаа дэмжихийн тулд гаргасан моргейжийн зээл өдгөө баячуудад зориулсан зээл болон хувирах нь энэ. Хэрвээ байдал даамжирвал Монголбанк орон сууцаар барьцаалсан үнэт цаасаа хоёрдогч зах зээлд арилжаалахад хүндрэл үүсч магадгүй гэдгийг хэлэх хүн олон. Тэр үед моргейжийн зээлийн тухай үлгэр төгсөнө. Гэтэл энэ бүгдийн цаад шалтгаан нь Монголын эдийн засагт урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр байхгүйтэй холбоотой.

### Хөл ургуулж, хүч нэмэх төлөвлөгөө

Хэрвээ даатгалын салбарыг хөгжүүлж чадвал урт хугацаатай, өртөг багатай их хэмжээний мөнгөн урсгалыг дотооддоо бий болгож болох ажээ. Хөрөнгийн бирж бага багаар өндийж, банкны салбар хөгжиж буй энэ үед даатгалын салбарын ирээдүйг гэрэлтэй байлгаж чадвал Монголын санхүүгийн салбар доголохгүй харин гүйнэ. Гэхдээ даатгалын салбар хөгжихөд учир бий. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийг дагаж, өдгөө 18 даатгалын компани

дотоод зах зээлд үйл ажиллагаагаа явуулж байна. Гэхдээ урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох учиртай амьдралын буюу урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулдаг “National life” гэх ганцхан компани л Монголд үйл ажиллагаа эрхэлж байна. Давхар даатгалын компанийн тухайд бол сүүдэр нь битгий хэл бараа нь ч алга. Гэтэл хөгжилтэй оронд амьдралын болон давхар даатгалын олон компани зах зээлийн гол хувийг эзэмшдэг. “National life” амьдралын даатгалын компанийн гүйцэтгэх захирал Г.Монголхүү “Амьдралын даатгалын хувьд хүн урт хугацаанд даатгуулдаг. Нэг жишээ дурдахад, 30 настай хүн хувийн тэтгэвэрийн даатгалын санд 70 нас хүртлээ даатгууллаа гэхэд тухайн хөрөнгийг 40 жилийн хугацаанд даатгалын компанийн дансанд тогтвортой хадгална гэсэн үг. Энэ нь тэр хөрөнгийг тухайн даатгалын компани 40 жилийн турш менежмент хийж, өсгөх боломж юм. Урт хугацааны даатгалын компанийн хувьд даатгуулагчийн мөнгийг хэрхэн урт хугацаанд эрсдэл багатай өсгөх вэ гэдэгт анхаардаг. Гаднын ихэнх оронд моргейжийн зээлийг урт хугацааны даатгалын эх үүсвэрээр санхүүжүүлдэг байна. Учир нь моргейжийн зээлд урт хугацаатай санхүүжилт хэрэгтэй бол даатгалын компанид урт хугацаанд эрсдэл

► багатай салбарт хөрөнгө оруулах зайлшгүй шаардлага бий. Харин ердийн даатгалын тухайд банктай л адилхан 1-3 жилийн хугацаатай хадгаламжийн эх үүсвэртэй байдаг гэв. Санхүүгийн салбар өндөр хөгжсөн орнууд, тухайлбал, АНУ-д банкнаас олгодог зээлийн хүүгийн түвшин 3-7 хувийн хооронд хэлбэлзэж байдаг аж. Үүний учир нь банкууд хөрөнгө оруулалтын банкуудаар дамжуулан, олгосон зээлийн авлагаа барьцаалж хөрөнгийн зах зээл дээр моргейжийн зээлийн багц барьцаалсан урт хугацааны өрийн бичиг гаргадаг аж. Өөрөөр хэлбэл, ирээдүйд орж ирэх зээлийн эргэн төлөлтөөрөө дэнчин тавьж хөрөнгө оруулалт татаж байна гэсэн үг юм. Эдгээр өрийн бичгийг хөрөнгийн зах зээл дээрээс томоохон

тодруулбал урт хугацааны даатгалын компаниас хөрөнгө босгох боломжтой болчихвол валютын савалгаанд халуурдаг эдийн засгийн “хууч өвчин” бага ч атугай илаашрах юм. Нөгөө талдаа мөлхөж байгаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх боломж аж. Монголд банкны систем илүү хөгжсөн, иргэд өөрийн гэсэн хуримтлалгүй, санхүүжилтийн өртөг өндөр, хөрөнгийн зах зээлийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муу зэргээс болоод манай хөрөнгийн зах зээл сонгодог утгаар хөгжихгүй байгааг хэлэх хүн олон. Тэгвэл даатгалын зах зээл, тэр дундаа урт хугацааны хуримтлалыг үүсгэх даатгалын сан нь үнэт цаасны зах зээлтэй салшгүй холбоотой болохыг олон улсын туршлагаас харж болно.

зохицож ажиллана гэдэг төвөгтэй. Адаглаад ойлголтын зөрүү их гарч байна” гэсэн юм. Ердийн даатгалын хувьд машин, байшин гэх мэт бодит зүйлийг даатгадаг бол урт хугацааны даатгал нь эрүүл мэнд, амь нас зэрэг бодит бус зүйлийг даатгадаг. Гэтэл энэ талаар манай өнөөгийн даатгалын хуулинд нэг ч заалт байдаггүй аж. Тиймээс хуулиа шинэчлэх зайлшгүй шаардлага байна. Хууль байлаа ч гэсэн хуулийн цоорхойг ашиглан Монголд хэрэгтэй заалт нь бодит амьдралд хэрэгждэггүй гэх шүүмжлэл ч бий. Тухайлбал, даатгалын тухай хуульд гадаадын томоохон компаниуд Монголын даатгалын компанид заавал даатгуулах ёстой гэж заасан байдаг аж. Гэвч хуулийн цоорхойг ашиглаж дотоодын даатгалын компаниудаар дамжилгүй, шууд гадаад улс руу шилждэг даатгал олон байдаг гэх. Ийм байдлаар хэдий хэмжээний мөнгө гадаад руу урсаж байгааг мэдэх боломж даанч хомс. Мөн даатгалын компанийн хөрөнгийн байршил хөрөнгө оруулалтын хязгаарын хэмжээг дахин өөрчлөх шаардлагатайг “Purplebook.mn” цахим хуудаснаа эдийн засагч Д.Дорждэрмийн нийтэлсэн нэгэн судалгаанд дурдсан байсан. Даатгалын компанийн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгөө байршуулах дээд хязгаар 20 хувь байдаг аж. Харин даатгалын салбарын дундаж хөрөнгө зургаан тэрбум төгрөг. Үүний 20 хувь нь 1.2 тэрбум төгрөг болно. Энэ мөнгөөр цөөн хэмжээний орон сууц худалдан авах боломжтой. Тиймээс даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалтын хязгаарын хэмжээг дахин өөрчлөх шаардлагатай байгаа юм. Хэрвээ төр, засаг даатгалын салбарын чадамжийг зөв үнэлж, хууль эрх зүйн орчныг нь бэлдээд өгвөл Монголын санхүүгийн салбар төрөлжих боломж байгаа аж. Гэхдээ дөнгөж хөгжлийн гараанд байгаа салбарын хувьд өнөөдрийн зах зээлд байгаа асуудлыг төр, хувийн хэвшил нь хамтран шийдэх нь чухал. Ингэж чадвал даатгалын салбарт, тэр дундаа урт хугацааны даатгалын салбарт эдийн засгийг эрүүлжүүлэх боломж олон байгаа ажээ. ■

### Хөгжихийн төлөө урагшаа

Даатгалын санд хуримтлагдаж байгаа мөнгө иргэдийн халааснаас л гарна. Тиймээс иргэдийн даатгалын тухай ойлголтыг өөрчлөх шаардлагатай гэдэг. Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга С.Ганболд “Манайд даатгалын салбар анх үүссэн цагаасаа л нийгмийн, эрүүл мэндийн гээд албан журмын даатгалаар ард иргэдээ бөмбөгдөж, баахан мөнгө татчихаад нөхөн олговор олгохдоо хойрго ханддаг байсан нь иргэдийг даатгалын талаар буруу ойлгоход хүргэсэн гэсэн юм. Иймд иргэдийг санхүү, эдийн засгийн мэдлэг мэдээлэлтэй болгох нь даатгалын салбарт юун түрүүнд тулгамдаж байгаа асуудал. Үүний тулд даатгалын компаниуд үйлчилгээний нэр төрлөө сайжруулах шаардлагатай гэдэг. Даатгалын компаниуд ч энэ шүүмжлэлийг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ хууль эрх зүйн орчин муу байдаг нь даатгалын төрөл үйлчилгээг сайжруулахад саад болдог гэнэ. “National life” амьдралын даатгалын компанийн гүйцэтгэх захирал Г.Монголхүү “Өнөөгийн хууль эрх зүйн нөхцөлд даатгалын урт хугацааны компани үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй байна. Ердийн даатгалын компанид зориулж гаргасан хуулийн хүрээнд

## Даатгалын компанийн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгөө байршуулах дээд хязгаар 20 хувь байдаг

даатгалын компаниуд болон хөрөнгө оруулалтын сангууд худалдан авдаг байна. Харин даатгалын томоохон компани нь тэтгэврийн болон эрүүл мэндийн санг бий болгосон байдаг аж. Ийм төрлийн санг бий болгох нь, Г.Монголхүү захирлын хэлсэнчлэн, урт хугацаанд даатгуулагчийн мөнгөөр менежмент хийх боломж буюу тогтвортой хөрөнгийн эх үүсвэрийг иргэдээс татан төвлөрүүлж, түүгээрээ нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох санхүүгийн шилдэг арга юм.

Урт хугацааны даатгалын давуу тал үүгээр зогсохгүй. Монголчуудын валютаас хэт хараат байдлыг ч аргамжиж болох гэнэ. Томоохон бүтээн байгуулалтын сургаар л гаднын хөрөнгө оруулагчид, ам.долларын эрэлд “хатдаг” монголчууд хэрвээ дотоодоосоо,

**ДААТГАЛ**

# Д.ЦЭВЭЭНЖАВ: САНХҮҮГИЙН ЭРСДЭЛЭЭС БҮРЭН ХАМГААЛСАН ХОХИРОГЧГҮЙ ДААТГАЛ

**Ж**олоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилт богино хугацаанд харьцангуй сайн байгааг иргэд олзуурхан ярьдаг. Өнгөрсөн жилээс хэрэгжиж эхэлсэн тус хуулийг эхэн үедээ жолооч нар сайн, муу янз бүрээр гоочилж байсан. Жолооч биш хүн ховор учраас өнөөдөр иргэдийн олонх нь даатгуулахын ач тусыг дээрх хууль хэрэгжих явцад гадарлахтайгаа болжээ. Бодит үр дүн гарч байгаа энэ хуулийн талаар Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжавтай ярилцлаа.

Үе үеийн Засгийн газарт Шадар сайд нарын зөвлөх, Гаалийн ерөнхий газар хэмээх их айлыг удирдаж байсан тэрбээр Жолоочийн хариуцлагын даатгалын хуулийн хэрэгжилтийг хангах ажилд бие, сэтгэлээ чилээн явна. Түүний яриа иргэдэд хэрэгтэй байх болов уу.

**-Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль хэрэгжүүлэх ажлын явц өнөөдөр хэр байна вэ?**

-Жолоочийн даатгалын тухай хуулийг 2011 оны аравдугаар сарын 7-нд баталсан. Өнгөрсөн оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжсэн. Уг хууль нь албан журмын даатгалын нэг төрөл юм. Энэ нь өмчийн эзэн ард иргэдэд учирсан хохирлыг тухай бүр барагдуулж байх агуулгаар батлагдсан хууль. Бусад улсад ийм хууль батлагдаж хэрэгжсэн нь олон жилийн түүхтэй.

Хууль батлагдаад үйлчилж эхлэхэд манайд хэрэгжилтийг хангах



Фотог Э.Зоригт

байгууллагууд бэлэн байсан уу гэвэл тийм биш. Ялангуяа даатгалын компаниуд энэ үйл ажиллагаа эрхлэхэд хүний нөөцийн талаасаа мэдээллийн баазын хувьд бэлтгэл хангагдаагүй байсан. Гэсэн ч хуулийг богино хугацаанд хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүйн яам, Сангийн яам, Зам тээврийн яам, Замын цагдаагийн газар зэрэг төрийн үндсэн чиг үүргийн байгууллагууд ихээхэн анхаарал тавьж, холбогдох журмуудыг батлан гаргаж, хуулийг хэрэгжүүлээд явж байна. Энэ хууль батлагдсантай холбогдуулж УИХ-аас тогтоол гаргаж сургалтыг шуурхай зохион байгуулах үүрэг өгөгдсөн. Энэ дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон даатгалын байгууллагууд

хамтран бүх аймагт сургалт зохион байгуулж, зохих зөвшөөрөл олгосон. Түүнчлэн даатгалын компаниудад Жолоочийн хариуцлагын даатгалыг зохион байгуулах зөвшөөрөл олгосон байдаг.

Энэ үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой нэг шинэ байгууллага бий болсон. Энэ бол Албан журмын даатгагчдын холбоо юм. Тус холбоог Санхүүгийн зохицуулах хороо зохих чиг үүргийнхээ дагуу байгуулж, эрх үүргийг олгож, дүрмийг баталж өгсөн. Үүний дагуу холбооны Удирдах зөвлөл байгуулагдсан. Зөвлөл нь Сангийн яам, Хууль зүйн яам, Зам, тээврийн яам, Замын цагдаагийн газар, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн байгууллагуудын төлөөлөлтэй байдаг. Удирдах зөвлөл холбооны гүйцэтгэх

► үүргийг маш богино хугацаанд тодорхой болгож, ажлын алба байгуулан ажилласан.

**-Өнгөрсөн онд хэчнээн мянган тээврийн хэрэгсэл даатгалд хамрагдав. Шинэ тутам байгуулагдсан танай байгууллага өнгөрсөн нэг жилийн хугацаанд ямар ажил хийж амжуулсан бэ?**

-2012 онд Монгол Улсын хэмжээгээр 360 мянган тээврийн хэрэгсэл албан журмын даатгалд хамрагдсан. Үүнийг улсын тоо бүртгэлтэй тулгаад үзэхээр нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 80 гаруй хувь даатгалд хамрагдсан гэсэн тоо бий.

2012 онд үйл ажиллагаа эхлэхэд тус холбооны санхүүжилтийг төвлөрүүлэх асуудал хүнд байсан. 2012 оны эцсээр холбооны үйл ажиллагаанд зээл авах тухай яригдаж байсан. Шинэ тутам байгуулагдсан байгууллагын боловсон хүчний чадавхи мэдлэг, дадлага дутагдсан тал бий байх. Улсын Их Хурал төсөв хэлэлцэх үед төсвөө батлуулж чадаагүйгээс санхүүжилтийн эх үүсвэр бүрдээгүй байсан. Гэсэн хэдий ч санхүүжилтийн нэг хэсэг болох даатгалын компаниудаас даатгалын хураамжийн орлогоос тодорхой хувиар хөрөнгө төвлөрүүлж, үйл ажиллагаагаа зохих түвшинд явуулж эхэлсэн. Өнгөрсөн онд эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлэх, ажлын албаа зохих ёсоор ажиллуулах, даатгалын компаниуд ажлаа жигдрүүлэх, ялангуяа орон нутагт ажиллаж байгаа төлөөлөгч нарт хуулийн талаар мэдлэг мэдээлэл олгох зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Даатгалын сан бүрдүүлэхийн тулд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогын 10 хувийг орон нутгийн төрийн байгууллагуудаас бүрдүүлэх томоохон ажил 2012 онд хэрэгжиж чадаагүй байсан. 2013 оны хувьд үүнийг хэрэгжүүлээд явж байна. Энэ орлогыг одоогийн байдлаар Дорнод, Хөвсгөл, Хэнтий Завхан гэсэн дөрвөн аймагт орлогоо зуун хувь төвлөрүүлээд байна. Мөн даатгагч нараас төвлөрүүлбэл зохих орлого бүрэн төвлөрөв. Даатгалын сангийн нөөц бүрдүүлэх ёстой. Энэ үүрэг ч биелэгдэж эхэлсэн.

Бид энэ онд жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулсан. Энэ сан бүрдсэнээр гурван үндсэн

үүрэг гүйцэтгэх ёстой. Нэгдүгээрт, жолооч нарын түүхтэй холбогдсон мэдээллийн сан бүрдүүлэх. Ингэхийн тулд мэдээллийн программ хангамж, сүлжээ, зохих серверийг бий болгох ажил байсан. Одоогийн байдлаар энэ ажлыг бүрэн бүрдүүлсэн. Мэдээллийн сан бүрдүүлэхийн тулд маш олон байгууллагатай сүлжээгээр холбогдсон байх ёстой. Юуны өмнө Монгол Улсын хилээр орж ирж байгаа тээврийн хэрэгсэл түүний арлын дугаар манай мэдээллийн санд байх шаардлагатай. Энэ хүрээнд Гаалийн байгууллагатай юуны өмнө холбогдох учиртай. Хоёрдугаарт, тээврийн хэрэгслийг эзэмшихтэй холбоотой хоорондоо худалдах, бусдад шилжүүлэх хөдөлгөөн байна. Үүнийг бүртгэхийн тулд Зам тээврийн яамны бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон. Гуравдугаарт, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгсэл эзэмшиж байгаа өмчлөгчийн хөдөлгөөнүүдийг мөн бүртгэлд оруулах. Тэгэхийн тулд Улсын бүртгэлийн ерөнхий газартай бидний үйл ажиллагаа холбогдсон байх ёстой. Тээврийн хэрэгслийн зөрчилтэй холбоотой асуудлаар Замын цагдаагийн байгууллагатай холбогдох гэх мэтчилэн олон байгууллагатай манайх сүлжээгээ холбож байж нэгдсэн систем болж ажиллах юм. Уг ажил хараахан бүрэн дуусчихаагүй. Зарим байгууллагатай энэ ондоо багтаж холболт хийхээр ажиллаж байгаа.

**-Мэдээллийн сан бүрдүүлэхийн ач холбогдол юу байх вэ?**

-Энэ мэдээллийн санг зохих ёсоор бүрдүүлснээр тээврийн хэрэгсэл эзэмшигчийн түүх баяжиж даатгалын суурь хураамж дээр нэмж төлөх хэмжээ өсөх, суурь хураамжийн хэмжээ буурах нөхцөл бүрдэнэ. Ослын газарт шуурхай очиж гэм бурууг тогтоож хохирлын хэмжээ зөв тогтооход хяналт тавих шуурхай албыг зохих түвшинд байгуулж ажиллууллаа.

**-Та энэ байгууллагын удирдлагад ирсэнээс хойш нэлээд том ажлуудыг амжуулсан байна.**

-Би өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын сүүлчээр энэ ажилд ирсэн. Даатгалын сан бүрдүүлснээр ажлын албаны үйл ажиллагааг санхүүжүүлээд зогсохгүй хохирогчдоо нөхөн

төлбөрүүдийг олгож байна. Үүний зэрэгцээ дараагийн жилүүдэд нөхөн төлбөрт ашиглаж болох нөөц сан бүрдүүлж байгаа. Мөн бид мэдээллийн сангаа бүрдүүлээд авлаа. Үүнээс гадна Шуурхай алба бий болгосон. 2012 онд шуурхай албыг зохион байгуулж, нэг ээлжиндээ дөрвөн хүнтэй байсан бол энэ онд бид 24 цагаар даатгалын тохиолдлын мэдээллийг шуурхай авдаг, газар дээр нь очиж үйлчилгээ үзүүлдэг дөрвөн ээлжийн зохион байгуулалттай ажиллаж байна. Шуурхай албыг зөвхөн Улаанбаатарт биш, орон нутагт байгуулах ажил явж байна. Одоогийн байдлаар бид есөн аймагт Шуурхай алба байгуулаад зохих машин, техникээр бүрэн хангасан. Үлдсэн аймгуудад энэ ондоо багтааж байгуулна. Мэдээллийн сан бүрэн хэмжээгээр ажилладаг болсноор даатгалын компаниуд манай мэдээллийн санг ашиглаад даатгуулагчийн түүхийг харах боломж бүрдэж байгаа юм. Ингэснээр тухайн жолооч маш болгоомжтой ямар нэг осол гаргаагүй бол даатгалд төлөх хураамжийн хэмжээ багасаж байдаг. Хэрвээ даатгалын тохиолдол удаа дараа гаргасан бол тэр хэмжээгээр суурь хураамж нэмэгдээд явах юм. Ийм боломжийг зөвхөн Мэдээллийн нэгдсэн сан бий болсноор ашиглах боломжтой. Өмнө даатгалын компани дээр даатгуулагч очиход "та өмнө нь осол гаргасан байна. Таны даатгалын хэмжээ нэмэгдэх нь" гэхэд "тэгвэл чамд даатгуулахгүй би өөр таньдаг мэддэг газраа даатгуулчих минь" гэх маягаар яваад өгдөг байсан. Тэгвэл одоо нэгдсэн сантай болчихоор тухайн жолоочийн мэдээлэл бүх даатгалын байгууллагад нэгэн зэрэг харагдаж байгаа учраас тухайн жолооч дураараа авирлах боломж хаагдсан. Энэ бол манай даатгалын үйл ажиллагаа шударга, шуурхай, ил тод явах боломжийг мэдээллийн сангаар батлуулж бий болгосон гэсэн үг.

**-Их сонин юм байна. Жолооч нарын хувьд өнөөдрийг хүртэл даатгалаас хохирол барагдуулсан тохиолдолд даатгалын хураамж нэмэгдэнэ гэдгийг огт мэдэхгүй яваа нь олон байгаа байх. Жишээ нь нэг удаа ослын тохиолдол гаргасан суудлын тэрэгний жолоочийн даатгалын хураамж хэдэн төгрөг** ►

► **болж өөрчлөгдөх вэ? Та жишээ татаад тайлбарлаад өгвөл сайн байна.**

-Итгэлцүүрээр хураамжийн хэмжээг дээш, доош болгож тооцох журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталж гаргасан. Энэ итгэлцүүрээр есөн нөхцөл заажээ. Жолоочийн даатгал 50 хувь хүртэл багасаж болох, хоёр дахин өсөж болох нөхцөлтэй. Энэ тохиолдол бүр дээр программ үйлчилж байдаг. Түүнээс биш, даатгалын байцаагч, даатгалын ажилтны санаа зоргоос хамаарч хийх боломжгүй. Жишээлбэл, даатгалтай жолооч замын хөдөлгөөний зөрчил гаргаж, даатгалын үйлчилгээ авсан тохиолдол гаргасан байх юм бол А, В ангиллын машинд 5.0 сая хүртэл, С, D ангиллын машинд 10.0 сая хүртэл сая төгрөгийн хохирлыг даатгалаас төлж өгч болно. Суудлын тэрэг бол жолоочийн хариуцлагын даатгалын хураамж 33000 төгрөг төлнө. 33000-хан төгрөг төлөөд 5.0 сая хүртэл төгрөгийн хохирол нөхүүлэх боломжийг хуулиар нээж өгч байгаа. Хэрвээ ямар нэгэн тохиодол гаргахгүй болгоомжтой сайн жолооч байх юм бол энэ хүний суурь хураамж буюу 33000 төгрөг нэг жил болоход 31000, хоёр жил болоход 27000 гэх мэтчилэн 10 жил осол гаргахгүй явах юм бол суурь хураамжийн хэмжээ 16500 төгрөг болтлоо багасаж болно. Хэрвээ нэг удаа тохиолдол гаргасан жолоочийн 33000 төгрөгийн суурь хураамж 51150 төгрөг болж өснө. Хоёр дахь тохиолдол гаргасан бол 80850 болж өсөх жишээтэй. Итгэлцүүрийн хөдөлгөөнийг жолооч нар маань их анхаарах хэрэгтэй. Ийм хөдөлгөөн гардаг учраас жолооч нар өмнө нь танил талаа харж, хураамжаа өсгөхгүйгээр хийж болдог байсан бол одоо Мэдээллийн нэгдсэн санд даатгалын бүх компаниуд холбогдчихсон. Энэ тохиолдолд хүн худлаа хэлэх аргагүй болсон гэсэн үг. Тэгэхээр Мэдээллийн сан бий болгосон явдал асар их ач холбогдолтой зүйл.

**-Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдахын ач холбогдолыг хууль хэрэгжсэнээр иргэд гадарлахтайгаа болж байна. Мэргэжлийн байгууллагын хүний хувьд та даатгалд хамрагдахын ач холбогдолыг хэлж өгөхгүй юу?**

-2012 оноос өмнө зам тээврийн


осол, зөрчил үүссэн тохиолдолд тухайн жолооч нар хэн нэгнийгээ буруутгаад, цагдаа дуудаж байж буруутнаа тодорхойлуулж, буруутан нь хохирол торгуулаа төлдөг байсан. Мэдээж энэ хугацаанд хоёр жолооч ямар их бухимдах нь тодорхой. Тэгвэл одоогийн хуулиар жолооч нар болзошгүй зүйл болсон үед юуны өмнө даатгалын компани дууддаг болсон. Даатгалын шуурхай алба газар дээр нь очоод, хэн нь буруутайг албажуулдаг болсон. Үүний зэрэгцээ учирсан хохирлын хэмжээг үнэлдэг үнэлгээний 18 компани ажиллаж байна. Өөрт хамгийн ойр байгаа үнэлгээний компаниар хийлгэсэн үнэлгээг нь үндэслээд даатгалын компани, даатгалын сан хохирлыг шуурхай нөхөж олгодог болсон. Энэ агуулгаараа хоёр жолооч хоорондоо муудалцах ямар ч шаардлагагүй болсон. Зөвхөн даатгалын компани дуудаад, хохирлын хэмжээг үнэн зөв гаргуулах сайхан боломж бий болсон гэсэн үг. Энэ бол сэтгэл зүйн хувьд жолооч нарт маш таатай нөхцөлийг бий болгож өгсөн. Нөгөө талаар Замын цагдаагийн байгууллагад учирч байсан асар их ачааллыг хөнгөлж өгсөн. Өнөөдрийн байдлаар замын хөдөлгөөний зөрчил ослын тохиодлын 53 хувь нь шууд даатгалын байгууллагаар шийдэгдсэн байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, 53 хувиар замын цагдаагийн ажлыг хөнгөрүүлжээ гэсэн үг.

Хууль гарснаар хохирол амссан хүний хохирлыг гэм буруутай хүний өмнөөс даатгалын компани, даатгалгүй этгээд байвал Даатгалын сангаас шуурхай нөхөж өгч хохирогчийг хамгаалдаг болсон. Нөгөө талаар иргэд сэтгэл зүйн хувьд би даатгуулчихсан юм чинь миний өмнөөс хохирлыг төлөөд өгдөг байгууллагатай болсон гэдэгтээ сэтгэл ханамжтай болсон. Энэ бүгдийг аваад үзэх юм бол энэ хуулийн ач холбогдол асар их байна. Хамгийн чухал нь жолоочийн даатгалд та заавал хамрагдахыг онцгой анхаар.

**-Жолоочийн даатгалаас бүрдэх төлөвлөгөөт орлого хэр бүрдэж байна. Мөн бүрдүүлсэн орлогоос даатгалын нөхөн төлбөрт өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хэр хэмжээний мөнгө зориулсан бэ?**

- 2012 онд нийт 326740 даатгалын

гэрээ хийгдэж улсын хэмжээгээр 16 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс мөн онд 5151 даатгалын тохиолдол гарч, 2.1 тэрбум төгрөг буцаан олгосон байна. Гэтэл энэ оны эхний есөн сарын байдлаар 7519 даатгалын тохиолдол гарч, 3.7 тэрбум төгрөг олгоод байна. Эндээс харахад, жолооч нар даатгалд хамрагдаж сурч байгаа хэрэг. Нөгөө талаас хуулийн үр дүнгээр дээрх олон мянган хүн, түүний гэр бүл хохирлоо шуурхай нөхүүлж ►►



Замын хөдөлгөөний зөрчил ослын тохиодлын 53 хувь нь шууд даатгалын байгууллагаар шийдэгдсэн

авч чадсан байна. Өнөөдөр даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 18 компани, тэдний орон нутагт байгаа 213 салбар, даатгалын зуучлагч 18, хохирол үнэлгээний есөн компани манай холбоотой нэг баг болж хамтран ажиллаж байна.

**-Хохирлын хэмжээ суудлын тэрэг дээр хуульд заасан 5.0 хүртэл сая төгрөгөөс дээш гарсан тохиолдолд жолооч өөрөө хариуцах уу?**

-Өөрөө хариуцахгүй байж болно. Тэр нь юу вэ гэхээр Тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдах ёстой. Энэ бол сайн дурын даатгал. Хэрвээ 9.0 сая төгрөгийн хохирол суудлын тэрэгний жолоочид учирлаа гэж бодъё. Таван саяыг нь жолоочийн хариуцлагын даатгалаараа нөхүүлээд авчихна. Цаана нь үлдэж байгаа 4.0 сая төгрөгийн хохирлыг тээврийн хэрэгслийн даатгалаар нөхүүлэх боломжтой.

**-Танайх орон нутагт салбар нээж байгаа гэсэн. Сургалт, байрны түрээс гээд зардал их гарах уу?**

-Манай байгууллагад хуулиар заасан гурван томоохон үүрэг байдаг. Нэг нь Шуурхай албыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээгээр байгуулах заалттай. Тэр дагуу ажиллаж байна. Бид эхний хагас жилд найман аймгийг Шуурхай албанд ажиллах зориулалтын машинтай болгож өглөө. Мөн хүмүүсийн цалин, байрны түрээс, мэдээллийн сүлжээг ашиглах интернэтийн зардал гээд 300 гаруй сая төгрөг зарцуулаад байна. Зөвхөн машин авч өгөхөд 190 сая төгрөг зарцуулсан. Дээр нь бусад зардалд 120 сая төгрөг. Одоо үлдэж байгаа аймгуудад мөн тийм хэмжээний зардал гарна. Аймаг орон нутагт энэ ажлыг зохион байгуулж өгсөнөөрөө даатгалгүй машин үлдээхгүй байх зорилготой. Хоёр дахь томоохон үүрэг бол зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг явуулах. Үүний тулд жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах мэдлэг мэдээлэлтэй болгох, ардиргэдийг замын хөдөлгөөнд оролцох боломж нөхцөлийг хангаж өгөх сургалтыг зохион байгуулах ёстой. Зөвхөн энэ оны эхний хагас жилд гэхэд 90.0 гаруй сая төгрөгийг зөвхөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хууль таниулах сурталчилгаанд зарцуулсан

байна. Гуравдугаарт, мэдээллийн сан ажиллуулахад манай нийт зардлын ихэнх нь явж байна.

**-Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн бусад оронд хэрэгжсэн туршлагыг судалж үзсэн үү. Бид хаана нь явна вэ?**

-Олон улсын түвшинд бид нарийн судалж үзсэн. Жолоочийн хариуцлагын даатгал бүх улсад хэрэгжсэн хууль. Монгол Улс хуулиа батлахдаа ОХУ-ын хуулийг нэлээд нарийн судалж, түшиглэж боловсруулсан байдаг. Хойд хөршид хариуцаж байгаа газар нь мөн манайх шиг ийм холбоо гэсэн нэртэй ТББ төрийн үүргийг гүйцэтгэж явдаг. АНУ, Япон мөн ялгаагүй. БНХАУ арай өвөрмөц байдлаар зохион байгуулсан. Тус улсад Санхүүгийн зохицуулах хороо нь энэ үүргээ давхар авч явдаг. БНСУ-ын хувьд 1963 онд батлагдсан хууль хэрэгжиж байгаа. Тус улсад энэ үүргийг даатгалын институтууд гэсэн нэртэй байгууллага гүйцэтгэж, 18.0 сая машиныг даатгалд хамруулсан байх жишээтэй. Эндээс аваад үзэхэд манай одоогийн зохион байгуулалт цаашаа зөв явах байх гэж бодож байна. Бусад улсын туршлагыг аваад үзэхээр төрийн байгууллагууд нь энд тодорхой хэмжээгээр оролцож байж жигдрүүлсэн байдаг. Монголын хувьд ч гэсэн хууль жигдэрч хэвштэл төрийн байгууллагын оролцоо байхаас аргагүй.

**-Та яагаад даатгалын салбартай холбогдсон билээ.**

-Би санхүү, эдийн засгийн мэргэжилтэй ч даатгалын салбарт нэлээд гүнзгий орсон хүн гэж болно. Улсын Их Хурал 1994 онд Нийгмийн даатгалын тухай хуулийг баталж нийгмийн даатгалын цоо шинэ төрөл харилцааг бий болгосон юм. Заавал даатгалын нэг хэлбэр. Нийгмийн даатгалын таван төрлийг амьдралд хэрэгжүүлэхийн тулд орон нутагт Дархан хотын нийгмийн даатгалын хэлтсийн даргаар ажиллаж байсан. Үүнийг дарханчууд маань ойлгож Улсын Их Хуралд хоёр удаа сонгосон юм.

Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байхдаа ч Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулсан. Ер нь ийм өргөн хүрээнд үйлчлэх хуулийг олон нийтэд хүргэж,

ойлгуулах, тэднийг бүрэн хамруулах ажил тийм ч амар зүйл биш. Нийгэмд үйлчлэх өргөн цар хүрээтэй тэр тусмаа төрийн оролцоотой заавал даатгалын төрлийг хэрэгжүүлэх үүрэг удаа дараа биелүүлж байгаадаа баяртай байдаг. Энэ бол төрөөс хүлээлгэсэн том итгэл шүү дээ.

**-Даатгалын үнэ цэнийг монголчууд одоо хэрнээ сайн ойлгоогүй, ойлгохыг төдийлэн хүсдэггүй. Албадлагын шинжтэй зүйл бас л татвар гэж бодож ирсэн. Жолоочийн даатгал энэ тал дээр ямар өөрчлөлтийг авчрах вэ?**

-Зах зээлийн эдийн засагт даатгалын салбар асар ач холбогдол бүхий салбар. Монголчууд хэзээнээс нааш "Өргүй бол баян" гэсэн сэтгэлгээгээр ханддаг. Зээл авбал болохоо байчих юм шиг ойлгодог. Гэтэл өнөөдөр зээлээр амьдралаа хэвийн явуулах нөхцөл байдаг гэдгийг дэлхийн орнууд харуулж байна. Түүнтэй нэгэн адил даатгалын системийн ач холбогдлыг иргэд сайн мэдвэл өөрт учрах болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах сайхан боломж байгаа. Даатгалын зах зээлийн ач холбогдлыг ард иргэд ойлгоод, ялангуяа жолоочийн хариуцлагын даатгалд сайн хамрагдвал өөрөө ч санхүүгийн эрсдэлээс хамгаалагдана. Хохирсон хүний хохирлыг шуурхай нөхөх боломж бүрдэж байгаа. Энэ хэмжээгээр ард иргэдийн амьжиргаа ядуурал руу татагдахгүй, орлоготой байх боломжийг бий болгож өгч байгаа. Нэг тоо хэлэхэд, Монголд авто тээврийн ослоос болж жилд 300 гаруй хүн нас барж, 6000-7000 хүн тахир дутуу болж, тэр хэмжээгээр өрхийн орлого хомсдож байгаа гашуун туршлага бий. Тэгэхээр энэ байдлыг эрс багасгах боломж бол жолоочийн хариуцлагын даатгал юм. Ер нь энэ хуулийг сайн зохион байгуулбал үр дүн ач холбогдол нь гэгээлэг харагдаж байгаа.

Эцэст нь хэлэхэд, Жолоочийн хариуцлагын даатгалыг тээврийн хэрэгслийн даатгалтай нэг багц болгож даатгалын ажлыг зохион байгуулж үйлчилгээг хөнгөвчилж болох юм. Ер нь тээврийн хэрэгсэл эзэмшигч, иргэд жолооч нар даатгалд бүрэн хамрагдвал танд учирч болох эрсдэлээс найдвартай хамгаалах боломжийг бүү алдаарай гэж хүсье. ■

“DISCOVER MONGOLIA”

# ДАВТАХ ЭРХГҮЙ, АЛДАХ ЁСГҮЙ

Ч.ЛУТАА

Навчис шарлаж, салхи сэрчигнэж, бороо дуслах яг л ийм намраар усны шувуудтай зөрөн ирдэг хөрөнгө оруулагчид энэ удаа шувуудын сүрэгтэй хамт дулаан орныг зорив уу гэлтэй таг чиг. Арван намрыг ардаа орхиж 11 дэх жилдээ “Discover Mongolia” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт эхэлсэн. Жилийн жилд хөрөнгө оруулагчдын хөлд дарагддаг “Discover Mongolia”-д ирсэн зочид цөөн. Магадгүй тулгаа тойрч суусан монголчуудыг дотоод асуудлаа халуун ам бүлээрээ шийд гэсэн ч байж магад.

Бид асуултаа асуусан . . .

Гэрийн эздийн хэлэлцсэн эхний сэдэв “Хууль, эрх зүйн тогтвортой орчин ба уул уурхай” байсан. Монголын эдийн засгийн зүрх болсон уул уурхайн салбарын даралт унаж, эдийн засаг доргисон гол шалтгаан бол ердөө л төрийн харалган бодлого, тогтворгүй авиртай холбоотой гэдгийг хуралдаанд оролцогчид хэлж байлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат “Энэ удаагийн “Discover Mongolia” хурлаар салбарын хөгжил, хөрөнгө оруулагчдын сонирхол, үзэл бодлын үзүүлэлт ямар байгаа нь харагдлаа. Ийм хоосон ▶



▶ танхимд нээлт, хаалт хийж үзээгүй. Гэхдээ зочид ирээгүй гээд уул уурхайн салбар Монголд хэрэггүй, хөрөнгө оруулагчид дахиж ирэхгүй гэсэн үг биш. Харин ч эсэргээрээ эрдэс баялгийн эрэлт хэрэгцээ дэлхийн зах зээлд өссөөр байна. Тэгвэл яагаад хөрөнгө оруулагчид уул уурхайн баялаг ихтэй манай орныг орхиод явчихсан юм бэ. Үүний гол буруутан нь төр. Бид энэ удаа төрөөс асуултаа асуулаа. Хэрхэн хариулах нь тэдний ухаанаас шалтгаална” гэв. Уул уурхай уналтад орж, эдийн засаг царцаж, валютын ханш чангарсан нь ердөө л аль ч улсын төрд байдаг “төрийн залгамж халаа” гэх суртахуун Монголын төрд алдагдсантай холбоотой аж. Монголчууд төрийн залгамж халаа гэх улс төрийн соёлыг цагийн эртэд олж авахгүй бол олон гоё мөрөөдөлдөө хүрч чадахгүй гэдгийг “Монголын шатдаг занарын холбоо”-ны ерөнхийлөгч Да.Ганболд хэлсэн юм.

Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил гэсэн Монгол Улсын хөгжлийн тулгын гурван чулууг засах зорилготой байсан тус чуулганаар чуулганд оролцогчид асуудал бүрт өөрийн өөрийн байр сууриас хандаж, тодорхой тайлбарыг цаг тухайд нь өгч байлаа. Дээр дурдсан төрийг буруутгасан үзэл бодолтой санал зөрөлдөх хүн чуулганы зочдын дунд байсангүй. Төрийн төлөөлөл болж ирсэн Эдийн засгийн хөгжлийн дэд сайд О.Чулуунбат “Төрийн болоод хууль эрх зүйн орчин тогтворгүй байгаа учраас хөрөнгө оруулагчид явсан нь үнэн. УИХ-ын ээлжит бус чуулганаар хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах хууль гарна. Хуулийн гол үзэл баримтлал нь өнөөдөр Монголд хөрөнгөө оруулсан гадаад, дотоодын бүх л хөрөнгө оруулагчид 5-10 жилийн дараа ч өнөөдрийнхөө хуулиар л зохицуулагдах тийм тогтвортой байдлыг бий болгоно” хэмээн дуулгасан. Гэсэн хэдий ч нэг хуульд өөрчлөлт оруулаад л хөрөнгө оруулагчдын итгэл сэргэчихгүй. Хамгийн гол нь зах зээлийн эдийн засагтай орны хувьд бизнес дэх төрийн шууд оролцоог зохицуулах чиг үүрэг рүү нь түлхүү чиглүүлэх хэрэгтэй байгааг сануулах

хүн олон. Учир нь төр менежмент хийгээд бизнест гар дүрээд ирэхээр л асуудал буруу тийшээ эргээд байгаа олон жишээ Монголд бий. Тиймээс төр аль болох урт хугацаанд бизнесийн таатай, тогтвортой орчныг нь бүрдүүлээд хөрөнгө оруулагчдаас татвараа ахиухан аваад амар жимир аж төрөн суух боломжтой ажээ.

### Шинэ мэргэжил “шантаажлах”

“Эх нутгийнхаа төлөө”, “Миний Монголын газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг”, “Гаднынхан зайл” гэх сүртэй үгсээр халхавч хийсэн эх орончид гэх шинэ “мэргэжил” уул уурхайн хөгжилтэй хамт Монголд үүссэн гэхэд хилсдэхгүй. Хөрөнгө оруулагчид дүрвэсэн хоёр дахь том шалтгаан бол шантааж гэдэгтэй олон хүн дуу нэгтэй. Нутгийн иргэд уул уурхайн компаниас юу нэхээд байна вэ. Эх нутгаа хамгаална гээд байна уу эсвэл хандив нэхээд байна уу. Үүнд л гол учир бий. Энэ талаар чуулганы үеэр олон сонирхолтой жишээ дурдсан. Тухайлбал, гар аргаар ашигт малтмал олборлогчдын гарт сүйдсэн газар жилээс жилд тэлсээр буй. Гэтэл байгаль орчноо хамгаалах ариун үйлсэд нэгдсэн иргэний хөдөлгөөнийхөн албан ёсны эрхтэй уул уурхайн компани нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөгөө үзүүлээд байхад л уурхайг хаана хэмээн сүрдүүлээд байдаг аж. Гэтэл байгаль орчныг жинхэнэ утгаар нь сүйтгэдэг гар аргаар ашигт малтмал олборлогчидтой тэмцдэггүй гэх. Үүний цаад шалтгаан нь байгалиа хамгаалах нэрээр мөнгө авах гэж санаархагчид олшроод байгаатай холбоотой аж. П.Очирбат “Хандив гэж юу вэ. Үнэндээ энэ бол нэрээ сольж, зүсээ хувиргасан авлига. Мөнгө өгөхгүй болохоор нь уул уурхайн компанийн ажилчдыг дэлбэлнэ, ална, хядна гэдэг хүмүүс олон байна. Ер нь дээрээсээ аваад доод шат хүртлээ монголчууд шанаатжлах тухай л боддог болж. Хөрөнгө оруулагчид э төрийн олон дарамттай аль болох зохицоод үйл ажиллагааны эрхээ авдаг. Тэгээд нөгөө лицензтэй

газраа хүрээд ирдэг. Гэтэл нутгийн иргэд нь хөөгөөд байдаг. Ер нь бол шантааж гэдэг чинь нутгийн иргэд түрэмгийллийн аргаар авдаг давхар татвар болчихоод байна” гэсэн юм. Үүний гол буруутан нь мөнөөх л төр аж. Учир нь Гэнэтийн ашгийн татварын тухай хууль, Урт нэртэй хууль зэрэг төрийн “үйлдвэрлэсэн” уул уурхайтай холбоотой 10 гаруй муу хуулийн харгайгаар олон компани дампуурч оронд нь гар аргаар ашигт малтмал олборлогчид олширсон аж. Өмнө нь тэднийг шанага, хувингаар зэвсэглэсэн мэтээр төсөөлдөг байсан бол өдгөө байдал өөрчлөгдөж жижиг уурхайгаас дутахааргүй техникжсэн “нинжа” нар олширч, байгаль орчныг сүйтгэчихээд яваад өгдөг байдал даамжирчээ. Үүнийг нь манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд уул уурхайн компаниуд байгаль дэлхийг сүйтгэлээ, голын амь тасаллаа гэх мэтээр бичсээр ард иргэд нь уул уурхайн компаниудыг “мангас” хэмээн төсөөлдөг болчихсон аж. Харин иргэдийн уул уурхайг үзэн ядах сэтгэлгээг овжин ашиглаж, ашиг харсан “эх орончид” хаа сайгүй олширсон байна. Тиймээс уул уурхай гэлтгүй бүх л салбарт олон талын оролцоо хүчтэй нөлөөлдөг гэдгийг дээрх жишээ харуулсан юм. Монголын уул уурхайн ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба “Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, сэтгүүл зүй гээд бүх тал харилцан уялдаатай ажиллах хэрэгтэй. Төр нь гаргасан бодлогынхоо үр дагаварыг боддог. Сэтгүүлчид нь бичсэн нийтлэл, гаргасан нэвтрүүлгийнхээ үр дагаварыг нь тооцоолдог байх хэрэгтэй. Мөн гаргасан алдаанаасаа суралцах цаг нь болсон” гэв. Ер нь хөрөнгө оруулагчид Монголын хэвлэл мэдээллээр гарч байгаа мэдээ мэдээллийг алгасалгүй уншиж, үйл ажиллагаагаа төлөвлөдөг тул сэтгүүлчид бичих өгүүлбэр, тавих таслал, хэлэх үг бүрийнхээ үр дагаварыг бодох хэрэгтэй гэдгийг шүүмжлэх хүн олон байсан. Түүнчлэн хөрөнгө оруулагчид явсан шалтгааны гуравдугаарт сэтгүүлчдийн хэт нэг талыг барьсан мэдээлэл байсан гэдгийг чуулганд оролцогчид хэлж байлаа. ▶

## ► Мөнхийн сэдэв

Уул уурхайг сүүдэр мэт дагадаг байгаль орчин, хүний нөөц гэх мөнхийн хоёр сэдвийг энэ удаа бас л хөндлөө. БОНХ-ийн сайд С.Оюун “Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаа энэ үед байгаль орчны асуудлыг нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Тиймээс ч Шинэчлэлийн Засгийн газар Байгаль орчин, Ногоон хөгжлийн яамтай болсон. Мөн өнгөрсөн оны тавдугаар сард Байгаль орчны багц хууль батлагдсан. Энэ хуульд багтаж буй Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд усны үнийн тарифыг нэмэх тухай заалт орсон. Үүний дагуу Засгийн газар усны тарифыг шинэчлэн тогтоох ёстой” гэв. Уг хуулийн гол зорилго нь бохирдуулагч нь төлдөг, ашиглагч нь хамгаалдаг байх тогтолцоог нэвтрүүлэхэд оршиж байгаа аж. Гэхдээ хууль хэрэгжихэд сул тал мөн л байгаа гэнэ. Тухайлбал, хуулийн сайн талыг нь харчихаад эрсдэлийг нь олж харахгүй байгааг шүүмжилж байлаа. Жишээлбэл, шинэ хуулиар “Монголын алт” компани өмнө нь 60 сая төгрөг усны төлбөрт төлдөг байсан бол өдгөө 800 сая төгрөг төлөхөөр болоод байгаа аж. Тиймээс хуультай холбоотой шинэ журам батлахгүй бол дээрх мэт усны төлбөр огцом нэмэгдэх асуудал үүсээд байна гэдгийг салбарынхан тайлбарласан. Ер нь дэлхий нийт байгалиа сүйтгэж эдийн засгаа тэтгэдэг загвараас зайлсхийж байгаа энэ үед монголчууд энэ зарчмаас хазайгаад хэрэггүй л болов уу. Гэхдээ байгаль орчин гэх нэр дуулдах төдийд л эдийн засгийг аргамжиж, уул уурхайг хаах, торгох арга мэтээр харахгүй байхыг салбарын сайд учирлаж байлаа. “The Nature Conservancy” байгууллагын тэргүүлэх эрдэмтэн, захирал Петр Карева “Байгаль орчны асуудал зөвхөн Монголд тулгамдаагүй. Тиймээс энэ талаар сайн туршлага олон улсад бий. Ер нь байгаль орчны асуудалд анхаарах нь нэг талаар байгальд ээлтэй технологийг хөгжүүлэх, ногоон эдийн засгийг бэхжүүлэх суурь болдог. Америкт 50 жилийн өмнө байгаль орчныг хамгаалах хууль батлах нь эдийн засгийн сөрөг үр дагавар авчирч магадгүй хэмээн шүүмжилж байсан. Гэхдээ өдгөө эдийн засагт эерэг үр дагавар авчирсан байна” гэсэн юм.

Монголд ажлын байр олон байгаа. Гэхдээ ажиллах хүч олдохгүй байна гэх гомдол салбар хуралдааны үеэр гарсан. Тухайлбал, гаднын уул уурхайн компанийн нийт ажилчдын 90 хувь нь монгол хүн байх журмыг биелүүлэхэд хэцүү байгаа аж. Үүний гол шалтгаан нь Монголд

мэргэжилтэй боловсон хүчин дутмагтай холбоотой. Тиймээс хүний нөөцийн эрэлт нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд хамгийн гол нь сургалтын тогтолцоог сайжруулж, уул уурхайн салбарт хэдий хэмжээний боловсон хүчин хэрэгтэй байна вэ гэдгийг тодорхойлж гаргах цаг нь болжээ. Мөн цалингийн хэмжээ бага, гадаад, дотоод гэх ялгаанаас болж монгол боловсон хүчний ур чадвар үнэгүйдэж хүнд хэцүү ажлыг цалин багатай хийж буйг иргэний нийгмийн төлөөлөл шүүжилсэн юм.

## Өнгөлөг сэдэв

Энэ удаагийн хурлын гэгээтэй мэдээлэл нь занарын талаарх салбар хуралдаан байлаа. Занарын арвин нөөцөө монголчууд хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулах, түүнийг ашиглаж хэрхэн эцсийн бүтэгдэхүүн болгох талаар ярилцлаа. Шатдаг занар нь нефтийн бүтээгдэхүүний хараат байдлаас гаргах эрчим хүчний чухал эх үүсвэр. Гэхдээ шатдаг занарын аж үйлдвэрийн хөгжлийн асуудал, хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгаагаас гацаанд оржээ. Тухайлбал, өнөөдрийг хүртэл занарын нарийвчилсан судалгаа манайд байдаггүй аж. Бусад төрлийн хайгуулын үеэр л тогтоогдсон баримжаа дурдахаас илүү гарахгүй байгаа аж. Тэртээ 1994 онд гаргасан судалгаа, тооцоонд тулгуурласан тоо баримтыг өдгөө дурдсан хэвээр байгаа гэсэн үг. Уул уурхайн дэд сайд О.Эрдэнэбулган “Монголд занарын нөөц их. Гэхдээ байгаа мэдээлэлдээ тулгуурлаад нарийвчилсан нөөцийг тодорхойлох хэрэгтэй байна. Одоогоор занарын нарийвчилсан нөөцийг албан ёсоор бүртгүүлсэн нэг ч тоо баримт байхгүй” гэв. Нарийвчилсан судалгаа хийгээгүй байж хий хөөрцөглөх нь халтай гэдэгтэй салбар хуралдаанд оролцогчид санал нэгтэй байсан. Байгаль орчны наад захын үнэлгээ, нөөцийн баталгаатай мэдээллээ бүртгүүлчихээд занарыг ашиглах тухай ярих нь амьдралд арай ойр юм.

Хүн цөөхөн ч хүч ихтэй болсон энэ удаагийн “Discover Mongolia” чуулганаар дээрх мэт олон чухал асуудлын талаар ярилцсаны үр дүнд монголчууд гаргасан алдаагаа давтах эрхгүй, ахиад алдах ёсгүй гэдэгтэй хөгжлийн тулгын гурван чулуу болсон төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөл үзэл бодол, үг хэл нэгдсэн. Одоо үйл хэрэг болгох том үүрэг талуудад үлдсэн. Хэрвээ алдаанаасаа сургамж авахгүй “тэнэг” үйлдэл гаргасаар байвал монголчууд гоё мөрөөдлөөс цаашгүй үлдэж мэднэ. ■



ОЮУТОЛГОЙ

# ДААЦТАЙ ХӨГЖИЛ, ДАВХАР ДЭМЖЛЭГ

Б.ТОГТОХ

Монгол Улсын нийт ажиллах хүчний 4.3 хувийг шингээх уул уурхайн салбарт хүний нөөцийн хомсдол байсаар. Тэр тусмаа нарийн мэргэжилтэн “ховор бараа” болж, хөрөнгө оруулалт гадагшилж байгаа нь нууц биш ээ. Эдийн засаг өсөхийн хэрээр тус салбарынхан мэргэжилтний эрэлд мордож, өндөр үнэтэй ажиллах хүч импортолж сууна. Богино хугацаанд ажиллах хүчээ нөхөх үүнээс өөр сонголт алга байгааг тэд учирлах аж. Угаас хөдөлмөрийн зах зээл “удирдлагагүй” болсныг эл байдал гэрчилнэ.

Монголын Мянганы сорилтын сангаас ойрын 20 жилд хөдөлмөрийн зах зээлд өндөр эрэлттэй байх 20 ажил, мэргэжлийн жагсаалт гэж гаргасан. Уг судалгаанаас үзэхэд байнгын ажлын байр уул уурхайд 6.6 хувиар өсөх хандлагатай дүн гарчээ. Харин эрэлттэй байгаа 20 мэргэжлийн дотор далд ба ил уурхайн уурхайчин, хүнд даацын машин, том тэрэгний жолооч, уурхайн инженер, металлургич, уурхайн металлургийн инженер гэсэн мэргэжлүүд онцгойрчээ. Тиймээс их, дээд сургууль төгсөгчид уул уурхайн салбар руу хошуурч байна.

Засгийн газраас мэргэжилтэй ажиллах хүчинг бэлтгэхээр зорьж байгаа ч төдийлэн хүртээмжтэй болсон нь цөөн. ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийн захирал Л.Пүрэв “Манай сургууль 1971 оноос уул уурхайн чиглэлээр дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсэн. Одоогийн байдлаар есөн чиглэлээр боловсон хүчин бэлтгэхийн сацуу уул уурхайн

салбарын нийт ажиллах хүчний 50 гаруй хувийг дангаар хангаж байна. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэр, уул уурхайн чиглэлээр суралцах оюутны тоо эрс нэмэгдсэн” гэв. Манай улсад уул уурхайн мэргэжилтэнг 12 сургууль бэлтгэж байгаа ч төгсөгчдийн чанар сул байгааг ажил олгогчид хэлдэг.

Хуучин нийгмийн үед “Эрдэнэт” үйлдвэрийг 1987 онд ашиглалтад орно гэж төлөвлөөд, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтнуудыг нь 1973 оноос бэлтгэж байсан гэдэг. Гэтэл долоон Эрдэнэт, 50 Бороо Гоулд, зургаан Асгаттай тэнцэх Оюутолгой төсөл “хөдөлсөн” хойно нь ажиллах хүчнээ санасан нь бодлогын алдаа гэлтэй. Дэлхийн банкны хийсэн судалгаанаас үзэхэд мэргэжилтэй ажиллах хүчин Монголын нийт ажиллах хүчний ердөө 20 хувийг эзэлж байгаа юм.

Монгол Улс уул уурхайн хосгүй баялагтай, баян орон гэдгийг дэлхий нийт мэдэх болж. Харин хүн ам цөөтэйг тэд бас гадарлах. Тиймээс “хоёр толгой”-г хэлэлцэхийн сацуу монгол хүнээ хөгжүүлэх, монгол толгойд найдах цаг иржээ. Ирээдүйд гаднаас мэдлэгтэй, мэргэжилтэй өндөр үнэтэй ажиллах хүч импортолж, өөрсдийн нөөц боломжоо бусдад алдахгүйн тулд хийх ажил их байгааг өнөө жилийн “Discover Mongolia-2013” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт өгүүлсэн. 11 дэх жилдээ болж буй тус чуулга уулзалт уул уурхайн салбар дахь хүний нөөцийн асуудлыг ийн хөндсөн юм.

Зөвхөн Монголд ч бус дэлхий нийтэд уул уурхайн ажиллах хүч санаа зовоох асуудлын нэг болчихож. 2020 он гэхэд ▶

Фотог Э.Зоригт

Оюутолгойн тэтгэлэгт хөтөлбөр  
2013-2014 оны хичээлийн жилд  
35 оюутанг шалгаруулж авах аж

дэлхийн уул уурхайн салбар ажиллах хүчний хомсдолд орох аж. "The Mining Industry Human Resource Council" олон улсын байгууллагын судалгаагаар дэлхий даяар уул уурхайн салбарт ажиллаж буй нийт хүний 60 мянга нь 2020 он гэхэд тэтгэвэрт гарах бөгөөд тэдний орон зай болоод тухайн үеийн хэрэгцээг нөхөхийн тулд 100 мянган шинэ ажилчныг бэлтгэх хэрэгтэй гэнэ.

Хамгийн өндөр цалинтай ч хүнд нөхцөлд ажиллах уул уурхайн салбарт ажиллах хүч өнөөдрийг хүртэл төдийлэн хангалттай биш. Томоохон ордууд тодорхой хэмжээний үйлдвэрлэл явуулж байгаа ч мэргэжилтэй ажиллах хүчнээр цангасаар. Уул уурхай техник болон хүний хүчээр хосолж ажилладаг. Тиймээс шингээх зах зээл нь хэзээд чанар нэхэх болохоор Монгол "хөл алдах" нь тэр. Уул уурхайн салбарт ажиллагсдын 0.4 хувь нь инженер, 34.4 хувь нь техникийн ажилтан, 65.2 хувь нь мэргэжлийн ажилчид байх шаардлагатай гэсэн судалгаа бий. Үүгээр бол өнөөдөр Монголд 1200 орчим өндөр мэргэжлийн инженер, 10 мянга гаруй техникийн ажилтан, 18 мянга орчим мэргэжлийн ажилтан шаардлагатай болох нь. Тэгвэл манай улс жилд 3900 гаруй оюутан бэлтгэж байна. Хэдий уул уурхайн мэргэжлээр суралцагсдын тоо өсч байгаа ч 2008 оны тоог 2005 оныхтой харьцуулахад дөнгөж 1.37 хувиар өссөн байна.

"Оюутолгой" компаниас Засгийн газрын зорилтод хөтөлбөрт дэмжлэг болохуйц томоохон хөрөнгө оруулалтыг хийж байна. Хамгийн үр дүнтэй хөрөнгө оруулалт хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт байдаг гэх. Үүнийг даацтай хөгжил гэж үздэг байна. Тэд ирээдүйд үүсэх эрэлт хэрэгцээг өнөөдрөөс хангахын тулд, ирэх жилүүдэд бий болох бүтээн байгуулалтын ажилд оролцох хүмүүн капиталыг Монголд бэлдэн өгч, суралцах тав тухтай орчин, суух ширээ сандлыг нь хүртэл төвхнүүлжээ. Төсвийн хөрөнгө оруулалтыг "ичээж" мэдэх тус хөтөлбөр нь боловсролын салбарт урьд өмнө байгаагүй хөрөнгө оруулалт болж Монголд шингээж байгаа нь энэ.

"Монгол Улсын мэргэжлийн боловсролын тогтолцоонд 126 сая ам.доллар буюу 168 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бодиттой дэмжлэг" болохыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав онцолсон. Тус санхүүжилтийн хүрээнд Монгол Улсад техник технологийн гурван жишиг сургууль шинээр барьж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн дөрвөн төвийг иж бүрэн сайжруулах юм. Үүнээс гадна 3300 мэргэжилтэй ажилтан бэлтгэх, МСҮТ-ийн 1200 багшийг сургах, Оюутолгойн ажилтан бэлтгэх, гадаад дотоодын их, дээд сургуульд бүрэн тэтгэлгээр сургах боломжоор хангаж байгаа аж. Тухайлбал, Налайх дүүрэгт Техник технологийн орчин үеийн жишиг сургууль барьж өнгөрсөн онд нээлтээ хийсэн билээ.

Засгийн газар "Оюутолгой" төсөлтэй хамтран нэг жилийн хугацаанд **7000 хүнийг** сургаж, үүний 70 гаруй хувь нь ажлын байртай болжээ

Мөн гадаадад суралцаж буй олон залуус Монголдоо ирээд баялаг бүтээнэ. Баялаг нь хөгжил болно. "Оюутолгой" компаниас "Шинэ төгсөгчдийн хөтөлбөр" гэж хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрөөр шинэ төгсөгчдийг "Рио Тинто" компанийн бусад улсад байрлах томоохон уурхайд ажиллуулж, дадлагажуулж байгаа юм. Энэхүү хөтөлбөрт хамрагдан Австрали улс дахь "Рио Тинто" компанийн "Нортпаркес" уурхайд мэргэжил дээшлүүлээд ирсэн С.Тамиртай уулзахад тэрбээр "Өнгөрсөн оны тавдугаар сараас нэг жилийн хугацаатай гадаадын уурхайд дадлага хийж их зүйл сурч, мэдлээ. Үндсэндээ бид тэнд Оюутолгойн далд уурхайд гурав, дөрвөн жилийн дараа хийхээр төлөвлөсөн ажлыг урьдчилаад харлаа гэж хэлэхэд болно. Тиймээс газар дээр нь очиж, үйл ажиллагаатай нь танилцаж,

ажиллана гэдэг маш их туршлага. Манайхан Мянга сонсохоор нэг удаа үз гэж ярьдагчлан ном, сурах бичгээс унших, газар дээр очиж үзэх их ялгаатай юм байна" хэмээн ярьсан юм. Тамир одоо "Оюутолгой" компанийн Далд уурхайн техник үйлчилгээний хэлтэст ажиллаж байна.

Саяхан тус компаниас үндэсний хэмжээний оюутны тэтгэлэгт хөтөлбөрөө зарлажээ. Оюутолгойн тэтгэлэгт хөтөлбөр 2013-2014 оны хичээлийн жилд 35 оюутныг шалгаруулж авах аж. Хэрэв тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэх аваас сургалтын жилийн төлбөрөө 100 хувь авахын сацуу сар бүр 200 мянган төгрөгийн тэтгэлэг авдаг байна. Тухайн оюутан орон нутгийнх бол дотуур байрных нь төлбөрийг мөн өгдөг аж.

"Нэг сумаар олон туулай буудах" тус хөтөлбөрт тэнцсэн оюутан "Оюутолгой" компанид дадлага хийх боломжтой юм байна. Тус компанийн Хүний нөөцийн хэлтсийн Сургалтын мэргэжилтэн Ё.Лхамаа "Оюутолгой" компани 2010 онд БСШУЯ-тай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Үүгээр 2010-2015 онд давхардаагүй тоогоор 200 оюутан тэтгэлгээр сургахаар шийдвэрлэсэн юм. Өнөөдрийн байдлаар 100 оюутан тэтгэлэг авсан байгаа. Энэхүү тэтгэлэг оюутнуудад санхүүгийн туслалцаа үзүүлж, Оюутолгой компаниас зарладаг бусад хөтөлбөрүүдэд үргэлжлүүлэн хамруулах гол зорилготой" гэв.

Оюутан хүн сургалтын төлбөр, дотуур байрны зардал, хэрэглээний мөнгөндөө санаа зовохгүй сурна гэдэг том боломж бас том дэмжлэг бус уу. Цаашилбал өрхийн амьжиргаанд ч давхар давхар сайнаар нөлөөлж байгаа хэрэг. Засгийн газрын тэргүүлэх зорилтуудын нэг нь "Ажилтай, орлоготой монгол хүн". Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Засгийн газар, "Оюутолгой" төсөлтэй хамтран өнгөрсөн нэг жилийн хугацаанд 7000 гаруй хүнийг МСҮТ-д сургаж, үүний 70 гаруй хувь нь ажлын байртай болсныг онцлон тэмдэглэв. Хүний хөгжлөөс улсын хөгжил эхэлнэ гэдэг. Монгол толгойг дэмжсэн хөрөнгө оруулалт цар хүрээгээ улам тэлэг. ■

## CEO SUMMIT

# “ТЭЖЭЭГЧЭЭ ХЯНАДАГ ТЭЖЭЭЛГҮҮЛЭГЧ БАЙДАГ ЮМ УУ”

## Б.ЭНХ

Төрийг тэжээж, ардыг ар амьдралтай нь залгуулагчид гэж хэлж болох компанийн захирлууд хоёр жилд нэг цуглаж, асуудал амжилтаа ярьдаг. Энэ сарын 25-нд Төрийн ордонд болсон “Компанийн захирлуудын дээд хэмжээний уулзалт” асуудалд булагдаж, бухимдалд буцалж өнгөрлөө. Энэ жилийн сэдэв “Эдийн засгийн хүндрэл, даван туулах арга замууд” байв.

Үл хөдлөх хөрөнгө, барилга, Тээвэр, ложистик, жижиглэн болон гадаад худалдаа, Үйлдвэрлэл, жижиг, дунд бизнесийг дэмжих, Банк санхүү гэсэн эдийн засгийн тулгуур салбаруудыг чухалчиллаа. Компанийн захирлууд УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийг индрээс “Валютын ханшийн чангаралд өртөж хохирол амссан компани байвал гараа өргө” хэмээхэд эгээтэй л хоёр гараа өргөсөнгүй. Өглөө 9:00 цагт эхэлсэн уулзалт бизнес эрхлэгчдийн хууль тогтоогч, шийдвэр гаргагчдад бодитой, эрс шийдэмгий санал бодлоо хүргэх гэсэн хүсэлт, шахалт, бухимдлаас үүдэн 19:00 цагт өндөрлөлөө. Төрийн ордны Их танхимын нэгдүгээр давхар сул суудалгүй байсан нь захирлууд уг чуулганд ямар их ач холбогдол өгсөнийг илтгэх. Үдээс хойш танхим сийрэгжсэн. Гэвч хурлын халуун уур амьсгал хөрөөгүй. Ерөнхий сайд Н.Алтанхуяг, ЗГХЭГ-ын дарга, Шинэчлэлийн асуудал эрхэлсэн сайд Ч.Сайханбилэг тэргүүтэй албаны “томчууд” нээлтэд нь оролцож, үндэсний эдийн засгийг бүтээгчдэд хувийн хэвшлийг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,



хүнд сурталыг багасгахын төлөө Шинэчлэлийн Засгийн газар чармайн ажиллаж буйгаа онцлов. Энэ тал дээр Ч.Сайханбилэг “Харин та бүхний Засгийн газартаа ойртож хамтран ажиллах зүтгэл дутаж байна” хэмээн хэлчихээд гарсан нь бизнес эрхлэгчдэд таалагдсангүй бололтой. Учир нь, мөнхийн завгүй, цаг минуттай уралддаг захирлууд зорьж ирсэн чуулгандаа төр, засгийн төлөөллүүдийг эхнээс нь дуустал байж, хэлж ярьж байгааг нь сонсож санаа бодлоо хуваалцаж халуун дотно харилцаа үүсгэх ёстой гэж үзсэн юм. Хуралд оролцогчдын олонх нь дээрх хүсэлтийг дэмжиж “Ингэх гэж л бид цугласан. Түүнээс биш, Ордонд олуулаа цугладаг жирийн нэг хурал шиг байх юм бол энд ирэх шаардлага байгаагүй” хэмээн хатуухан хэлж байсныг тэмдэглэх нь зөв болов уу.

## Банкныхан хувалзууд гэж үү

Хурлын ерөнхий уур амьсгал баялаг бүтээгчид бид өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд өмнөхөө хийж бүтээж, төрийн буруу бодлого, шийдвэр, хүнд сурталд дэндүү хүлээцтэй хандаж ирлээ. Одоо бид хэлэхгүй бол болохгүй байна гэдгийг сануулж байв. Ерөнхий сайд нээлтийн үгэндээ Чингис бондын мөнгөөр эдийн засгаа хямралаас аварч, бүтээн байгуулалтыг өмнө байгаагүйгээр өрнүүлж, барилгын салбарыг дэмжиж байгаа талаар дэлгэрэнгүй дурдсаныг бизнесмэнүүд анхааралтай сонссон. Гэхдээ эдгээртэй холбоотой зарим хариулт нэхсэн асуудлаар шийдвэр гаргагчдын яриаг сонсохыг илүүд үзэж байв. Тухайлбал, Монголбанкны ▶

► ерөнхийлөгч Н.Золжаргал Банк, санхүүгийн салбар хуралдаанд оролцохоор байсанд олон хүн олзуурхаж байгаа нь илт байв. Цаг нь болоход Золжаргал ерөнхийлөгч ч индэрт гарсан. Тэрбээр валютын ханш болон эдийн засагт болж байгаа процесс, өнөөгийн байдлын талаар дэлгэрэнгүй илтгэл тавьж, бизнес эрхлэгчдэд эдийн засгийн мэдлэг, мэдээлэл олгохоос гадна шаггүй илтгэгч гэдгээ харуулав. Төвбанкнаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Мөнгөний бодлогын талаар ч дэлгэрэнгүй өгүүлсэн түүний илтгэл богино биш байсан ч оролцогчдод таалагдаж, шимтэн сонссон. Гэхдээ тэрбээр завгүй байсан уу, эсвэл үйлдвэрлэгчдийн зүгээс олон асуултаар бөмбөгдөнө гэж болгоомжилсон уу илтгэлээ тавьж дуусмагц, асуулт хариултын цагийг хүлээлгүй гарч одсон. Оролцогчдын зүгээс индэр дэх түүний суудал эзэнгүй байгааг ч үл анзааран Монголбанкны ерөнхийлөгчөөс асуумаар байна гэж байгаад л “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг Чингис бондоос мөнгө өгч дэмжиж байгаа гэж худлаа ярьж, бичээд байх юм. Бидний гар дээр өнөөдрийг хүртэл нэг ч төгрөг ирээгүй. Энэ мөнгийг хэзээ өгөх юм бэ” хэмээн асууж байсан. Монголбанкны тэргүүний нэр дээр хаягласан цөөнгүй асуулт тавигдсаны захын жишээ нь энэ. Хэрвээ тэр байсан бол жинхэнэ асуулгаар бөмбөгдүүлэхээр байлаа. Харин эдийн засгийн өнөөгийн байдлын талаар хүмүүсийн ой тойнд ортол ярьсан Золжаргал ерөнхийлөгч ирэх оны Мөнгөний бодлогыг импортыг орлох экспортыг дэмжсэн үйл ажиллагаанд чиглүүлнэ. Эдийн засаг үндэсний тулгууртай байж гэмээнэ хөгжинө гэж амласан нь бизнесийнхэнд өөг сонсогдоо болов уу.

Захирлуудын зүгээс валютын өсөлтөөс болж олон компани ихээхэн алдагдал хүлээсэн гэдгийг хэлж байлаа. Тэд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр валютаар гүйлгээ хийхийг хориглодог атлаа банкны зээлийг валютаар гаргахыг зөвшөөрдөг нь буруу. Бүх зүйлийг

төгрөгөөр илэрхийлж байх ёстойг хатуухан сануулж байсан.

Валютын ханшийн огцом өсөлтөөс хохирол амсаагүй баялаг бүтээгч гэж байхгүй болоод ч тэр үү, хувийн хэвшлийнхэн бухимдлаа тайлахдаа банкныхныг муусайн хувалзнууд гэж хүртэл цоллоод амжсан. Тус хурлын үеэр бизнесийн салбарт учирдаг голлох бэрхшээлүүдийг мөн хөндөж ярьсаны дотор төрийн оролцоо хэрээс хэтэрч байгааг онцолсон. Тухайлбал, “Сэргэн мандал” группын ерөнхийлөгч Ч.Төмөрчулуу “Төр ганцхан А4-ийн цаас худалдаж авдаг эрхтэй бай. Бусад худалдан авалтад огт оролцох хэрэггүй” хэмээв. Түүнчлэн хүнд суртлыг ихээхэн шүүмжилж мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагатай үүрэг, хариуцлага нэн даруй хуваан авч, хамтран ажиллах хүсэлтийг тавьсан юм. Төр өнөөдөр бүх тусгай зөвшөөрөл, зураг төсөл, мэргэшсэн инженерийн сургалт, норм дүрмийн шинэчлэлийн асуудлыг ганцаараа хариуцаж буй нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж буйг барилгын салбарынхан учирлаж байв. Барилгын зөвлөгөө мэдээллийн төвийн захирал Г.Батсүх “Зам тээвэр болон Барилга, хот байгуулалтын яам орон сууцны үнийн асуудлыг бус орон сууцыг олноор нь чанартай, хямд өртгөөр барих асуудлыг бодлогоо болгож ажиллах ёстой. Энэ л тэдний үүрэг” гэлээ. Түүнчлэн тэрбээр бизнес эрхлэгчдийн хөгжлийн хурдыг төрийн бодлого чиглэл, үйл ажиллагаа гүйцэж чадахгүй байгаад ихээхэн шүүмжлэлтэй хандаж байлаа. Түүнчлэн одоогийн барилгын салбарт мөрдөж буй норм, дүрэм стандартад тохирохгүй гэх шалтгаанаар барилгын үйлдвэрлэлд шинэ дэвшилтэт техник технологи, богино хугацаанд барилгын ажлыг гүйцэтгэх аргачлалыг нэвтрүүлж чадахгүй байгаа нь тус салбарын хувьд баглуулчихсан байгаагаас ялгаагүйг хэлэх хүн олон байсан юм. Барилгын салбарынхан учирлах, уурлах нь зэрэгцэн зөвшөөрөлгүй барилгын цаана нөгөө талаас шат дамжлага олон хэвээр байна, хүнд сурталд хүлэгдсэн барилгачид байдгийг хэлээд, төрийн үйлчилгээг

шуурхай болгохыг хүсч буйгаа илэрхийлсэн. Эс бөгөөс одоогийн зөвшөөрөл олгодог байдал, норм, стандарт, зохицуулалтаар иргэдээ орон сууцжуулна гэдэг үлгэр гэсэн юм.

## Архимед: Надад тулах цэг өгөөч, би ертөнцийг эргүүлэе

Монгол улсад өнөөдөр 40.000 жижиг, дунд үйлдвэрлэгч, холдингийн хэмжээнд 300, ТОП 20 аж ахуйн нэгж байна. Хүн хөгжиж, бизнес тэлдэг. Гэтэл бизнесийн салбарт учирдаг олон саад бэрхшээл, дарамт хүндэрлээс дээрх компаниуд томрох бус дампуурчихгүйг хичээж байгааг Санхүүгийн зах зээлийн холбооны тэргүүн Ө.Ганзориг тавьсан илтгэлдээ онцоллоо. Тэрбээр “Жижиг, дунд үйлдвэрлэгчдээ дэмжиж бизнесийн цар хүрээг нь тэлмээр байна. Харин хөлөө олчихсон том компаниуд глобал түвшинд ажиллах, гадаад зах зээлээс хөрөнгө татаж ажиллах хэмжээнд хүрэх цаг болсон” хэмээсэн. Энэ талаар ярихдаа тэрбээр дээрх Архимедийн хэлсэн үгийг ишилсэн нь Монголын хувийн хэвшлийн салбарт боломж олгооч гэдгийг хэлчих шиг болсон.

Чуулганд оролцогчдын зүгээс олон зүйлийн талаар ярьсан ч тэдний хэлсэн нь тодорхой хэдэн асуудалд нэгтгэгдсэн байлаа. Тэр нь ажил олгогчийн зүгээс төлдөг бүх төрлийн татварын хэмжээг таван хувь руу бууруулах, социализмын угшилтай Хөдөлмөрийн хуулийг шинэчлэх, уул уурхайгаас бусад үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортыг дэмжих, валютын ханшийг тогтворжуулах зэрэг асуудлаар ярилцсан.

Хөлсөө дуслуулж олсон орлого нь татвар, цалин хөлст явчихаар компанид хуримтлал үүсэхгүй байгаа нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэх бололцоогүй болгож, татварын тайлан дээр л баян компани байгааг учирлав. Тухайлбал, “Наран” группын ерөнхийлөгч С.Болдхэт “НӨАТ-ыг таван хувь болгоё. Төсвийг зарцуулахад татвар төлөгчдийн хяналтыг бий болгох цаг болсон. Сайд ►

дарга нар хатуухан хэлэхэд татвар төлөгч бидний зарц шүү. Тийм байж бидний хоёр жилдээ нэг гаргадаг дуу хоолойг сонсохгүй, худлаа ярихаас цаашгүй байгаа нөхцөлд бүгдээрээ жагсаж цугладаг дараагийн шатны арга хэмжээнд шилжицгээе” хэмээн уриалж, тодорхой саналууд гаргасан нь олны талархлыг хүлээв.

Үйлдвэрлэгчдийн зарим нь бизнес эрхлэхэд улам бүр хүнд болж байгааг хоолой нь зангиран, жишээ баримттай хэлж байсан. Энэ үед сэтгүүлчийн хувьд хуралд С.Дэмбэрэл гишүүнээс гадна албаны томчуудаас байсан ч болоосой, хэлж ярьсан нь энэ хэвээрээ бодлого тодорхойлогчдод хүрэх болов уу гэж эргэлзэж сууснаа нуух юун. Тухайлбал, манайд татварын сул бодлого, өндөр татвартай байгаагаас гадна сүүлийн үед улсын төсвийн орлого их хэмжээгээр тасарч байгаатай холбоотой татвар төлөгчдөөс аль болох ахиу татвар авах гэсэн оролдлого, дарамт ихэссэн байна. Мөн татвар төлөгчдийн мөнгө ямар ч хяналтгүй урсаж байгаа болон бизнесийн дарамт шахалт, хүнд суртал хөнгөвчлөгдөхгүй байгаад бухимдсан зарим нь “Тэжээгчээ хянадаг тэжээлгүүлэгч” байдаг юм уу гэж хүртэл хэлэх нь сонсогдсон.

С.Болдхэт “Хувийн компанийг элдэв янзын хууль, давхар хяналт шалгалтаар чангалаад байдаг атлаа улсын төсөв дутахад ямар хяналт шалгалт явуулж, хэн хариуцлага хүлээж байгаа юм бэ. Нэг хүнд цалин өгч үзээгүй хүмүүс төрийн бодлого тодорхойлж сууна шүү дээ. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжихийн тулд УИХ-д байгаа хэдэн бизнесмэн гишүүн лообий бүлэг байгуулах хэрэгтэй” гэв.

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэлийн хэлснээр өнөөдөр НӨАТ-аас болж асуудалд ороод байгаа 2500 компани бий учраас эрүүгийн гэмт хэрэгтэн болоход ойрхон байгаа компанийн захирлууд ч цөөнгүй байгаа аж. Тус танхимын дэргэд татварын асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа юм байна. НӨАТ-ыг үгүй хийж тэглэх саналтай хүн ч цөөнгүй байлаа.

Компанийн эзэд жилийн жилд хоорондоо хоосон яриад суух нь утгагүйг хэлж, ундууцаж байсан ч С.Дэмбэрэл гишүүн Засгийн газарт

өргөн барихаар зэхэж буй 65 зүйл бүхий УИХ-ын тогтоолын төсөлд хурлаас гарсан оновчтой саналуудыг тусгана гэдгээ хэлсэн юм. ■

## “CEO SUMMIT 2013”-д оролцогчдын төлөөллийн үгийг хүргэе.



**Л.Даваажаргал**

*“Бридж” группын захирал.*

-Бизнесийн салбарт арилжааны зээлээс өөр хөнгөлөлттэй зээл олдох боломж бараггүй. Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээл тодорхой хэмжээгээр гараад эхэлсэн ч импортлогч, жижиглэнгийн худалдаачид үндсэндээ орхигдоод байна. Худалдааны даатгал, зээлийн даатгал гэсэн хэлбэрүүдийг ядаж дэмжээд өгмөөр байна. Валют зохицуулалтын асуудлын хувьд бидэнд энэ жил хамгийн их хүндрэл учруулсан. Аж ахуйн нэгж валютаар гүйлгээ, гэрээ хийх эрхгүй байгаа. Гэтэл банк ам.доллараар бидэнд зээл өгөөд байдаг. Монголд банкны засаглал үүсчихсэн байна. Хүнд үе тулгарахад хамаг хөрөнгийг минь зарж, мөнгөө аваад уснаас ганцаараа хуурай гарчихдаг. Биднийг үндсэндээ шимэгчилж байна. Тэгэхээр зээлийг банк ч адилхан төгрөгөөр гаргахыг зааж өгөх хэрэгтэй. Гуравдугаарт, төр өөрөө валют зохицуулалтад зохисгүй хандлага гаргаад байна. Жишээлбэл, Онцгой албан татварыг хуулинд ам.доллараар тогтоосон байдаг. Гэтэл Монгол Улсын нутаг дэвсгэрт ам.доллараар арилжаа хийхгүй гэсэн хууль хаана хэрэгжиж байна вэ. Яагаад онцгой татварыг ганцхан ам.доллараар авах ёстой гэж. Улс өөрөө үлгэр жишээ үзүүлмээр байна.

**Б.Лхагважав**

*/ “Үндэсний соёмбо” хөдөлгөөний тэргүүн/.*



-Бизнес эрхлэгчдэд нэн тэргүүнд татварын өршөөл үзүүлэх хэрэгтэй байна. Өмнө нь том татвар төлөгчдөд хуримтлагдсан татварын өрийг өршөөж байсан. Гэхдээ тэр нь Монголын нийт компанийн хоёрхон хувийг л хамарсан. Одоо бол том, жижиг гэж ялгалгүй нийтэд нь өршөөл үзүүлж, хувийн хэвшлийн санхүүгийн хувьд цэвэрлэж аваад, татварын ил тод, нээлттэй, шударга тогтолцоог бүрдүүлээд явах нь зөв. Бизнесийн байгууллагуудын санхүү нэлээд булингартай байна шүү дээ. Ийм нөхцөлд өөрчлөлт гаргана гэдэг хэцүү. ▶



**Д.Галсандорж**

*Монголын экспортлогчдын холбооны гүйцэтгэх захирал:*

-Сүүлийн үед нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох талаар монголчууд их ярьж байна. Зарим арга хэмжээг ч аваад эхэлсэн. Харамсалтай нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээл тусламжийн асуудал, бондын санхүүжилт экспортыг дэмжих хэмжээнд байж чадахгүй байна. Дотоодын зах зээлд босгосон бондын эх үүсвэрээр ноос, ноолуурын салбарыг дэмжиж байгаа. Гэхдээ арьс ширний үйлдвэрлэлийг дэмжсэн 140

тэрбум төгрөгийн санхүүжилт одоо ч алга. Тиймээс үйлдвэрлэлээ дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх л шаардлагатай байна. Нөгөөтэйгүүр гаалийн үйлчилгээг шуурхай болгох, хууль хяналтын үйл ажиллагааг сажруулах учиртай. Мөн импортын худалдаанд НӨАТ болон бусад татварын үнэлгээ бодит бус байна. Хэдийгээр Засгийн газрын түвшинд лицензийг цөөлөх, бизнесийн орчныг сайжруулах гээд зарим ажлыг хийж байгаа ч мэргэжлийн хяналт, гаалийн байгууллага дээр ирээд хэрэгжилт нь гацчихаад байгаа юм. Дээрээс нь экспортыг дэмжсэн төрийн бодлого гаргах шаардлага бий.



**Н.Даш-Өлзий** /"Өлзий төв"-ийн захирал:

Үйлдвэрлэл болоод жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд зах зээл хэрэгтэй. Зах зээлийг Монголдоо хайх нь хэцүү. Учир нь манай зах зээл жижиг. Тиймээс гадаад зах зээлд гарах нь бидний нэг том боломж юм. Гадаад зах зээлд гарахын тулд чөлөөт худалдааг бий болгох хэрэгтэй байна. Орос, Хятад, АНУ-тай чөлөөт худалдаа хийхэд төрөөс бодлогоор дэмжээд, хөрөнгө санхүүг нь гаргаад өгмөөр байна. Энэ бол ЖДҮ-ийг дэмжих ганц арга юм. Тухайлбал, Монголын оёдлын

үйлдвэрт гадаад зах зээл нээлттэй байхад 100 гаруй үйлдвэрт 25 мянга орчим ажилчин ажиллаж жилдээ нийт 30 сая гаруй хувцас экспортолдог байлаа. Учир нь тухайн үед АНУ-ын зах зээл бидэнд чөлөөтэй байсан юм. Эндээс харахад чөлөөт худалдаа хийх нь ажлын байрыг нэмэгдүүлэх, гаднын хөрөнгө оруулагчдыг татах, экспортыг дэмжих гол арга. Мөн гол орнуудад гадаад худалдаа хариуцсан туршлагатай дипломатчийг томилж, ажиллуулах шаардлага бий. Үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн гадаад зах зээлд хандсан оролдлого хүчин мөхөстөж, дэмжлэг дутдаг.



**Я.Энхтайван**

*"Их харанга" компанийн захирал:*

-Компаниудын үйл ажиллагааг түлхэгч хүч нь реклам сурталчилгаа байдаг. Гэтэл энэ үйл ажиллагааг ихээхэн нугачин дарж байна. Хурал дээр ч мөн олон хүн шүүмжилж үүнийг хэллээ. Хөгжингүй орнуудад хотын захаар, мөн онцлог хэсгүүдэд рекламны самбарууд байрласан байдагтай жишиж үзээд байх шиг байна. Манайд Нисэхээс хот руу чиглэх замд байсан ч одоо байхгүй болсон. Өнгөрсөн онд Нисэх, Яармагийн замыг өргөтгөх зорилгоор компаниудад рекламны

самбаруудаа 30 метр дотогшлуулах мэдэгдэл өгсөн. Үүний дагуу компани бүр дунджаар дөрвөн сая төгрөгийн зардлаар тус шаардлагыг биелүүлсэн. Гэвч энэ онд бүх самбарыг буулгасан нь ямар ёс суртахуун бэ. Энэ хооронд татвараа авч л байсан. Нийслэлийн захирагчийн албанд саналаа хэлэхээр рекламны зөвшөөрөл олгохгүй гэх мэтээр дарамталж байна. Энэ бол компаниудыг боож унагаад байгаагийн нэг л жишээ. Валютын ханшийг их ярилаа. Ямар ч улсад валютын ханшийг тогтворжуулах нэг л арга байдаг. Үйлдвэржилт явагдаагүй цагт ханш мөнхөд савлана. ■

## ШИЛДЭГ ИЛТГЭЛ

# “БҮГДЭЭРЭЭ ХЯМРАЛ ЯРИАД ЭХЛЭХЭЭР ХЯМРАЛААС ГАРЧ ЭХЭЛДЭГ”



*Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалын өнгөрсөн сарын 25-нд Төрийн ордонд болсон “Захирлуудын дээд хэмжээний чуулган”-ы Банк, санхүүгийн салбар хуралдааны үеэр тавьсан илтгэлийг бүрэн эхээр нь сонирхуулж байна. Түүний итгэлийг хуралд оролцогчид шимтэн сонссон бөгөөд асуулт хариултын цагаар сэтгэгдлээ хэлсэн зарим нь бизнес эрхлэгчдэд эдийн засгийн өнөөгийн байдлын талаар бүрэн мэдээлэл, мэдлэг өгсөн сайн илтгэл байлаа гэж олзуурхаж байсан бол худлаа үнэн баахан зүйл ярьж, иргэдийн тархийг угаачихаад, асуултад хариулахаас зугатаж, хурал орхиж явлаа гэж шүүмжлэх нь ч байсан.*

2012 онд хоёр зүйл маш ойлгомжтой байсан. Нэгдүгээрт, зээл нэлээд хумигдчихсан. Хоёрдугаарт, ханш байрандаа байгаад байгаа мэт боловч Монголд орж ирж байгаа валют эрс багасчихсан байлаа. Хэрвээ энэ байдал удаан үргэлжилсэн бол юу болох байсан бэ. Гэхдээ энэ байдлыг заавал үргэлжлүүлэх албагүй л дээ. Үргэлжлүүлэхгүй байхын тулд Монголбанкнаас арга хэмжээ авсан. Тиймээс үргэлжилсэн бол юу болох байсан талаар ярихаасаа илүү ямар арга хэмжээ авсан талаар цухас дурдъя. Монголбанкнаас 2013 оны эхнээс Үнэ тогтворжуулах хөтөлбөр зарласан. Энэ нь анх удаа монголчууд инфляцитай тэмцэхийн тулд эдийн засагт мөнгө хийсэн тохиолдол юм. Хоёрдугаар сараас хөтөлбөрийн үр дүн гарч эхэлсэн. Ялангуяа шатахуун дээр үр дүн нь харьцангуй сайн гарсан. Хэрвээ арванхоёрдугаар сараас шатахууны үнийг бууруулах хөтөлбөр явуулаагүй байсан бол хоёрдугаар сар гэхэд шатахууны үнэ валютын ханшийн савалгаатай холбоотой бараг 50 хувь нэмэгдэх байлаа. Энэ бол Монголбанкны бодлого эдийн засгийг хамгаалсан энгийн жишээ. Мөн зээл хумигдаж эхэлсэн тэр үед Монголбанкнаас арилжааны

банкуудад зээлийн эх үүсвэр тавьж өгсөн. Үүний үр дүнд өдгөө эдийн засаг харьцангуй тогтвортой байна. Хэрвээ Монголбанкнаас арга хэмжээ аваагүй байсан бол эдийн засаг хямрах нь дамжиггүй байсан юм шүү. Нийт дүнгээрээ 2.8 их наяд төгрөгийг Монголбанк эдийн засагт хийсэн. Үр дүнд нь инфляци есөн хувьтай байна. Гэтэл манай гадаад нөхцөл байдал огт сайжраагүй. Хөрөнгө оруулалтын орчин муудаж, валютын дотогшлох урсгал саарсаар байсан. Экспортын бүтээгдэхүүний үнэ нэмэгдээгүй, экспортлох хэмжээ ч сайжраагүй. Харин импортын хэмжээ эхний хагас жилд 10 гаруй хувиар буурсан. Нөхцөл байдал ийм муу байхад манай эдийн засаг яагаад өсөлттэй гарч, инфляци нэг оронтой тоонд орж чадсан юм бол. Энэ асуултын хариулт нь Монголбанкны эдийн засагт оруулсан мөнгө ажлын байрыг хадгалах, эдийн засгийн бодит өсөлтийг хамгаалах зорилготой байсанд гол учир нь байгаа юм. Бид төсвөөр дамжуулж эдийн засагт мөнгө хийгээгүй. Харин арилжааны банк руу мөнгөө оруулсан. Тэр мөнгө нь зах зээлийн дунджаас доогуур ханштай зээлийн эх үүсвэр байсан юм. Яагаад хувийн сектороор дамжуулж зээлийн эх үүсвэрийг өгсөн юм бол гэж гайхаж

магадгүй. Өнөөдөр эхний хагас жилийн эдийн засгийн тайлан, судалгаа нэгэнт гарчихсан тул энэ талаар дахин давтаж хэлээд хэрэггүй байх. Харин ганцхан жишээ хэлье. Эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээг 13 хувиар нэмж байхад ДНБ 11 хувиар өссөн байна. Гэхдээ өсөлт бууралт гол нь биш. Долоон хувийн өсөлттэй эдийн засаг 14 хувиар огцом өсч байсан шүү дээ. Тиймээс гол нь үр дүн. Эдийн засаг хямарч магадгүй нөхцөл байдалд хувийн сектороор дамжуулсан зөв бодлого өдгөө үр дүнгээ өгсөнд л гол учир нь байгаа юм. Та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр барилгын салбар өмнөх жилтэйгээ харьцуулахад 125 хувийн өсөлт үзүүлчихээд байна. Барилгын материал үйлдвэрлэдэг 240 гаруй компани бий. Эдгээрийн дийлэнх нь импортын барааг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлээд эхэлсэн. Тиймээс бид хэрвээ эдийн засгаа дэмжих гэж байгаа бол мөнгөн эх үүсвэрийг аль болох хувийн сектороор дамжуулах нь зөв юм аа гэдэг нь эндээс харагдана. Дотоодын барилгын компаниудад өгч байгаа зээлийн эх үүсвэр гурван жилийн хугацаатай. Үүний цаад учир нь эдийн засаг хямарч магадгүй үед тогтвортой ажлын байраа авч үлдэх, үйлдвэрлэлийг дэмжихэд ▶

► чиглэсэн бодлоготой холбоотой. Бидний үзэж байгаагаар Монголын эдийн засгийн хамгийн хүнд хэцүү үе ард хоцрох шиг боллоо. Өдгөө эдийн засгийн хямралыг олон хүн олон янзаар тайлбарлаж байна. Харин Монголбанкны зүгээс хариуцлагатай мэдэгдэхэд 20 орчим сар үргэлжилж байгаа гадаад худалдааны шок, хоёр сонгууль дамжсан төсвийн том тэлэлт, алдагдал үргэлжилсэн энэ хугацаанд эдийн засгаа сулруулахгүй авч гарч чадлаа. Бидний сайн мэдэж байгаагаар гадаадын хөрөнгө оруулалтыг сааруулсан олон хуулийн үр дүнд манай эдийн засаг өмнөх жилтэй харьцуулахад жилдээ 1-2 тэрбум ам.долларын алдагдал хүлээгээд байна. Мөн эдийн засгийн суурь өөрчлөлтийг харахад 2-3 тэрбум ам.долларын хөдөлгөөнд орчихсон. Энэ бол нөхцөл байдал муудаж байгаагийн энгийн жишээ. Ийм нөхцөлд манай хувийн сектор, тэдэнд чиглэсэн зээлийн хямд эх үүсвэр, энэ олон барилгын компаниуд, тэнд ажиллаж байгаа хүмүүс, тэдний бүтээсэн баялаг л эдийн засгийг тэнцвэржүүлсэн гэж хэлж болно. Дээрээс нь эдгээр ажлын байранд тулгуурласан моргейжийн шинэ тогтолцоо Монголын эдийн засаг дахь бас нэг шинэ зүйл байлаа. Тэгвэл энэ байдал цаашдаа үргэлжлэх үү. Миний бодлоор зайлшгүй үргэлжлүүлэх ёстой бодлого бол энэ.

Монголын эдийн засагт дутуу байгаа хоёр зүйлийн эхнийх нь дотоодын үйлдвэрлэл. Инфляцитай тэмцэхийн тулд, төлбөрийн тэнцэлийн алдагдлаас гарахын тулд, улсын төсвийн орлогоо бүрдүүлэхийн тулд гээд аль ч талаас нь харсан Монголын

эдийн засагт дотоодын үйлдвэрлэл чухал. Япон улсад ханшийн 10 хувийн хөдөлгөөн инфляцид нь 0.25 хувь нөлөөлдөг. Гэтэл манайд ханшийн 10 хувийн хөдөлгөөн инфляцид дөрвөн хувиар нөлөөлдөг байх жишээтэй. Энэ бол бид валют, гадаад худалдаанаас ямар их хамааралтай байгааг харуулж байгаа хэрэг. Хэрвээ манай дотоодын үйлдвэрлэл хөгжихгүй бол нөхцөл байдал даамжирсаар л байх болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монголын эдийн засаг яг энэ бүтцээрээ цаашаа явах уу гэсэн маргаан үүсээд байх шиг байна. Ингэж их импортоос хамаардаг Монгол Улс цаашаа хэр хол замыг туулах вэ. Хэрэв ханш чангараад байвал юу болох вэ?

Монголын дотоодын үйлдвэрийн өрсөлдөх чадвар 1150-1200 ам.долларын төгрөгтэй харьцах ханш дээр тогтоод байгаа юм. Хэрвээ валютын ханш үүнээс доошоо орчихвол манайд үйлдвэр байх хэрэг алга. Бүгдийг нь эрэнээс татах нь илүү хямд. Макро эдийн засгийн түвшний судалгаагаар одоо байгаа ханшийн чангарал магадгүй үүнээс ч илүү ханшийн чангаралтай бол манай дотоодын үйлдвэрлэлүүдийн өрсөлдөх чадвар сайжирна. Гэвч манайхан импортын бүтээгдэхүүн хэрэглээд сурчихсан. Тэр импортын бүтээгдэхүүнээрээ баялаг бий болгоод сурчихлаа. Гэхдээ бид яагаад импортын барааг дотооддоо үйлдвэрлэж болохгүй гэж. Хэрвээ бид үйлдвэрлэлд нь хэрэгтэй тэр эх үүсвэрийг нь бий болгоод өгч чадвал энэ биелэх боломжтой мөрөөдөл. Тиймээс Монголбанк бодлогоо энэ зүг залж байна. Энэ жил дотоодын

үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарлаа. Бидний хүсээд байгаа зүйл бол дотооддоо үйлдвэрлээд экспортын чадамжтай болж чадсан үйлдвэрлэгчдийг урамшуулах системийг бүрдүүлэх юм. Энэ нь манай өрсөлдөх чадварыг сайжруулна. Яваандаа инфляцид эерэгээр нөлөөлөх учиртай. Тухайлбал, бид шатахуун дээр туршилт хийсэн нь амжилттай боллоо. Энэ онд бид шатахуун дээр 50 төгрөгийн нөлөөлөл авлаа. Шатахуун гэдэг нь өөрөө үнийн том өдөөгч хүчин зүйл. Тиймээс Монголбанк энэ өдөөгч хэсэгт анхаарлаа хандуулсан. Бодлого маань ч үр дүнгээ өгөөд явж байна.

Магадгүй маргааш ч төгрөгийн зээлтэй нь торгуулаад валютын зээлтэй нь ашигтай байдаг хувилбар руу шилжиж болно. Гэхдээ бид нэг талдаа төгрөгийн зээл нь ашигтай. Нөгөө талдаа валютын зээл нь ашигтай аль аль нөхцөлд нь байж үзсэн. Эндээс юу харагдаж байна гэхээр хэт хөдөлгөөнтэй байх нь хэнд ч ашиггүй гэдгийг л олж харж болох юм. Тиймээс аль болох тогтвортой, таамаглах боломжтой байх нь л бидэнд хэрэгтэй. Тэр дундаа тогтвортой байх механизм дотроо төгрөгийн орлоготой компаниуд нь валютын зээл авч байгаа тохиолдолд тэрийг нь зохицуулдаг механизмыг нь Монголбанк хийхээр төлөвлөж байна. Магадгүй яг одоо ам.долларын зээлтэй байж байгаад гашууныг нь амсчихаад, төгрөгийн зээл рүү шилжиж байгаа нь ирээдүйд бүр ч гашуун байж болно. Ер нь аливаа зүйл хоёр талтай. Эрсдэл ч ялгаагүй. Манай улсын хувьд валютын орлогоо нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хэрвээ байдал энэ хэвээрээ удаан үргэлжилэх юм бол бидний өрсөлдөх чадвар, дархлаа маань улам л муудна.

Ирэх онд бид экспортыг дэмжих тэр дундаа уул уурхайн хамаарлаас гарахыг эрмэлзэж байна. Ойрын гурван жилийн хугацаанд уг хамаарлыг мэдэгдэхүйц бууруулах шаардлага зайлшгүй бий. Өнөөгийн уул уурхайтай холбоотой эдийн засгийн савлагаа, төлбөрийн тэнцлийн алдагдал, төсвийн алдагдалыг давахад үнэхээр хэцүү. Энэ их давалгаан дунд бид алдагдал хүлээсээр л байна. Тийм учраас нийт экспортын ядаж 20-30 хувийг уул уурхайн бус бүтээгдэхүүн болгох ►►



хэрэгтэй. Тэгэхгүй бол эдийн засаг урт хугацаандаа тогтвортой байх нь хэцүү. Ер нь эдийн засгийн болоод нийгмийн үр ашгийг харсан ч уул уурхайн бусад салбараа дэмжих зайлшгүй шаардлага монголчуудад бий. Тийм л учраас энэ онд Монголбанк барилгын салбар руу итгэлтэй орсон юм. Одоо бусад салбарыг дэмжих хууль эрх зүйн орчин хэрэгтэй байна. Энэ бүхний үр дүнд зээлийн хүү буурах учиртай. Гэхдээ зээлийн хүүтэй холбоотой өөр нэг асуудал нь зээлийн эргэн төлөлт байдаг. Энэ намрын чуулганаар бид зээл авсан л бол эргэн төлдөг тэр механизмыг хуульчуулахаар төлөвлөж буй. Тиймээс бидний мөрөөдөөд байгаа энэ орчинд зээл авсан бол зээлийн нөлөөл нь жилийн 3-4 хувь л байх болов уу гэж төсөөлж байгаа. Дээрээс нь бүх зээл хадгаламж талаас хамаардаг. Монголын нийт хадгаламжийн хэмжээ, хадгаламжийн хугацаанаас шууд хамаарч байна. Манай эдийн засагт хөрөнгө оруулалтын сан, урт хугацаатай мөнгөний эх үүсвэр алга. Хамгийн том хуримтлал буюу тэтгэврийн сан ерөнхийдөө 0 дүнтэй яваад байсан. Одоо моргейжийн хөтөлбөр орж ирсний үр дүнд тэтгэврийн санд зарим нэг эерэг үр дүн гарч байгаа. Цаашдаа ч сайжирна. Монголд ажлын байр хангалттай бий. Тэдгээр хүмүүс ирээдүйн тэтгэвэртээ зориулж мөнгө хадгалуулна. Энэ бол бидний урт хугацааны зээлийн эх үүсвэр. Тиймээс бид энэ мөнгийг л үржүүлэх ёстой. Мөнгөгүй бол зээлийн хүүг бууруулна гэдэг хэрэгжүүлэхэд хэцүү мөрөөдөл болж хувирна. Нөгөө талдаа төлбөрийн тэнцэл, ханшийн том алдагдал хүлээнэ.


Өөр нэг том асуудал бол алт. Нэг хэсэг Монголбанкиндаа алт тушаадаг тэрний эсрэг төгрөг гаргадаг байлаа. Гэтэл одоо байдал эсрэгээрээ байна. Дэлхий дээр мөнгөтэй, валюттай болдог хэд хэдэн арга байдаг. Тэр дундаа валют олдог дөрвөн урсгал нь дөрвүүлээ Монголд байна. Зарим улсад гурав байдаг. Манайд байгаа нэг том давуу тал бол алт. Бусад улсад тийм ч олон тохиолдоод байхгүй боломж. Гэтэл өдгөө дотооддоо байгаа алтаа Монголбанкинд тушаадаггүй. Шууд л гаднын аль нэг Төвбанкинд зараад байдаг. Магадгүй Монголын

улсын төсвийн сонирхол нь гаднын Төвбанкинд алтаа худалдаад таван хувийн татвараа авах байж болно. Гэхдээ Монголбанк, Монголын эдийн засгийн дунд болон урт хугацааны сонирхол арай өөр. Манайд олборлосон алтыг Хятадын Төвбанк руу биш, Монголын Төвбанкинд тушаагаад 2.5 хувийн хөнгөлөлт эдлүүлэх юм. Үүний гол учир нь нийт алтны 97.5 хувийг Монголын эдийн засагт үлдээх эдийн засгийн сонирхол. Гэтэл одоо эсрэгээрээ Монголд олборлосон алтыг 100 хувь гадагшаа гаргаад Монголын төр ердөө таван хувийн татвар аваад сууж байна. Алт гэдэг өөрөө миний түрүүний ярьсан эдийн засаг дахь урт хугацааны мөнгөний эх үүсвэр юм. Хэрвээ бидний хүсээд байгаа Монголд олборлосон алтыг Хятадын Төвбанк руу биш, Монголын Төвбанкинд тушаагаад 2.5 хувийн хөнгөлөлт эдлүүлэх тухай хууль батлагдчихвал хэн хэндээ хэрэгтэй. Нөгөө талдаа тэр алт нь валютын цэвэр нөөц болоод Монголбанкинд хадгалагдах эдийн засагт эерэг нөлөөтэй. Тиймээс бид энэ мэт урт хугацааны мөнгөний эх үүсвэрээ бий болгоогүй байж Монголбанк эдийн засагт мөнгө хийгээд үйлдвэрлэлээ дэмжээд, инфляцитайгаа тэмцээд байх нь тийм ч таатай зүйл биш. Тиймээс бид валютын орох урсгалыг дэмжих хэрэгтэй. Валют орж ирэх хэд хэдэн хаалга бий. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, алт, зээл буюу бонд гаргах. Эдгээрээс хамгийн аюулгүй нь магадгүй алт байж болох юм.

2014 онд баримтлах мөнгөний бодлого экспортыг дэмжихэд чиглэнэ. Үүний тулд бидэнд урт хугацаатай мөнгө хэрэгтэй. Тиймээс урт хугацаатай мөнгийг бий болгодог дээрх хүчин зүйлийг анхааралдаа авах учиртай. Ингэж чадвал бид уул уурхайн хамаарлаас гарч чадна. Өдгөө Монголбанк бодлогын хүүгээ бууруулсан. Үүнээс ч илүү бууруулах боломж байсан. Гэхдээ Монголд орж ирэх валютын урсгал маш сул байсан юм. Валютын орох урсгал сайн байсан бол бид бодлогын хүүгээ үүнээс илүү бууруулж төдий чинээ ажлын байрыг нэмэгдүүлэх байлаа. Дундаж зээлийн хүү 7.5 хувьтай байвал нийт эдийн засгийн

идэвхжилт 10 дахин илүү болдог юм.

Эцэст нь дүгнээд хэлэхэд 2013 он бол эдийн засгийн уналтыг саармагжуулсан жил боллоо. Бид үүнээс илүү хатуу унах байсан байж болзошгүй юм шүү. Хэрвээ эдийн засагт 2.8 их наяд төгрөг нийлүүлээгүй байсан бол манай эдийн засаг дахь мөнгөний хэмжээ 23 хувиар бага байх байлаа. Хэрвээ нийт мөнгөний хэмжээ ийм бага байсан бол нэг ч зээл эргэн төлөгдөхгүй байсан. Ингээд л манай эдийн засаг хямрах байлаа. Ер нь бүгдээрээ хямрал яриад эхлэхээр л хямралаас гарч эхэлсэн байдаг юм. Хямрал хэзээ ч хэлж ирэхгүй. Гэхдээ бүгд хямрал яриад эхэлсэн үед бүгд бүсээ чангалаад эхэлчихсэн, бүгд орлого зарлагаа сайн хянаад эхэлчихсэн байдаг. Тиймээс ирэх онд эдийн засаг овоо өсөх байх. Учир нь энэ онд бид их олон зүйлээ аваад гарчихлаа. Миний бие анх удаагаа Монголбанкны ерөнхийлөгчийн хариуцлагатай албыг авсан энэ цаг үед эдийн засгийн ийм нөхцөл тохиосон нь их том сорилт байлаа. Өнөөдөр ямартаа ч эдийн засгийн өсөлт 11, инфляци есөн хувьтай байна. Ажлын байраа ер нь аваад гарлаа. Гэхдээ ханшийн хөдөлгөөн тийм ч таатай мэдээ байсангүй. Тогтворгүй гэдэг утгаараа бүгдэд нь муу. Хүсч байсан зүйл биш. Гэхдээ энэ бол зайлшгүй болох байсан хүчин зүйл юм. Ханшийн эсрэг тэмцэх нөөц Монголбанкинд байгаа юу гэвэл байна. Нийт 2.7 тэрбум ам.доллар нөөцөд байна. Юанийн нөөц ч байгаа. Гэхдээ энэ нөөцөө шавхаж болохгүй. Маргааш өнөөдрөөс хэцүү үе ирвэл яах вэ. Үүнд л бид бэлтгэлтэй байх учиртай. Гэхдээ одоо ханш буурч байна. Цаашдаа тогтворжих байх. Он дуустал хэрэглээний импорт нэмэгдэхээр байгаа. Гэхдээ хэрэглээний сагсанд ордог импортын барааны ихэнх тэвчиж болдог бүтээгдэхүүн. Валютын орох урсгалыг сайжруулахын тулд төр, засгаас олон зүйл хийж байна. Валютын орох урсгалыг дэмжсэн хуулиуд нь батлагдаасай. 170 мянган ажлын байраа хадгалж үлдсэний ач 2014 онд гарах байх. ■

TYRES  
MINING**MAGNA MA04**

- Improved shoulder and sidewall protection
- Deep aggressive pattern
- Excellent traction

**MAGNA MA0**

- High resistance to heat build, cutting and
- Deep tread pattern with sidewall protection
- Excellent traction



# БИД ДУГУЙГ “ХАЛАМЖИЛДАГ”

Монголын эдийн засагт хамгийн их үүрэгтэй уул уурхайн салбарын шилдэг техник технологийг дэлхийн өнцөг булан бүрээс Монголд авчирч танилцуулдаг “Mongolian mining- 2013” үзэсгэлэнгийн үеэр “Магна Тайрес” группын Олон улсын худалдааны борлуулалтын менежер Рэтэр Шридэрингтэй ярилцлаа.

**-Танд энэ өдрийн мэнд хүргэе. Ярилцлагаа танай бизнесийн түүхээс эхлэх үү?**

-Сайн байна уу. Миний нэрийг Рэтэр Шридэринг гэдэг. Би “Магна Тайрес” группын Олон улсын худалдааны борлуулалтын менежер. “Магна тайрес” групп нь анх гэр бүлийн бизнес хэлбэрээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Тэртээ 1947 онд Малайз, Индонез зэрэг улсаас түүхий эд авч гутал хийдэг байсан. Харин одоо бүх төрлийн авто машины дугуй үйлдвэрлэж, дугуйн салбарт хүч үзэж байна. Анх 1974 онд дугуйн салбарт орж байсан. 2005 онд “Магна” нэртэйгээр өөрсдийн анхны брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд, дэлхийн зах зээлд өндөр чанартай, нэр хүндтэй дугуй үйлдвэрлэгч болтлоо өсөн дэвшиж байна. Бид үйлчлүүлэгчиддээ уул уурхайн хүнд даацын болон үйлдвэрлэлийн зориулалттай авто машинуудын олон төрлийн дугуйг санал болгодог. Тухайлбал, ачаа зөөгч, кран, боомтын ачаа зөөх техник, уул уурхайн бүх төрлийн хүнд даацын авто машины дугуйг чанарын өндөр түвшинд хийж байна.

**-Тэгвэл танай бүтээгдэхүүний онцлог, технологийн давуу тал нь юу вэ?**

-Манайд радиал, байас гэх хоёр төрлийн дугуй үйлдвэрлэдэг. Радиал дугуй нь хол замд, хурдтай явахад тохиромжтой бол байас дугуй нь ойрын замд, бага хурдтай явдаг боомтын машинуудад зориулагдсан. Бид манай бүтээгдэхүүнийг хэрэглэж буй байгуулагуудын ажлын талбайд нь очиж бүх төрлийн судалгаа хийдэг. Энэ бол бидний хамгийн том давуу тал юм. Түүнчлэн манай дугуйг ашиглах үед түлш бага зарцуулдаг. Энэ нь нэг талаар CO2-ын ялгарлыг бууруулах нөгөө талаас хэрэглэгч нарт эдийн засгийн бага ч

атаугай хэмнэлт бий болгох боломж юм. Одоогийн байдлаар “Магна тайрес” компани дэлхийн 90 гаруй оронд дугуй нийлүүлж байгаа. Түүнчлэн 10 гаруй улсад группынхээ албан ёсны төлөөлөгчийн газраа нээн ажиллаж байна. Мөн хүнд даацын уул уурхайн машины илүү чанартай өвлийн дугуй үйлдвэрлэх чиглэлд ажиллаж байна.

**-“Магна тайрес” компанийн борлуулалтын менежерийн хувьд Монголын зах зээлийн боломжийг хэрхэн харж байна вэ?**

-Монголын өнөөгийн нөхцөл байдал нь нэг талаар хөрөнгө оруулагчдад шинэ боломж юм. Би үргэлж хэлдэг. Галт тэрэг зорчигчидоо хүлээгээд буудалдаа зогсож байхад нь амжиж суух хэрэгтэй гэж. Учир нь нэгэнт хурдаа авчихсан галт тэргэнд амжиж сууна гэдэг хэцүү. Тиймээс танай эдийн засгийн дөнгөж хөдөлж байгаа галт тэргэнд амжиж суух нь хөрөнгө оруулагчдын боломж юм.

**-Танай компани Монголын хэрэглэгчдэд ямар давуу тал амлаж чадах вэ?**

-Бид илүү чанартай дугуйг боломжийн үнээр нийлүүлэхэд анхаарч байна. Бусад Goodyear, Michellen, Bridgestone, зэрэг үйлдвэрлэгчдийн дугуйны үнэтэй харьцуулахад манай бүтээгдэхүүн маш боломжын үнэтэй. “Магна Тайрес” Монголд салбараа нээгээд нэг жил болж байна. Энэ нь бид танай зах зээлийг бусдаас арай илүү мэднэ гэсэн үг юм. Тиймээс зах зээлээ мэдэж байгаа компани эрэлтийн талын хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлэх нь ойлгомжтой. Бид Багануурын уурхайд хүнд даацын дугуй нийлүүлээд байгаа.

**-Монголын уул уурхайн компанийнхан танай дугуйг хэр сонирхож байна вэ?**

-Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн ихэнх ▶

► нь урд хөршөөс орж ирсэн, харьцангуй хямд, чанаргүй дугуйг биш илүү боломжийн үнэтэй, чанартай бүтээгдэхүүн авах сонирхолтой байгаагаа энэ удаагийн “Mongolian mining- 2013” үзэсгэлэнгийн үеэр хэлж байсан. Харин “Магна тайрес” компани энэ шаардлагад нийцсэн дугуй нийлүүлэгч компани юм. Боломжийн үнэтэй, зах зээлд өрсөлдөхүйц дугуйтай байна гэсэн үг. Ашиглалтын хугацааны өртөг хямд байх нь дугуйны нийт цагт зарцуулагдах өртөг бага байх тухай ойлголт. Үүний тулд л бид дугуйн явах зам, ажиллах орчин, нутгийн цаг агаар гээд бүгдийг судалдаг. Тухайлбал, 57 инчийн дугуй 1000 цаг ажиллахад уурхайн талбай дээр очоод бүх төрлийн судалгааг хийнэ гэсэн үг юм. Судалгааны дагуу яг тухайн нутагт тохирсон дугуйг үйлдвэрлэх шаардлагыг үйлдвэрлэгч нарт хүргүүлдэг. Гэхдээ судалгаа ингээд зогсчихгүй. Судалгааны дагуу дугуй бэлэн болж, борлуулсан ч бид дугуйг солих, ашиглах, гадаргуугийн гэмтэл, дугуйн даралт, элэгдэл гээд бүх талыг судалж, “халамжилсаар” байдаг. Хамгийн чухал нь дугуйг өдөр бүр л шалгах хэрэгтэй. Тухайлбал дугуйн гадаргуу дээр үүсдэг хаванг цагаанаар үргэлж тэмдэглэх шаардлагатай. Тэр тэмдэглэгээний дагуу мэдээлэл бий болох жишээтэй. Хэрвээ манай үйлдвэрлэсэн дугуйнд гэмтэл гарвал зургийг нь авч манай компаний төв оффисийн Техник судалгааны хэлтэст хүргүүлнэ. Манай мэргэжлийн шиншээчид дугуйны гэмтлийг судалж үзээд үйлчлүүлэгчдэдээ дугуйг хэрхэн, яаж ашиглах талаар мэргэжлийн зөвлөгөө өгдөг.

Манай компаниас худалдан авагч нарт өгдөг таван жилийн баталгаат хугацааны дагуу техникийн бүх төрлийн алдааг засч өгнө. Мөн даатгалын хувьд сайн.

**-Багануурын уурхайд нийлүүлсэн дугуй Монголын цаг агаарт хэр тохирч байгаа бол. Компаниас гомдол, санал ирж байгаа юу?**

-Санал бол ирж байгаа. Бид тэр саналын дагуу зөвлөгөө болон бусад үйлчилгээг үзүүлж, хамтран ажиллаж байна. Мэдээж бид Монголын зах зээлд орж ирэхийн тулд дээр дурдсан олон хүчин зүйлийг судалсан. Эхний ээлжинд хэд хэдэн асуултыг захиалагч талдаа хүргүүлдэг. Адаглаад уул уурхайн компанид ямар техникийн талын шаардлага байгааг асуудаг. Үүнийхээ дараа хур тунадасны хэмжээ, жилийн агаарын дундаж хэм, ачих буулгах талбайн орчин, эрсдэл гээд тодорхой асуултуудад хариулт авсны дагуу эхний ээлжинд ямар дугуйг зах зээлд нийлүүлэхээ шийддэг. Ер нь дугуйн бизнесийн эрсдэл өндөр. Гэхдээ манай компани Сибир, Альяска, Латин Америк, Африк зэрэг өөр өөр уур амьсгалтай нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхай компанид зориулсан бүтээгдэхүүн нийлүүлдэг тул Монголын нөхцөлд таарахгүй гэх ойлголт байхгүй болов уу.

**-Уул уурхайн техникийн дугуйг хэрхэн зөв ашиглах тухай зөвлөгөөг манай уншигчдад өгөхгүй юу?**

-Дугуйн чанар, хэрэглээний түвшин нь олон улсад танигдсан, Олон улсын үйлдвэрлэлийн шаардлагад тохирсон, олон жилийн туршлагатай үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сонгох нь зүйтэй. Хямд өртөгөөс нь болоод чанаргүй дугуйг хэрэглэснээр бусад дугуйныхаа эдэлгээний хугацааг богиносгож энэ нь эдийн засгийн болон

амь насны эрсдэл учрах үндэс болдог.

**-Та Монголд анх удаагаа ирж байна уу?**


-Тийм ээ. Анх удаагаа ирж байна.

**-Тэгвэл та Монголын өнөөгийн нөхцөл байдлыг тэр дундаа эдийн засаг, улс орны хөгжлийг хэрхэн харж байна вэ?**

-Бүх хүмүүст хийх ажил их байна. Маш их боломж байна. Их зүйл хийх л хэрэгтэй байна даа. ■



Байас дугуй



Радиал дугуй

## ЗӨВЛӨГӨӨ

# ТҮР ЗУУРЫН ДАВУУ ТАЛ

Р.ГАНТУЛГА

Стратегийн ертөнц бол олон компанийн хувьд давуу талаа хадгалан үлдэхэд тулгардаг хүнд сорилт юм. Аливаа бизнес тогтвортой бөгөөд өрсөлдөхүйц давуу талыг бий болгохын тулд тодорхой хугацаанд хүчин чармайлт тавин ажиллах боловч цагийн уртад ямар байхыг нь таамаглахад хүндрэлтэй болдог байна. Өрсөлдөхүйц давуу талын үр дүнгээ өгөх бодит хугацаа ердөө л нэг жил үргэлжилдэг тул компаниуд зах зээлд тэргүүлэгч байр сууриа алдахгүйн тулд олон янзын өрсөлдөхүйц түр зуурын давуу талыг нэгэн зэрэг бий болгож, ашиглах стратегийн шинэ санаачилгыг тогтмол эхлүүлэх зэргээр цаг хугацааны

хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гарч ирдэг.

Цаашид бизнесээ тогтвортой байлгах зорьж буй компаниудын хувьд хувьсамтгай өрсөлдөөний талаар сайтар ойлгох нь олсон амжилтаа хадгалахад өрсөлдөгчдөө бодвол илүү сайн байдаг. Цөөхөн компани л энэхүү зорилгод хүрч чаддаг байна.

## Түр зуурын давуу талын бүтэц

Өрсөлдөхүйц давуу тал ямар төрөл байхаас үл хамааран бүгд нэгэн адил амьдралын мөчлөгөөр явагддаг. Гэхдээ давуу талууд дуусах дөхөх тусам амьдралын мөчлөг нь гол төлөв богинохон байх шаардлагатай

болдог. Тиймээс амьдралын мөчлөг хэрхэн ажилладаг талаар ойлголттой болох нь юу юунаас чухал юм.

Энэхүү мөчлөгийн эхний алхмыг эхлүүлэх үйл явц (launch process) гэж нэрлэдэг. Энэ үе шатанд компанид боломж байгаа эсэхийг олж тогтоох бөгөөд боломж байгаа бол санхүүжилт хийх нөөцийг бэлтгэдэг. Дараагийн алхам бол өгсөх (ramp up) бөгөөд энэ хүрээнд бизнесийн шинэ санаа, оноог арвижуулан нэмэгдүүлдэг байна. Тухайн компани азтай байвал гурав дахь алхам болох ашиглалт (exploitation) руу шилжин ордог. Энэ үйл явцад тухайн компани ашиг, ногдох хувиа олдог бөгөөд энэ нь өрсөлдөгчдийг хариу үйлдэл хийхээс өөр аргагүй байдалд оруулдаг байна.

Өрсөлдөөний гал нэгэнт ноцсон бол давуу тал суларч эхэлдэг бөгөөд дахин тохиргоо хийх (reconfiguration) шаардлагатай болдог. Энэ шатанд компаниуд өөрсдийн давуу талуудыг шинээр тохируулан сэлбэх боломжтой. Гэхдээ зарим тохиолдолд давуу тал огт байхгүй болдог учраас хэрэггүй болсон давуу талаас ангижрах (disengagement) шаардлага гардаг. Үүний дараа мөчлөгийг дахин эхлүүлэх шинэ давуу талыг бий болгох хэрэгтэй болно.

## Гашуун үнэнтэй нүүр тулах

Олон компани давуу талаа суларч буйг үл тоомсорлон улмаар ашиг олох үе шатанд л голлон анхаардаг байна. Ийнхүү сануулга дохиог анзаарахгүй байх нь компаниудыг маш хүнд байдалд оруулах эрсдэлтэй. Түр зуурын давуу тал бүхий үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд компаниуд ▶



шударга үнэлгээ хийлгэхэд бэлэн байх ёстой. Энэ нь нөгөө талаас тухайн компанийг алдаа гаргаж, хүнд байдалд орохоос урьдчилан сэргийлж буй хэрэг юм.

Дараах хэдэн асуултанд үнэн зөвөөр хариулах шаардлагатай. Үүнд: (1) Би өөрийн компанийн бараа, үйлчилгээг худалдаж авдаггүй. (2) Бид адилхан хэмжээний эсхүл илүү хөрөнгө оруулалт хийсэн ч хөрөнгө оруулалтын ашгийн өөрчлөлтийг байхгүй, мөн ашиг нэмэгдэхгүй байгаа. (3) Үйлчлүүлэгчид илүү хямд эсхүл “хангалттай” байх хялбар шийдлийг хайж байна. (4) Бидний тооцоолоогүй газраас өрсөлдөөн гарч ирж байна. (5) Бидний санал болгож буй бараа, үйлчилгээ хэрэглэгчдийн сонирхлыг татахаа больсон. (6) Бидний ажилд авахыг хүсч буй хүмүүсийн хувьд манай компани тэргүүний сонголт биш (7) Манай хамгийн сайн зарим ажилтан ажлаасаа гарах болсон (8) Манай компанийн хувьцааны ханш тогтмол унаж байгаа.

Хэрэв дээрх асуудлуудын дөрөв ба түүнээс дээших нь танай компанийн хувьд биелэлээ олж байгаа бол шинэ давуу талыг хэрэгжүүлэх арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай болсныг сануулж буй маш тодорхой дохио мөн.

## Долоон төрлийн буруу ойлголт буюу сул тал

### Түрүүлж хөдлөгчийн сул тал

Энэ бол тухайн зах зээлд анхдагч байх, өөрийн хөрөнгө нь тогтвортой байдлыг бий болгох тухай ойлголт юм. Энэ байдал ихэнхдээ удаан оршин тогтнодоггүй.

### Бусдаас илүү байхын сул тал:

Олон компани өдийг хүртэл байгуулж, бүтээсэн зүйлсээ сайжруулах хэрэгцээ, шаардлагыг олж харж чаддаггүй. Үүнээс болж компаниуд хүрсэн өндөрлөгөөсөө маш амархан доошилдог байна.

**Чанарын сул тал.** Өндөр чанартай бүтээгдэхүүн сайн шийдэл байж болох ч хэрэглэгчид хямд үнэ, хялбархан саналтай тулгархаараа санаагаа өөрчилдөг.

**Барьцааны нөөцийн сул тал** Гүйцэтгэх захирлууд ихэнхдээ шийдвэр гаргах эрх мэдэлтэй байдаг ч нөөц, боломжийг шинэ хөрөнгө оруулалт болгон хувиргах нь ховор. Энэ байдал удаан үргэлжилбэл өрсөлдөгч компаниуд шинэ (эрсдэлтэй) хөрөнгө оруулалтыг бий болгож, улам олон хэрэглэгчтэй болох бөгөөд энэ нь тухайн компанийг сүйрүүлэх аюултай.

**Олдсон боломжийг алдах сул тал.** Компанийн үйл ажиллагаанд доголдол үүсэхэд бүтэц, зохион байгуулалтаа дахин хийхийн оронд зарим компани бүхэл бүтэн төслийг бүрмөсөн зогсоодог. Энэ нь ашигтай байх боломжит стратегиудыг анзааралгүй өнгөрөхөд хүргэдэг аюултай.

Компани томрохын сул тал: Хөрөнгийн хэмжээ, ажилтнуудын тоо нь өсөн нэмэгдэхийн хэрээр компаниуд нууцлах хадгаламж, нөөц болох хүнд суртал бий болж, улмаар туршилт болон давтан сургалтанд саад болж эхэлдэг байна. Хэдийгээр эдгээр үйлдэл зориуд бус боловч олон ажилтныг үргээдэг.

**Тохиолдлын инновацийн сул тал.** Олон компанийн хувьд инноваци

нь албаны болон хувийн харилцаа холилдсон үйл явц болсон байдаг. Энэ нь бизнесийн мөчлөгт маш тогтворгүй үйл явцыг бий болгодог.


## Түр зуурын давуу талд зориулсан стратеги

1. Үйл ажиллагааны чиглэл бус, үйл ажиллагааны талбарыг анхаарах: Үйл ажиллагааны талбар нь хэрэглэгчдийн сегмент ба санал хүсэлт, тэдний саналыг хүргэх газрыг хослуулсан онцлог талбар юм. Хувьчилсан төрөл, чиглэлд анхаарахаас илүүтэйгээр талбарын талаарх санаа, санаачилгаа орчин үеийн стратегитай хослуулах нь туйлын чухал. Зөвхөн хязгаарлагдмал хүрээнд анхаараад байвал хийх шаардлагатай зүйлсийн талаарх бүрэн зураглал гарч ирэхгүй.

2. Өргөн хүрээг хамарсан сэдэв гаргаж, хүмүүсээр туршуулах: Авьяастай стратегид өөр өөр арга хэрэглэдэг. Тэд өргөн хүрээг хамарсан сэдэв гаргахын тулд холбогдох өгөгдөл, мэдээллийг шинжлэхийн зэрэгцээ эргэн тойрны хэрэглэгчийн зан төлвийн талаарх дэвшилтэт ойлголт, шууд ажиглалт, сулхан дохиог ойлгож мэдэх зэрэг сэдвийг ашигладаг. Эдгээр нь компанийн ажиллах хүчнийг шинээр бүрэлдүүлэх боломжтой шинэ хандлага, загварыг туршиж үзэх эрх чөлөөг хүмүүст олгодог.

3. Хувийн хэвшлийн өсөлтийг дэмжих хэмжүүртэй (metrics) болох: Уламжлалт хэмжүүрүүд (conventional metrics) нь инноваци хийх боломжийг үгүй хийх ямар ч утгагүй дүрэм, журам тогтоох хандлагатай байдаг. Энэ нь аливаа компани тодорхой боломжид хүрэх үест хөрөнгө оруулалтыг дутуу хийх эрсдлийг бий болгодог. Энэ асуудалд бүдрэхгүйн тулд компаниуд авах гэж буй шинэ арга хэмжээгээ үнэлэх “бодит сонголт”-ын логикийг ашиглах боломжтой. Энэ нь цаашид илүү зориулалттай ажиллах эрхийг харуулж буй бөгөөд хүнд сорилт, алдаанаасаа суралцах боломжийг байгууллагад олгож буй хэрэг.

4. Туршлага болон асуудлын шийдэлд анхаарах: Хэрэглэгчид аль ▶



► ч компаниас олж харахыг хүсдэг хамгийн чухал зүйл бол арвин туршлага, асуудлыг шийдвэрлэх цогц шийдэл. Олон компани хэрэглэгчдийн туршлагаас илүүтэйгээр дотооддоо анхаарах хандлагатай байдаг учраас энэ асуудлыг шийдвэрлэхэд амаргүй юм. Түр зуурын давуу талын талаар сайн мэдлэгтэй байгууллагууд өөрсдийгөө хэрэглэгчийн хэтийн төлөвт хаана байлгахгаа сайн мэддэг.

5. Хүчтэй харилцаа болон сүлжээг бий болгох: Хувийн сүлжээ бол түр зуурын давуу талыг эрүүл хадгалах чухал хэсэг юм. Сүлжээ илүү өргөн байхын хэрээр хувьчилсан амжилт тэр хэмжээгээр их байх болно. Хүчтэй харилцааг үүсгэх боломжтой зорилтот бүлэгт хөрөнгө оруулснаар компаниуд өөрсдийн салбартаа нэр хүндтэй болж чадна. Амжилт олж буй олон компаниудын хувьд сүлжээгээ тэлэх чадвар нь бат бөх байдаг.

6. Бүтцийн хэт өөрчлөлтөөс зайлсхийх, хэрэггүй зүйлээс зөв зохистой ангижирч сурах: Компаниуд ямар ч гарз, хохиролгүй учруулалгүйгээр ашиггүй бизнесээс өөрийгөө тусгаарлан салгах арга зам олох чадвартай байх хэрэгтэй. Олон компани бүтцийн өөрчлөлтөө үр ашигтай хийх тал дээр ур чадвар дутмаг байдаг. Нэг нэгээр нь халж, солихын оронд голлох өөрчлөлтийг хийхэд шаардагдах хамгийн шилдэг аргыг олж мэдэх хангалттай хугацааг өөрсөддөө олгох нь илүү ашигтай. Хэрэглэгчийг нэг үйлчилгээнээс нөгөө рүү шилжүүлэх бэлтгэл ажил нь нарийн төвөгтэй үйл явц юм.

7. Анхан шатны инновацийг зохион байгуулалттай явуулах: Аль ч байгууллага инновацийн төсөл хэрэгжүүлэхдээ маш анхааралтай, нарийн зохион байгуулах ёстой. Компаниуд инноваци хийхэд зориулсан засаглалын бүтцийг бий болгох арга замаар үүнийг хэрэгжүүлэх боломжтой юм. Төсөв болон ажилтнуудын асуудлыг хойш тавих нь тухайн компани өөрийгөө бусадтай өрсөлдөх хэцүү байдалд оруулалгүйгээр инноваци хийхэд нь илүү хялбар болгодог байна.

8. Турш, давт, суралц: Адилхан арга барилыг дахин дахин ашиглах нь зайлсхийх ёстой том алдаа юм. Компаниуд гаргасан алдаанаасаа суралцаж, туршлагажих ёстой. Ингэснээр стратегид шаардлагатай, үр өгөөжтэй өөрчлөлтийг хийх боломжийг бүрдүүлэх болно.

## Дүгнэлт





Түр зуурын, үр дүнтэй давуу талыг хэрэгжүүлэхэд манлайлал зайлшгүй шаардлагатай. Үүний тулд компанийн өнөөгийн бодит нөхцөл байдлыг хөндсөн яриа, хэлэлцүүлгийг эхлүүлэх чадвартай манлайлагч байх нь тогтвортой давуу талаа хадгалж үлдэх боломжийг олгодог. Гэхдээ дээр дурдсан алхмууд хэзээ ч өөрчлөгдөхгүй бөгөөд компаниуд дагаж мөрдөх нь зүйтэй. Стратеги нь цаг ямагт юу хийх, юу хийхгүй тухай хүндхэн сонголтуудтай нүүр тулахад хүргэдэг. Цаашид хийх алхмуудаа тодорхойлох нь байгууллагын удирдлагуудын зайлшгүй хийх шаардлагатай зүйл юм. ■

“Harvard Business Review” сэтгүүлээс орчуулав



# НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

Утас:976-70115476



*Bayangol Hotel*  
*Since 1964*